# Дээд боловсролын салбар дахь дижитал шилжилтийн төлөвшлийн загвар



# Агуулга


**4 Төлөвшлийн загварын ерөнхий ойлголт**

**6 Төлөвшлийн түвшингүүд**

**7 Нэр томъёо**

**8 Төлөвшлийн загварын үндсэн ойлголтууд**

**10 Байгууллагын дижитал соёл**

- 12 Дижитал соёл болон сэтгэлгээ
- 22 Байгууллагын дүр төрх
- 26 Байгууллагын сайн сайхан байдал
- 30 Байгууллагын өөрчлөлт

**34 Мэдлэг бүтээх, шинийг санаачлах**

- 36 Дижитал алсын хараа, чиг хандлага тодорхойлох
- 40 Судалгаа
- 52 Шинийг санаачлах
- 56 Өргөн хүрээний нөлөөлөл

**60 Мэдлэг дээшлүүлэх**

- 62 Сургалтын хөтөлбөр боловсруулах
- 78 Дижитал технологи ашиглан суралцах
- 92 Дижитал технологи ашиглан заах
- 102 Суралцагчийн туршлага

**110 Мэдлэгийг удирдах, хэрэглэх**

- 112 Мэдээллийн удирдлага, хэрэглээ
- 122 Өгөгдлийн удирдлага, хэрэглээ
- 130 Бизнесийн оюун (BI)
- 132 Шийдвэр гаргах

**136 Мэдлэг солилцох, түншлэх**

- 138 Харилцаа холбоо
- 144 Хамтын ажиллагаа
- 150 Олон нийтийн оролцоо
- 156 Харилцааны менежмент

**160 Дижитал болон бодит дэд бүтэц**

- 162 Найдвартай дижитал дэд бүтэц
- 176 Дижитал холболт
- 182 Дижитал дэмжлэг
- 186 Эд хөрөнгийн удирдлага

**195 Индекс**


**Энэ файл нь өөр хуудас, вэб сайт руу шилжих боломжтой холбоосууд бүхий интерактив .PDF файл юм**

ТЕКСТ Тайлангийн заасан хэсэг руу эсвэл вэб сайт руу шилжих холбоос

Үндсэн диаграм руу шилжих товч (саарал бол идэвхгүй)

Мастер элементийн диаграм руу шилжих товч (саарал бол идэвхгүй)

Байгууллага өөрийн төлөвшлийн түвшин болон ахицыг сонгох бол Word хувилбарыг энд ээс татан авна уу.

# Төлөвшлийн загварын ерөнхий ойлголт

Дижитал шилжилтэд зориулсан энэхүү төлөвшлийн загвар нь Их Британийн дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг үйл ажиллагааны бүх чиглэлээр өөрсдийн дижитал төлөвшлийг үнэлэхэд нь туслах бүтцээр хангах юм. Инновацийг дэмжих, бизнесийн үйл явц, үйл ажиллагаар оновчтой болгох, хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх боломжоор хангаж, стратегийн алсын хараag тодорхойлох, стратеги төлөвлөлт хийх үйл явцуудыг чиглүүлэх зорилго бүхий Их Британий хамтын мэдээллийн системүүдийн хорооны (ХМСХ буюу Joint information systems committee / Jisc) дижитал шилжилтийн тогтолцоотой энэхүү бүтэц нь бүрэн уялдсан болно.
Багууд дан дангаараа, өөр хоорондоо хамааралгүй мэт ажилласнаас үүдэх төвөгтэй, хуваагдмал байдлыг багасгах хамтарсан багийн аргыг дэвшүүлэн ажиллаж, бодлого, үйл явцаа үүнд хэрхэн уялдуулахын чухлыг энэхүү тогтолцоонд онцолсон байдаг.

Бизнесийн үйл ажиллагааны бүх чиглэлээр дижитал төлөвшлийн түвшингээ тодорхойлохдоо дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд өөрсдийн үзүүлэлтийг салбарын жишиг үзүүлэлтүүдтэй харьцуулж, цаашид урагшлах суурь түвшингээ тогтоох хэрэгтэй. Дижитал төлөвшлийн түвшингээ тодорхойлох нь дижитал шилжилтийн стратеги, хэрэгжүүлэх боломж бүхий төлөвлөгөө зэргийг боловсруулахад нэгэн чухал алхам юм. Төлөвшлийн түвшингээ (6-р хуудсыг харна уу) "сайжруулсан-төлөвшсөн" гэж тодорхойлсон байгууллагуудтай бид хамтран ажиллаж, тэдний сайн туршлагыг судалж, салбар даяар жишээ болгон хуваалцахыг зорьж байна.

Энэхүү загвар нь дижитал шилжилтийг дэмжих багц арга хэрэгслүүдийн нэг бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө/үе шаттай төлөвлөгөөний загвар болон тойм баримт бичигт тусгагдсан болно. Энэхүү загвар нь дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад өөр хоорондоо дижитал шилжилтийн талаар хэлэлцэх, шилдэг туршлагаа байгууллага даяар болон салбарын хүрээнд хуваалцахад нийтлэг ойлголт буюу хэл нь болж өгөх юм.



# Төлөвшлийн түвшин

Энэхүү загвар нь дижитал шилжилтийн тогтолцоонд тодорхойлсон үйл ажиллагааны чиглэл бүрээр үнэлж болох дижитал төлөвшлийн гурван түвшингээс бүрдэнэ.
Төлөвшлийн түвшин ахихад гарах үр ашиг, үр дүнг харуулах зорилгоор дижитал шилжилтийн тогтолцооны бүх чиглэлээр түвшин нэг бүрийг энэхүү загварт тайлбарлан тодорхойлж өгсөн.
Тайлбар тодорхойлолтыг ашиглан байгууллагуудад өөрсдийн түвшинг тодорхойлоход юм. Өмнө дурдсан гурван түвшинг доор жагсаав:

**Идэвхгүй үе шат**

**Эхлэл-Тогтворжсон**
- Стратегийн дижитал манлайлал дутмаг
- Богино хугацааны хөрөнгө оруулалт
- Систем, үйл ажиллагаанууд нэгдмэл бус
- Шинэ санаачлагаар дутмаг
- Оролцогч талуудын өргөн хүрээний ойлголт, оролцоо дутмаг
- Төсөлд суурилсан, нэгдсэн зохион байгуулалтгүй дижитал үйл ажиллагаанууд

**Идэвхтэй үе шат**

**Тогтворжсон-Сайжирсан**
- Стратегийн идэвхтэй хандлагыг хөгжүүлж буй
- Үр дүнтэй дижитал манлайллын бололцоог бүрдүүлж буй
- Систем, үйл ажиллагаагаар нэгтгэх хүчин чармайлт гаргаж буй
- Бүх оролцогч талуудыг татан оролцуулж, ур чадварыг дээшлүүлж буй
- Үйлчилгээ үзүүлэх загвар руу шилжиж буй

**Нэгдсэн үе шат**

**Сайжирсан-Төлөвшсөн**
- Стратегийн цогц, нэгдсэн арга барил
- Үр дүнтэй дижитал манлайлал
- Урт хугацааны, уян хатан төлөвлөлт, хөрөнгө оруулалт
- Нэгдмэл, үр ашигтай систем, үйл ажиллагаа
- Оролцоо өндөр, мэдээллээр хангагдсан, зохих ур чадвартай оролцогч талууд
- Шинэ санаачлалыг хэрэгжүүлэх түншлэлийн аргачлал
- Урт хугацаанд хэрэгжүүлэх загварт суурилсан арга барил (төсөл дээр суурилаагүй)



# Нэр томьёо

Бид дээд боловсролын байгууллагуудын олон талт байдлыг харгалзан "их сургууль" гэхийн оронд "байгууллага" гэсэн үгийг ашиглав.

"Бүх оролцогч тал" гэсэн нэр томьёонд дээд болон дунд шатны удирлага, ажилтнууд, оюутнууд болон төгсөгчид, бизнесийн байгууллага, аж үйлдвэр гэх мэт түншүүдийг багтаасан. Мөн тодорхой оролцогч талуудыг зохих оролцогч тал хэмээн тодорхойлсон. Энэхүү баримт бичигт зарим мэдээллийг дахин давтан (эсвэл сэдэвт нь тохируулан бага зэрэг өөрчилсөн) оруулсан байгаа. Энэ нь зориудын бөгөөд байгууллагын ажилтнууд / багууд ажиллаж буй чиглэлийнхээ мэдээллийг түлхүү анхаарах байх гэж үзээд тухайн чиглэл бүрээр нь мэдээллийг тохируулан оруулж өгсөн юм.

Зарим асуудлууд дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлд чухал байдаг. Үүнд эрх тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо, байгаль орчны тогтвортой байдал зэрэг байгууллагын эрхэм зорилгод тусгагдах гол зарчмууд орно. Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлээр авч үзэх шаардлагатай байж болох бусад асуудлуудад дижитал манлайлал ба засаглал, стратеги төлөвлөлт, зохих хөрөнгө оруулалт, өгөгдлийн аналитик, дижитал соёл ба практик, технологийн шаардлага, ажилтнуудын хөгжил гэх мэт орно. Эдгээр асуудлуудыг энэхүү загварын хэсэг бүрт зохих ёсоор оруулсан болно.

Дижитал шилжилтийн тогтолцоонд ашигласан түлхүүр үгсийг энэхүү төлөвшлийн загварт мөн хэрэглэсэн. Эдгээрийг дижитал шилжилтийн тогтолцооны баримт бичгийн индекс хэсэгт интерактив холбоос байдлаар оруулсан тул энэ хоёр баримт бичгийн хоорондын холбоос болгон ашиглахад дөхөмтэй юм.

# Төлөвшлийн загварын үндсэн ойлголтууд

Дижитал шилжилтийн төлөвшлийн загвар нь дээд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны зургаан үндсэн элементийг голчлон авч үзнэ. Эдгээр гол чиглэлүүдийн төлөвшлийн түвшинг үнэлснээр сайн байгаа болон сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлон гаргаж ирэх боломжтой.

### Байгууллагын дижитал соёл

Дижитал технологийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөх байгууллагын үнэт зүйлс, итгэл үнэмшил, арга барил. Байгууллагын үндсэн стратегиуд, захиргааны бүтэц, үйл явц, үр дүнтэй засаглал, оролцогч талуудын дэмжлэг, хөгжил, оролцоонд анхаарсан дижитал соёл болон манлайллыг (стратеги, төлөвлөлт, хөрөнгө оруулалт) дэмжин чадавхжуулах. Мөн дижитал аюулгүй байдал, дижитал сайн сайхан байдал, нээлттэй байдал, хамтын ажиллагаа, тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо зэрэг асуудалд хандах байгууллагын хандлагыг тодорхойлох, түүнчлэн өөрчлөлтийг хэр сайн хэрэгжүүлж, дасан зохицохыг тодорхойлох хүчин зүйл нь байгууллагын дижитал соёл юм.

- Дижитал соёл болон сэтгэлгээ
- Байгууллагын онцлог
- Байгууллагын сайн сайхан байдал
- Байгууллагын өөрчлөлт

### Мэдлэг бүтээх ба инноваци

Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлд шинээр гарч ирж буй чиг хандлага, хөгжил дэвшилд дүн шинжилгээ хийж бодлого, хөгжлийн стратегийг чухал мэдээллээр хангах. Судалгаа шинжилгээ хийх, хамтын ажиллагаа явуулах замаар мэдлэг бүтээх, шинийг санаачлах үйл явцыг нэмэгдүүлэх. Орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээний өргөн хүрээнд үзүүлэх нөлөөллийг харгалзан авч үзэх.

- Дижитал алсын хараа, чиг хандлага тодорхойлох
- Судалгаа
- Инноваци
- Өргөн хүрээний нөлөөлөл

### Мэдлэг дээшлүүлэх

Бүх оролцогч талуудын дижитал орчинд сурч, ажиллаж, хөгжих нөхцөлийг хангах зорилгоор байгууллагын хүрээнд мэдлэгийг ахиулж, дээшлүүлэх үйл явцыг дэмжих. Дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх арга замыг дахин бодож, сайжруулах.

- Сургалтын хөтөлбөр боловсруулах
- Дижитал хэлбэрээр суралцах
- Дижитал хэлбэрээр заах
- Суралцагчийн туршлага

### Мэдлэгийг удирдах ба хэрэглэх

Судалгаа, сургалтыг дэмжих зорилгоор өгөгдөл, мэдээллийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах. Шийдвэр гаргах явцыг мэдээллээр хангах зорилгоор мэдээлэл, өгөгдлийг нэгтгэх, хадгалах, удирдах, хуваалцах, ашиглах боломжтой болгох.

- Мэдээллийг удирдах ба хэрэглэх
- Өгөгдлийг удирдах ба хэрэглэх
- Бизнесийн оюун
- Шийдвэр гаргах

### Мэдлэг солилцох, түншлэх

Байгууллагын гол чухал мэдээллийг дамжуулах, түгээх, бүх түнш/оролцогч талуудын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор мэдлэг солилцоог сайжруулах.

- Харилцаа холбоо
- Хамтын ажиллагаа
- Олон нийтийн оролцоо
- Харилцааны удирдлага

### Дижитал болон бодит дэд бүтэц

Дижитал технологиор тоноглогдсон орон зай, техник хангамж, програм хангамж, сүлжээ, системүүдэд зохих хөрөнгө оруулах гэх мэт холбогдох мэргэжлийн туршлага, алсын хараан дээр суурилсан бат бөх, найдвартай дэд бүтцийг бий болгож, үр дүнтэй удирдлага, стандарт хэрэгжилтээр хангах

- Найдвартай дижитал дэд бүтэц
- Дижитал холболт
- Дижитал дэмжлэг
- Эд хөрөнгийн удирдлага

# Байгууллагын дижитал соёл

Дижитал технологи ашиглаж эхэлсний нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөх байгууллагын үнэт зүйлс, итгэл үнэмшил, арга барил. Байгууллагын үндсэн стратеги, захиргааны бүтэц болон үйл явц, үр дүнтэй засаглал, оролцогч талуудын дэмжлэг, хөгжил, оролцоонд анхаарсан дижитал соёл болон манлайллыг (стратеги, төлөвлөлт, хөрөнгө оруулалт) дэмжин чадавхжуулах.

Мөн дижитал аюулгүй байдал, дижитал сайн сайхан байдал, нээлттэй байдал, хамтын ажиллагаа, тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо зэрэг асуудалд хандах байгууллагын хандлагыг тодорхойлох, түүнчлэн өөрчлөлтийг хэр сайн хэрэгжүүлж, түүнд дасан зохицохыг тодорхойлох хүчин зүйл нь байгууллагын дижитал соёл юм.



Дижитал соёл болон сэтгэлгээ >>

Байгууллагын дүр төрх >>

Байгууллагын сайн сайхан байдал >>

Байгууллагын өөрчлөлт >>

# Дижитал соёл болон сэтгэлгээ

Дижитал соёл болон сэтгэлгээ гэх ойлголтод хүмүүсийн дижитал технологитой харилцах харилцааг хэлбэржүүлдэг хандлага, зан төлөв, итгэл үнэмшил, дадал хэвшил гэх хүний хүчин зүйлүүдийг, мөн эдгээрийн байгууллагын үйл ажиллагааг хувирган өөрчлөх арга замуудыг хамруулан авч үзнэ. Түүнчлэн шинийг санаачлах, хамтран ажиллах, мэдээлэл солилцох, дижитал контент бүтээх болон ашиглах үйл явцуудад хандах оролцогч талуудын хандлага, эдгээр үйл явц нь хэрхэн оролцогч талуудын ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулж болох талаар авч үзнэ.



## 1 Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцсэн дотоод дижитал соёлыг хөгжүүлж, загварчлах

**Гол чиглэл:**
Дижитал стратеги | Байгууллагын стратеги | Байгууллагын үнэт зүйлс

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Байгууллага доторх дижитал технологи, хэрэгсэл, туршлагыг нэгтгэх, нэвтрүүлэх ажлыг хэсэгчилсэн байдлаар хийсэн. Зарим хэлтэс үйл ажиллагааныхаа үндсэн чиг үүрэгт дижитал технологийг тусгах, хөрөнгө оруулах, хөгжүүлэх стратегийн арга барилыг боловсруулсан.
- Оролцогч талууд дижитал шилжилт хийх стратегийн аргачлалын ашиг тусын талаар нэгдсэн ойлголтгүй.
- Байгууллагын алсын хараа, үнэт зүйлд нийцсэн дижитал стратеги буюу стратегиуд боловсруулахад бүх оролцогч талуудыг татан оролцуулахаар төлөвлөж байгаа.

### Тогтворжсон-Сайжирсан

- Нэгдмэл дижитал соёлыг хөгжүүлэхэд ихээхэн ахиц дэвшил гарсан. Байгууллагын өргөн хүрээний зарчим, алсын хараа, үнэт зүйлсийг хэрэгжүүлэхэд дижитал хөгжил дэвшил томоохон түлхэц үзүүлэх талаарх нийтлэг ойлголтыг дижитал стратегид тодорхой заан тусгасан.
- Стратеги боловсруулахад оролцогч талууд оролцсон бөгөөд байгууллагын нийтлэг дижитал алсын харааг байгууллагын алба, хэлтэс, нэгжүүд өөрсдийн чиг үүрэг, хэрэгцээнд нийцүүлж тусган хэрэгжүүлж байгаа.
- Дижитал гэсэн ойлголтыг үндсэн бүх стратегид тусгасан бөгөөд хэрэгжүүлэлтэд байгууллагын өөр өөр алба, хэлтэс, нэгжүүдийн төлөөллөөс бүрдсэн холимог баг хяналт тавьдаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын зүгээс дижитал соёлыг эрхэм зорилго, үнэт зүйлдээ бүрэн шингээж өгсөн бөгөөд дижитал технологийг байгууллагын үйл ажиллагааны бүх талын салшгүй хэсэг болгож чадсан.
- Тус байгууллага нь дижитал инновацын манлайлагч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дижитал технологийг ашиглан боловсрол, судалгааны ирээдүйг идэвхтэй тодорхойлж байгаа. Төсөлд суурилсан үйл ажиллагааны оронд үйлчилгээнд суурилсан, agile буюу хурдтай арга ашигласан загварыг бүх дижитал хөгжил дэвшлийн үндэс суурь болгосон.
- Байгууллага дотроо болон гадны түншүүдтэй хамтран ажиллах, шинийг санаачлах, мэдлэг хуваалцах соёлыг гүнзгий нэвтрүүлсэн.

## 2 Тогтвортой байдлыг эрхэмлэсэн зан төлөв, сэтгэлгээг суулгах

**Гол чиглэл:**

Байгаль орчны тогтвортой байдал | Байгууллагын үнэт зүйлс

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Оролцогч талуудыг дижитал технологи ашиглаж байхдаа тогтвортой хөгжлийг эрхэмлэсэн зан төлөв, сэтгэлгээгээр хандахыг уриалдаг.
- Дижитал үйл ажиллагааны нүүрстөрөгчийн ул мөр, экологид үзүүлэх нөлөөллийг багасгах (жишээ нь, эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж ашиглах, шаардлагагүй зүйл хэвлэхгүй байх, хариуцлагатай мэдээллийн удирдлагын туршлагыг нэвтрүүлэх гэх мэт) практикийг дэмждэг.
- Тогтвортой байдалд тулгарч буй сорилтуудын талаарх мэдлэгийг дээшлүүлж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжсэн дижитал контентыг бий болгох, ашиглахыг байгууллага даяар, ялангуяа дотоод болон гадаад харилцааны хүрээнд уриалан дэмждэг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Тогтвортой байдал нь байгууллагын соёлын салшгүй нэг хэсэг болсон. Тогтвортой байдлыг эрхэмлэсэн дижитал дадал хэвшлийг байгууллагын үнэт зүйл, бодлого, журамд нэгтгэсэн. Тогтвортой байдлыг эрхэмлэсэн дижитал дадал хэвшилд анхааран ажиллах ажлын хэсэг буюу холимог багийг (өөр өөр алба, хэлтэс, нэгжийн төлөөллүүдээс бүрдсэн) байгуулсан.
- Оролцогч талуудыг дижитал тогтвортой байдалтай холбоотой амжилтын түүх, сургамж, шинэлэг санаагаа хуваалцахыг урамшуулан хариуцлагатай, тууштай байдлыг дэмждэг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь шинэлэг шийдлүүдийг хэрэгжүүлээд зогсохгүй дижитал тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцон үлгэр жишээ үзүүлж, салбарын хэмжээнд өөрчлөлт оруулахад нөлөөлдөг
- Тогтвортой дижитал шийдлүүдийн судалгаа, хөгжилд зориулж нөөц хуваарилах замаар тасралтгүй суралцах, тасралтгүй шинийг санаачлах соёлыг төлөвшүүлсэн.
- Тогтвортой хөгжлийн ур чадвар, туршлага, мэдлэгээ бусдад урам зориг өгөх, эерэг өөрчлөлтийг бий болгох зорилгоор хэвлэн нийтлүүлэх, чуулганд оролцох зэрэг сэтгэлгээний манлайллын үйл ажиллагаанд оролцох замаар байгууллага дотроо болон байгууллагаас гадагш аль алинд нь хуваалцдаг.



## 3 Үр дүнтэй дижитал манлайлал

**Гол чиглэл:** Дижитал манлайлал | Засаглал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал манлайллын ач холбогдлын талаарх ойлголт нэмэгдэн, сайжирч байгаа боловч дунд шатны удирдах ажилтнуудад дижитал манлайллын ур чадвар, туршлагыг бий болгох албан ёсны сургалт, хөгжлийн боломж цөөн (эсвэл огт байхгүй). Зарим дунд шатны удирах ажилтнууд дижитал шилжилтийн стратегид хувь нэмрээ оруулах чадваргүй, өөртөө итгэлгүй байдаг. Дижитал санаачилгыг хэрэгжүүлэх түр зуурын хүчин чармайлт нь уялдаа холбоогүй байх хандлагатай.
- Дунд шатны удирлага дижитал гүйцэтгэлийн хувьд хариуцлага хүлээхгүй байж болдог ба сайн туршлагыг үлгэрлэн харуулахад бага ач холбогдол өгдөг.
- Бүх ахлах менежер үлгэр дуурайл үзүүлэхдээ итгэлтэй бус байгаа хэдий ч дижитал шинийг санаачлагчид, дижитал манлайлагчид удирдлагын түвшний санхүүжилт авсан байдаг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал манлайллын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, энэ чиглэлээр ахлах удирдагчдыг дэмжих алхмууд хийгдэж байгаа. Дижитал манлайллын талаар дунд шатны удирдах зориулсан албан ёсны сургалт, хөгжлийн тодорхой зарим боломжууд байгаа. Дунд шатны удирлах ажилтнууд улам бүр дижитал шилжилтийн стратегийн алсын хараанд хувь нэмрээ оруулж чадахаар болж байна.
- Дунд шатны удирлагууд сайн туршлагыг үлгэрлэн харуулах хэрэгтэй бөгөөд дижитал гүйцэтгэлд хариуцлага хүлээж болно. Байгууллага даяар дижитал санаачлагуудыг зохицуулж, инновацыг дэмжих хүчин чармайлт гаргаж байгаа.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Үр дүнтэй дижитал манлайллыг сайшааж, урамшуулдаг. дунд шатны удирлагууд, байгууллагын удирдлагуудад дижитал туршлагаа сайжруулах сургалт, хөгжлийн цогц хөтөлбөр, боломжууд бий.
- Дунд шатны удирах ажилтнууд дижитал гүйцэтгэлийн үр дүнд хариуцлага хүлээдэг бөгөөд байгууллагын хэмжээнд сайн туршлагыг үлгэрлэн харуулах шаардлагатай.
- Тасралтгүй сурч, хөгжих соёл бий болж, тогтсон. Бүх ажилтанд дижитал манлайллын ур чадвараа хөгжүүлэх боломж олгох замаар дижитал инновац болон хамтын ажиллагаа дэмжинэ.

## 4 Байгууллагын дижитал соёл нь тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоог дэмждэг байх

**Гол чиглэл:**
Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Байгууллагын үнэт зүйлс

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Дижитал тэгш байдал, олон янз байдал, тэгш оролцооны ач холбогдлыг стратегийн баримт бичигт хүлээн зөвшөөрсөн.
  Олон өөр оролцогч талын хэрэгцээ, шаардлагуудын талаар хязгаарлагдмал мэдлэг байгаа хэдий ч байгууллагын хэмжээнд шийдвэрлэх тодорхой төлөвлөгөө байхгүй.
- Асуудал гарсан талаар мэдэгдсэн тохиолдолд хариу үйлдэл үзүүлэх замаар үйлчилгээ үзүүлж, ажилладаг.
- Оюутнууд болон ажилтнуудын дижитал хандалт, ашиглалтын талаарх өгөгдлийг цуглуулдаг боловч аливаа зөрүүг арилгах стратегийн аргачлалгүй.
- Ашиглагдаж буй дижитал процесс, систем, үйлчилгээний зүгээс үйл ажиллагаанд оролцох, суралцах, ажиллахад саад тотгор учруулахгүй байхад тус байгууллага анхаарч ажилладаг.
- Холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн талаарх мэдээллийг байгууллагын вэбсайтаас авах боломжтой (жишээ нь, "Тэгш байдлын тухай хууль 2010, хүртээмжтэй байдлын журам"). Вэб хөтчөөр дамжуулж буй контент нь хүртээмжтэй байдлын журмын дагуу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүртээмжтэй байдлын стандартад нийцсэн. Тус байгууллага нь хүртээмжтэй байдлын журмын шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй байдлын талаарх мэдэгдлийг сүүлийн үеийн байдлаар шинэчлэн нийтэлсэн.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал тэгш байдал, олон янз байдал, тэгш оролцооны үнэ цэнийг таниулан сурталчлахад ихээхэн ахиц дэвшил гарсан.
- Дижитал ялгаатай байдлыг (жишээ нь, хувь хүний хэрэгцээ, чадавх болон нөөц, сүлжээ, тоног төхөөрөмжийн хүртээмжтэй холбоотой) тусган, шийдвэрлэх стратегийг үнэлэх, сайжруулах зорилгоор оролцогч талуудтай тогтмол зөвлөлдөн, хэлэлцдэг.
- Тэгш хүртээмж, тэгш оролцооны зарчмуудыг шинэ ажилтан, шинэ оюутанд зориулсан ажлын байр, сургалтын орчныг танилцуулах сургалт дээр заан ойлгуулдаг бөгөөд дижитал орчинд тэгш оролцоог хангасан буюу бүгдэд адил тэгш хандах зан үйлийг дэмжих удирдамж гаргасан.
- Шинээр элсэн суралцагч ба/буюу шинэ ажилтнуудын хувьд суралцах/ажиллах үед нь тулгардаг бэрхшээл, сорилтуудыг сургалтын орчин/ажлын байрыг танилцуулах сургалтаар тодорхойлж, нөхцөлийг бүрдүүлэн, дэмждэг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал тэгш байдал, олон янз байдал, тэгш оролцоог дэмжихтэй холбоотой цогц, нэгдсэн стратеги хэрэгжүүлсэн нь бизнесийн бүх үйл ажиллагаа, үйлчилгээнд илт тодорхой харагдана. Байгууллагын зүгээс бүтцийн саад тотгорыг арилгах, бүх оюутан, ажилтнуудад адил тэгш, хүртээмжтэй дижитал орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа.
- Бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд нь тусгалаа олсон тэгш оролцооны соёлыг байгууллага даяар бий болгосон. Өдөр тутмын үйл хэргээрээ тэгш оролцоог хэрхэн дэмжиж, үлгэрлэн манлайлах талаар оролцогч талууд нэгдсэн нэг алсын хараа, ойлголттой.
- Зөвхөн технологи, агуулга, дүрэм журамд төвлөрөлгүйгээр хүртээмжтэй байдлын бүх талын ойлголт, мэдлэг өргөн хүрээг хамарсан (жишээ нь, хүртээмжтэй байдлаар заах болон үнэлэх арга зүй, уян хатан бодит болон дижитал орон зай, уян хатан ажлын зохион байгуулалт, хэлний зөв хэрэглээ, нийгмийн болон харилцааны хүртээмжтэй арга хэлбэрүүд).

## 5. Оролцогч талуудын дижитал чадавх

**Гол чиглэл:**

Дижитал манлайлал | Дижитал цогц чадвар | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Бүх оролцогч талын хувьд дижитал чадавх чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа боловч үүнийг суралцах, заах, үнэлэх болон ажилтан сонгон шалгаруулах, хөгжүүлэх, дүгнэх үйл явцад хараахан тусгаагүй.
- Дижитал чадавхыг хөгжүүлэхэд дөхөм болох зарим нөөц бололцоо байгаа боловч бүх багш, ажилтан, оюутнуудад ямар дижитал чадавх шаардлагатай талаар ойлголт дутмаг.
- Дижитал чадавхын асуудлыг ганц, хоёр хэлтсийн үүрэг гэж үздэг.
- Зарим тодорхой ажлын байр, чиг үүрэгт шаардагдах дижитал чадавхыг тодорхойлох ажил эхэлсэн бөгөөд зарим стандарт дижитал чадавхыг ажлын байрны тодорхойлолт, ажил горилогчид тавигдах шаардлагад оруулсан байгаа.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Бүх ажилтан, оюутнуудад зориулсан дижитал чадавхын стратегийн төлөвлөгөөг боловсруулсан. Байгууллага нь дижитал чадавхыг өөрийн үйл ажиллагаа, соёлд нэвтрүүлэхээр идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд ингэснээр шинэ ажилтны сонгон шалгаруулалт болон чиглүүлэх сургалт, ажилтны сургалт, хөгжилд нөлөөлөх болсон ба сургалтын хөтөлбөр боловсруулахад мөн нөлөөлж эхэлсэн.
- Тус байгууллага нь дотооддоо олон янзын сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд явуулдаг бөгөөд ажилтнууд болон оюутнууддаа дижитал чадавхаа батлан харуулах боломжтой албан ёсны гэрчилгээ олгох хөтөлбөрүүдийг танилцуулан, чиглүүлж өгдөг.
- Ажилтнууд болон оюутнуудад өөрсдийн дижитал чадавх, өөртөө итгэх итгэлийн түвшинг үнэлэх боломж олгож, дэмжлэг үзүүлдэг. Ажилтны үнэлгээг хийхдээ дижитал чадавхыг харгалзан авч үздэг, мөн тухайн ажилтанд чиглэсэн сургалт, хөгжлийн боломжийг санал болгодог.
- Тухайн ажил үүрэгт шаардагдах ур чадварын салбараас гаргасан тодорхойлолт ба / буюу мэргэжлийн онцлогтой тогтолцоо зэргийг ашиглан янз бүрийн ажил үүрэг, түвшингүүдэд шаардагдах дижитал чадавхыг тодорхойлдог бөгөөд байгууллагын хэмжээнд дижитал чадавхыг бий болгох тогтолцоо эсвэл үе шаттай төлөвлөгөөг боловсруулсан.



### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын бүх үйл ажиллагаа, бодлого зохицуулалтад дижитал чадавхын соёлыг нэвтрүүлсэн. Ажилтныг ажилд авах, сонгох, шинээр сургах, үнэлэх, урамшуулах журамд дижитал чадавхын ойлголт бүрэн шингэсэн.
- Дижитал чадавхыг мэргэжлийн болон ажил мэргэжлийн шаардлагад нийцүүлэн бүх сургалтанд тусган оруулсан.
- Тус байгууллага нь дижитал чадавхыг хөгжүүлэх чиглэлээр манлайлагч хэмээн танигдсан бөгөөд шинэлэг хөтөлбөр, санаачлага хэрэгжүүлдгээрээ нэр алдар нь түгсэн. Байгууллага нь дижитал чадавхыг хөгжүүлэхийн тулд салбарын бусад байгууллага, түншүүдтэй хамтран ажиллаж байж болно.
- Одоо байгаа болон шинээр үүсгэсэн бүх ажил үүрэгт шаардагдах дижитал чадавхын шаардлагуудыг тогтмол хянаж, сургалт болон хөгжлийн хөтөлбөрүүдийг зохих ёсоор өөрчлөн шинэчилдэг.
- Өндөр мэргэшсэн ажил үүрэг, дижитал ур чадвар бүхий хүмүүсийг зохих ёсоор түр болон байнгын ажилд авдаг.

## 6 Шинийг санаачлах, шинийг турших соёл бий болгох, дэмжих

**Гол чиглэл:**
Дижитал инновац| Дижитал манлайлал | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагын шинийг санаачлах тохиолдлууд нь салангид, уялдаа холбоогүй бөгөөд эдгээрийг дэмжиж, урамшуулах албан ёсны бүтэц, үйл явц байхгүй.
- Дунд шатны удирдах ажилтнууд шинийг санаачлах буюу инновацын соёлыг сурталчлах ажилд идэвхтэй оролцоггүй, шинийг турших, эрсдэл хүлээхэд бага ач холбогдол өгдөг. Шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэхэд уламжлалт арга, үйл явцыг илүүд үздэг. Тусгаарлагдсан, төсөлд суурилсан үйл ажиллагаанууд байгууллага даяар явагддаг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Шинийг санаачлах, шинээр турших соёлыг төлөвшүүлж, хөгжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн. Инновацын лаборатори, инкубатор зэрэг инновац буюу шинэ санаачилгыг дэмжих албан ёсны зарим нэг бүтэц байгаа ба дунд шатны удирдах ажилтнуудын зүгээс шинээр турших соёлыг идэвхтэй сурталчилж эхэлсэн.
- Тус байгууллага нь инновацыг дэмжих шинэ технологи, процессод хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд байгууллагын өөр өөр албан тушаал, чиг үүрэг бүхий ажилтнууд хамтран ажиллаж, санаа бодлоо хуваалцахыг тууштай дэмждэг. Өөрчлөлт хийхэд зарим нэг эсэргүүцэл байсаар байгаа бөгөөд шинийг турших албан ёсны процессууд хангалтгүй.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллага даяар шинийг санаачлах, шинээр турших соёл илт тодорхой явагдаж байгаа. Инновацыг дэмжих албан ёсны бүтэц, процессууд бий. Дунд шатны удирдах ажилтнууд шинээр турших соёлыг сурталчилж, үлгэрлэн харуулахад идэвхтэй оролцдог.
- Эрсдэл хүлээх гэсэн ойлголтыг дэмждэг, бүтэлгүйтэл нь суралцах, өсөж хөгжих боломж гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Тасралтгүй сайжруулах, шинэ технологи, процессыг зохих ёсоор нэвтрүүлэхэд анхаарч байгаа. Тус байгууллага нь судалгаа, хөгжилд идэвхтэй хөрөнгө оруулж, дэмжиж ажилладаг бөгөөд байгууллагын өөр өөр албан тушаал, чиг үүрэг бүхий ажилтнууд хамтран ажиллаж, санаа бодлоо хуваалцах соёл гүнзгий нэвтэрсэн.
- Шинэ систем, үйл ажиллагаа, үйлчилгээг хөгжүүлэх зорилго бүхий "дижитал дизайнтай" аргачлал нь ажил явуулах уламжлалт арга хэрэгсэл, зан байдлаа илүүд үзэж, бахь байдгаараа байх гэсэн сэтгэлгээг арилгахыг эрмэлзэнэ (илүү тохиромжтой гэсэн нөхцөлд уламжлалт, дижитал бус аргачлалыг солих шаардлагагүй).



# Байгууллагын дүр төрх

Байгууллагын дүр төрх гэдэг нь байгууллагыг тодорхойлж, бусдаас ялган харуулдаг өвөрмөц онцлог, чанарууд юм. Байгууллагын стратегийн зарчим, үнэт зүйлсийг таниулан, сурталчлахыг дэмжих дижитал үйл ажиллагаануудыг, мөн эдгээр нь хэрхэн бизнесийн арга барилд тусгалаа олж, оролцогч талуудад нөлөөлөх талаар авч үзнэ.



## 7 Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг тусгасан дижитал дүр төрхийг бий болгох, сурталчлах

**Гол чиглэл:**
Маркетинг, харилцаа холбоо | Дижитал бүлэг үүсгэх | Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагынхаа эрхэм зорилго, үнэт зүйлсийг вэбсайт болон нийгмийн сүлжээний сувгуудаа тодорхой оруулсан. Бүх төрлийн харилцаа холбоо, хэвлэл нийтлэлд ашиглахад зориулан брэндийн удирдамж гаргасан.
- Дижитал сувгуудын гүйцэтгэлийг хэмжихдээ энгийн аналитик хэрэгсэл ашигладаг. Байгууллагын албан ёсны дижитал сувгууд тэгш хүртээмжийн заавар, зөвлөмжийг дагаж мөрддөг боловч гадагшаа болон дотогшоо чиглэсэн зарим контент нь брэндийн болон тэгш хүртээмжийн шаардлагад нийцээгүй.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Бүх дижитал сувгууд дээрээ өөрийн гэсэн, өвөрмөц дижитал дүр төрхийг үүсгэн оруулсан. Байгууллагын вэбсайт нь сайн дизайнтай, хэрэглэхэд хялбар, нийгмийн сүлжээний сувгууд нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд байгууллагын брэнд номонд заасны дагуу, мөн тэгш хүртээмжийн шаардлагад нийцүүлэн байгууллагын брэнд, дүр төрхийг нэгэн жигд, зохистойгоор ашиглаж, дэмжихийг бүх ажилтан, оюутнуудаа уриалдаг.
- Дижитал сувгуудын гүйцэтгэлийг хэмжихдээ ахисан түвшний аналитик хэрэгсэл ашигладаг бөгөөд өгөгдөл дээр суурилан дижитал маркетинг, харилцаа холбооны стратегиудыг чиглүүлдэг.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллага нь шилдэг ажилтан, оюутнуудыг татах, элсүүлэх, олон улсын хэмжээнд нэр хүндээ өсгөхдөө өөрийн дижитал дүр төрхийг өсөлт, амжилтын гол хөшүүрэг болгон ашиглаж байгаа.
- Дижитал маркетингийн шинэлэг, үр дүнтэй стратегиуд хэрэгжүүлснээр байгууллагын дүр төрхийг бүх сувгаар нэгэн жигд түгээдэг бөгөөд байгууллага нь олон нийттэй харилцах, дижитал хүрээлэл (жишээлбэл, төгсөгчдийн сүлжээ, судалгааны бүлгүүд, үйлдвэрлэл, бизнес) бий болгохын тулд дэвшилтэт технологиуд ашиглаж байгаа.
- Өөр өөр бүлгүүдэд чиглэсэн дижитал туршлагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өгөгдлийн аналитик болон машин сургалтыг ашигладаг бөгөөд хэрэглэгчийн туршлагыг сайжруулах үүднээс зарим контентыг (жишээ нь, оюутны хотхоны аялал) виртуал болон өргөтгөсөн бодит байдал ашиглан үзүүлдэг.

# 8 Ажилтнууд болон оюутнуудын дижитал дүр төрх

**Гол чиглэл:**

Дижитал чадавх | Дижитал цогц чадвар

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Дунд шатны удирдах ажилтнууд, ажилтнууд болон оюутнуудад дижитал дүр төрхөө эерэг байдлаар хөгжүүлэхэд зориулсан албан ёсны дэмжлэг эсвэл нөөц хязгаарлагдмал.
- Дижитал ур чадварын сургалт, мэргэжил дээшлүүлэх боломжуудад дижитал дүр төрхийн талаарх мэдлэгийг агуулсан бөгөөд ажилтнууд болон оюутнуудад онлайн орчинд аюулгүй байх талаар ерөнхий дэмжлэг, удирдамжийг санал болгодог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллагын зүгээс ажилтнууд болон оюутнуудад дижитал дүр төрх, онлайн зан төлөвөө удирдан, зохицуулахад нь тохирсон дэмжлэг, зөвлөмжийг санал болгодог. Хувийн дижитал дүр төрхийг эерэг хэлбэрээр хөгжүүлэхийг дэмжих бодлого, удирдамж боловсруулсан.
- Эерэг дижитал дүр төрх хөгжүүлэх зорилгоор дижитал хэрэгсэл, технологи ашиглахыг дэмждэг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал дүр төрх, онлайн зан төлөвтэй холбоотой асуудлуудыг бүх ажилтан, оюутнуудын хувийн хөгжлийн төлөвлөгөөнд, мөн тэдгээрийг удирдах процессуудад тусган оруулж өгсөн. Ажилтнууд мэргэжлийн дижитал дүр төрхөө байнга хөгжүүлдэг.
- Оюутнууд суралцах хугацааныхаа туршид мэргэжлийн дижитал дүр төрхөө идэвхтэй хөгжүүлдэг.
- Оюутнууд болон ажилтнууд янз бүрийн нөхцөлд хүлээн зөвшөөрөгдөх дижитал зан үйлийн удирдамж, протоколыг хамтран бүтээсэн.





# Байгууллагын сайн сайхан байдал

Бүх оролцогч талуудын бие бялдар, сэтгэл санааны болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангах, дэмжих, сайжруулах. Дижитал технологиор дамжуулан ажиллаж, амьдарч, суралцах, түүнчлэн хувь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулж, удирдахад дижитал аргачлал нэвтрүүлэх зэрэгт үзүүлэх нөлөөллийг оруулан авч үзнэ.



## 9 Дижитал сайн сайхан байдлын стратегийн аргачлал

**Гол чиглэл:**
Дижитал сайн сайхан байдал | Уян хатан ажлын байр | Кибер аюулгүй байдал | Ажилд авах, ажилд үлдээх | Байгаль орчны тогтвортой байдал | Дижитал цогц чадвар | Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Эдийн засаг/ Санхүүгийн боловсрол

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Сайн сайхан байдлын бодлого, дэмжлэг нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд төвлөрдөг бөгөөд дижитал сайн сайхан байдлын тухай ойлголтыг тусгайлан ойлгож, шийдвэрлэдэггүй. Ажилтны сайн сайхан байдлын асуудлыг хүний нөөцийн баг хариуцдаг. Оюутны сайн сайхан байдлын асуудлыг оюутныг дэмжих баг хариуцдаг. Байгууллагын эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого нь дижитал сайн сайхан байдлын эргономикийн асуудал дээр төвлөрдөг.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал сайн сайхан байдлын асуудлуудыг байгууллагын бодлого, удирдамжид маш сайн тодорхойлон, тусгасан. Ажиллаж, суралцахдаа дижитал технологи ашиглах үйл явц нь бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй байхад анхаарч ажилтнууд болон оюутнуудад зохих дэмжлэг үзүүлдэг.
- Бүх оролцогч талуудын дижитал ур чадвар, чадавхыг сайжруулах боломжуудад дижитал сайн сайхан байдлыг сайжруулах арга замуудыг багтаан авч үздэг.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал сайн сайхан байдал нь байгууллагын хүн бүрийн үүрэг хариуцлага бөгөөд албан ёсны дэмжлэг, туслалцааг байгууллагын стратеги, үйл ажиллагаа, соёлд уялдуулж, нэвтрүүлсэн. Шинэ ажилтны бүх сургалтад дижитал сайн сайхан байдлыг тусган оруулсан бөгөөд бүх оролцогч талууд дижитал технологийн бие махбод, сэтгэл санаа болон сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бие даан үнэлэх боломжтой.
- Байгууллагын зүгээс сөрөг нөлөөллийг бууруулахад дэмжлэг үзүүлж, сайн сайхан байдлаа сайжруулахдаа технологийг хамгийн сайнаар ашиглахад нь хүмүүст туслах зорилгоор хөрөнгө оруулалт хийдэг (сургалт, зөвлөгөө, зааварчилгаа, туслах технологи ашиглах гэх зэрэг).
- Дижитал сайн сайхан байдлыг өөр өөр нөхцөл байдалд тохируулан сургалтын хөтөлбөрийн дизайнд тусгасан.
- Асуудал тодорхойлох, шийдэл олохдоо өгөгдлийн аналитик болон түүний үр дүнг зохих ёсоор ашигладаг.

## 10 Оролцогч талуудын өөр өөр хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэн ажиллах, суралцах уян хатан хандлагыг нэвтрүүлэх.

**Гол чиглэл:**
Дижитал сайн сайхан байдал | Уян хатан ажлын байр |
Ажилд авах, ажилд үлдээх | Тэгш хүртээмж, тэгш оролцоо

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Уян хатан ажиллах, сурах зохицуулалтыг уялдаа холбоо бүхий байгууллагын стратеги, алсын хараагүйгээр, тухайн тохиолдлоор хэрэгжүүлдэг.
- Үндсэн бодлого, зохицуулалтаараа зарим тохиолдолд зайнаас ажиллах эсвэл хувийн нөхцөл байдалд тохируулан зохицуулалт хийх гэх мэт уян хатан хэлбэрээр ажиллаж, суралцахыг дэмждэг.
- Тус байгууллагад компьютер, сургалтын орон зай, интернет холболт, алсаас нэвтрэхэд шаардлагатай програм хангамж зэрэг уян хатан хэлбэрээр ажиллаж, суралцах боломжийг дэмжих зарим нэг дэд бүтэц бий.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Ажил, амьдралын тэнцвэртэй байдал, сайн сайхан байдлыг дэмжих стратегийн чанартай үүрэг, амлалт байгаа. Уян хатан ажиллаж, суралцах боломжуудаас сонгоход нь ажилтнууд, оюутнуудад туслах сургалт болон нөөц бололцоогоор хангах, тусламж үзүүлэх тусгай ажилтнуудаар хангах зэргээр байнгын дэмжлэг үзүүлдэг.
- Уян хатан ажиллаж, суралцах орон зайн асуудлаар цогц бодлого, дэмжлэгийн системүүд байгаа. Цагаар ажиллах, ажил хувааж хийх, уян хатан цагаар ажиллах, холимог хэлбэрээр сурах зэрэг сонголтуудтай.
- Сайжруулсан мэдээллийн технологийн систем, алсын зайнаас нэвтрэх шийдэл, өөр төрлийн суралцах орон зай, хамтын ажиллагааны хэрэгслүүд зэрэг бодит болон дижитал дэд бүтцийг ашиглан уян хатан ажиллах, суралцах үйл явцыг дэмждэг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын бүх гишүүдийн ажил амьдралын тэнцвэртэй байдал, сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий, тасралтгүй шинийг санаачлах, сайжруулах үйл явцыг дэмждэг, өөрчлөн шинэчлэх боломж бүхий уян хатан ажиллах, суралцах стратегиуд. Багш, ажилтан, оюутнууд уян хатан ажиллах, суралцах сонголтоо хийх бүрэн чадвартайгаас гадна уян хатан байдалтай холбоотой бодлого, хэрэгсэл, туршлагыг хөгжүүлж, сайжруулахад идэвхтэй хувь нэмэр оруулдаг.
- Уян хатан хэлбэрээр ажиллах, суралцах нь байгууллагын соёл, үнэт зүйлсийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олон төрлийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлсэн өргөн сонголттой. Багш, ажилтан, оюутны тухайлсан хэрэгцээнд тохируулан уян хатан ажиллах, суралцах олон төрлийн сонголтуудыг цогц бодлогоор дэмждэг.
- Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлд уян хатан ажиллаж, суралцах орон зай, багаж хэрэгсэл, платформуудыг нэгэн жигд нэгтгэн уялдуулж өгсөн дэд бүтэцтэй.

# Байгууллагын өөрчлөлт

Дижитал шилжилтийн үйл ажиллагааны үр нөлөөг урьдчилан таамаглах, удирдах, хариу арга хэмжээ авах. Төлөвлөсөн санаачлагууд, үйл ажиллагаадаар дамжуулан оролцогч талуудыг арга барил, хүлээлт шаардлага, хандлагаа өөрчлөхөд нь дэмжиж туслах.



## 11 Дижитал шилжилтийг манлайлан, идэвхжүүлэх

**Гол чиглэл:**
Дижитал стратеги | Дижитал манлайлал | Үйл ажиллагааны өөрчлөлт | Засаглал | Байгууллагын стратеги

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●–○–○ Эхлэл-Тогтворжсон**

- Дунд шатны удирдах ажилтнууд болон удирдлагууд дижитал технологийн хувиран өөрчлөгдөх мөн чанарыг ойлгодог бөгөөд стратеги боловсруулахад манлайлан оролцох дижитал удирдагч, манлайлагчдыг тодорхойлсон.
- Дижитал шилжилтийн нэгдсэн стратеги боловсруулах ажил эхэлсэн. Байгууллагын зүгээс зарим нэг жишиг судалгаа, харьцуулалт, дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны бүх чиглэлээр төлөвшлийн түвшин, ирээдүйн хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг гаргаж байгаа.
- Дижитал шилжилтэд хамгийн их нөлөө үзүүлэх бизнесийн зарим гол үйл ажиллагаа, системүүдэд хөрөнгө оруулахаар тэргүүлэх ач холбогдол өгсөн.
- Дунд шатны удирдлагуудад дижитал манлайллын ур чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж байгаа.

**○–●–○ Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал шилжилтийн стратегийг боловсруулсан (эсвэл бүх стратегийг дижитал шилжилт хийхэд нийцүүлсэн). Стратегийг боловсруулахад бүх оролцогч талууд оролцож, зорилго, эрмэлзлийн талаар нэгдсэн ойлголттой болсон.
- Дунд шатны удирдлагууд, удирдлагууд богино, дунд, урт хугацааны нөөц хуваарилалтад зориулж хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гаргасан.
- Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд хүрч болохуйц зорилтууд, гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд, тэргүүлэх чиглэлүүд, хариуцсан эздийг тодорхойлсон ба уг төлөвлөгөөг алба, хэлтсийн төлөвлөгөөг чиглүүлэхэд ашиглаж байгаа.

**○–○–● Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь дижитал шилжилтийн стратеги, хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж байгаа. Дижитал шилжилт хийхдээ цогц аргачлал ашиглаж, хамтын ажиллагаа, хамтын өмчлөлийг дэмжих үүднээс алба, хэлтэс, нэгжийн төлөөллүүдээс бүрдсэн холимог бүлгүүдийг үүсгэсэн.
- Байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр гаргах процессуудын бүх чиглэлд дижитал технологиудыг нэгтгэсэн тул дижитал шилжилтийг богино хугацаанд хэрэгжүүлж чадах нь тодорхой. Стратеги, төлөвлөгөөнүүдийг сүүлийн үеийн дижитал чиг хандлага, шилдэг туршлагуудтай мөр зэрэгцүүлэн тасралтгүй хянан, шинэчилж байгаа.
- Тус байгууллага нь дээд боловсролын салбартаа дижитал инновацын тэргүүн эгнээнд байдаг. Дижитал технологийн хүрээнд тасралтгүй суралцан, хөгжих соёл тогтсон бөгөөд удирдагчид нь дараагийн үеийн дижитал удирдагчдыг сургаж, дасгалжуулах ажилд идэвхтэй оролцдог.
- Дижитал өөрчлөлтөд бүтээлч хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд инновацыг урамшуулах, эрсдэлийг хүлээн зөвшөөрөх соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудыг дэмжих, шинэлэг арга барилыг үлгэрлэх зэрэг орно.





# Мэдлэг бүтээх, шинийг санаачлах

Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлд шинээр гарч ирж буй чиг хандлага, хөгжил дэвшлийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бодлого, хөгжлийн стратеги боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах. Судалгаа шинжилгээ хийх, хамтын ажиллагаа явуулах замаар мэдлэг бүтээх, шинийг санаачлах үйл явцыг нэмэгдүүлэх. Орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээнийөргөн хүрээнд үзүүлэх нөлөөллийг харгалзан авч үзэх



# Дижитал алсын хараа, чиг хандлага тодорхойлох

Салбарын болоод байгууллагын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаанд одоогийн болон ирээдүйн дижитал чиг хандлагын үзүүлэх нөлөөллийг урьдчилан харж, бэлтгэх. Стратеги төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явцыг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор дээд шатны удирдах ажилтнуудад ирээдүйг урьдчилан таамаглахад шаардагдах мэдээлэл цуглуулах, олж авах боломжоор хангах.



## 12 Ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, шийдвэр гаргалтыг чиглүүлэх

**Гол чиглэл:**
Чиг хандлага тодорхойлох | Дижитал алсын хараа | Жишиг тогтоох | Урьдчилан харах Дижитал манлайлал | Дижитал бүтээлч байдал | Ирээдүйн хувилбарт таамаг | Салбарын чиг хандлага | Аж үйлдвэрийн чиг хандлага | Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Жишиг үнэлгээг мэргэжилтнүүд, шинжээчид явуулах ба үр дүнг голчлон тухайн байгууллагын холбогдох хүмүүс сонирхон, ажигладаг. Жишиг үнэлгээ нь стратеги төлөвлөлтийг чиглүүлэх ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч албан ёсоор баталгаажуулаагүй.
- Ирээдүйн хөгжлийг тодорхойлох, урьдчилан таамаглахад бараг идэвх зүтгэл гаргадаггүй бөгөөд шинээр гарч ирсэн чиг хандлагад хариу үйлдэл үзүүлдэг.
- Дээд боловсрол, технологи болон бусад холбогдох салбарын мэдээ мэдээлэл, хөгжил дэвшлийг үндсэндээ уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон албан бус яриагаар авдаг.
- Ажилтнууд өөрсдийн алба, хэлтэс эсвэл мэргэшсэн салбарынхаа чиг хандлагыг үе үе хуваалцаж, хэлэлцдэг боловч алба, хэлтэс хоорондын хамтын ажиллагааны албан ёсны процесс байдаггүй.
- Ажилтнууд шинээр гарч ирж буй чиг хандлагын талаар ойлголт авахын тулд хурал, семинарт оролцдог боловч эдгээр үйл ажиллагаа нь хааяа зохиогддог, мөн стратегийн арга барилын нэг хэсэг биш.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Зарим нэг менежер жишиг үнэлгээ ашиглахыг дэмжиж, инновацын төлөвлөгөө, хөгжлийг мэдээллээр хангах зорилгоор хэлтэс дотроо ашиглахыг уриалж байж болно.
- Байгууллага нь стратеги төлөвлөлт, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангаж чиглүүлэх зорилгоор системтэй аргачлал ашиглан, чиг хандлагыг идэвхтэй хянаж, дүн шинжилгээ хийхдээ нэгдсэн хүчин чармайлт гаргадаг.
- Шинээр гарч ирж буй чиг хандлагыг тодорхойлохын тулд янз бүрийн мэдээллийн эх сурвалжийг (эрдмийн сэтгүүл, салбарын тайлан, нийгмийн сүлжээ, мэргэжилтнүүд гэх мэт) хянан судалдаг.
- Өөр өөр алба, хэлтэс, чиглэлийн ажилтнууд чиг хандлага тодорхойлох, дүн шинжилгээ хийхтэй холбоотой ойлголт, үзэл бодол, мэдлэг туршлагаа хуваалцах зорилгоор тогтмол хамтран ажилладаг.
- Ирээдүйн хөгжлийн боломжит хувилбаруудыг судлах зорилгоор чиг хандлага тодорхойлох семинар, урьдчилсан таамаг, хувилбар дэвшүүлэх хурал, семинарт ажилтнууд тогтмол оролцдог эсвэл эдгээрийг удирдан явуулдаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Дээд шатны удирдлагын баг жишиг үнэлгээг дэмждэг бөгөөд байгууллагын стратегийн зорилт, төлөвлөгөөг тодорхойлохдоо жишиг үнэлгээний үр дүнг хардаг. Жишиг үнэлгээний дүн шинжилгээг шийдвэр гаргахад ашигладаг.
- Тэд чиг хандлагыг идэвхтэй тодорхойлж, дүн шинжилгээ хийхээс гадна тухайн салбарын ирээдүйн хөгжлийг идэвхтэй тодорхойлж, нөлөөлдөг.
- Чиг хандлагыг тодорхойлж, дүн шинжилгээ хийхдээ өгөгдөлд тулгуурласан ойлголтыг хүний зөн совин, дүгнэлттэй хослуулан, байгууллага доторх болон байгууллагын гаднах мэдлэг, туршлага, эх сурвалжуудыг ашигладаг.
- Бусад байгууллага, салбарын тэргүүлэгчид, бодлого боловсруулагчидтай хамтран ажиллах нь шинэлэг шийдлүүдийг хамтран хэрэгжүүлэх боломж олгож, дээд боловсролын болон бусад холбогдох салбаруудын чиг хандлагад нөлөөлнө.
- Тус байгууллага нь шинээр гарч ирж буй чиг хандлагуудын талаар ойлгуулан, тайлбарласан судалгаа, тайлан, бие даасан өгүүллийг хэвлэн нийтэлж, олон нийтийн хэлэлцүүлэг, бодлогын түвшний мэтгэлцээнд хувь нэмрээ оруулдаг.



## 13 Дээд түвшний удирдлагад "ирээдүйг хувилбар дэвшүүлэн таамаглах" сэтгэлгээ суулгах

**Гол чиглэл:**
Стратеги төлөвлөлт
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Стратегийн төлөвлөлт нь гол төлөв идэвхгүй буюу хариу үйлдлийн шинж чанартай бөгөөд ирээдүйг идэвхтэйгээр төлөвлөхөөс илүү гарсан өөрчлөлтөд дасан зохицох дээр анхаардаг.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Ирээдүйд тулгарах сорилт, бий болох боломжуудыг таамаглан, тэдгээрт бэлдэхэд анхаарсан чиг хандлагын дүн шинжилгээ, урьдчилан таамаглах үйл ажиллагаануудыг стратеги төлөвлөлтөд багтаадаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Стратеги төлөвлөлт нь зөвхөн чиг хандлагад хариу үйлдэл үзүүлэх төдий бус дээд боловсролын салбарт инновац, хамтын ажиллагаа, манлайллаар дамжуулан ирээдүйг идэвхтэй тодорхойлоход чиглэдэг.

# Судалгаа

Судалгаа шинжилгээний ажлыг дэмжин тогтвортой дэд бүтцээр хангах. Үүнд, стратегийн аргачлалууд боловсруулах, дижитал систем, орчин, процесс, технологид зохих хөрөнгө оруулалт хийх, судлаачдыг татах, идэвхжүүлэх, хөгжүүлэх, дэмжих зэрэг орно.



## 14 Судалгаа, шинжилгээний ажил дахь дижитал шилжилтийн стратеги

**Гол чиглэл:**

Дижитал стратеги | Нээлттэй судалгаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь судалгаа, шинжилгээний ажилд дижитал шилжилт хийх стратеги боловсруулж, дижитал судалгааны дэд бүтэц, судалгааны хөрөнгийн удирдлага, нээлттэй судалгаа/хэвлэл, мэдлэг солилцоо, түншүүдтэй хамтрах хамтын ажиллагаа, судалгааны өгөгдлийн удирдлага зэрэгт зориулсан бодлогуудыг шинэчлэн өөрчилж, сайжруулахаар төлөвлөж байгаа.

### Тогтворжсон-Сайжирсан

- Судалгаа, шинжилгээний ажилд дижитал шилжилт хийх стратегийг боловсруулсан (эсвэл судалгаа, шинжилгээний ажлын стратегид нэгтгэн оруулсан) бөгөөд байгууллагын холбогдох хэд хэдэн стратегитай (жишээ нь: номын сан ба мэдээллийн, дижитал хадгалалтын, цуглуулгын удирдлагын, дижитал шилжилтийн, МТ-ийн, эд хөрөнгийн, өгөгдлийн стратеги гэх мэт) нийцүүлсэн.
- "Судалгааны хөгжлийн циклийн хүрээн дэх өмчлөл"-ийн тухай ойлголт, мөн нийлүүлэгчид болон гадны түншүүдтэй хэрхэн хамтран ажиллаж, зохих ёсны өмчлөлийг эзэмшиж болох талаар ойлголт бий болж байгаа.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Оролцогч талууд нь судалгаа шинжилгээний ажилд дижитал шилжилт хийхийн ач холбогдлын талаар нийтлэг ойлголттой болсон бөгөөд ашиглах дижитал арга, аргачлалууд нь байгууллагын үндсэн үнэт зүйлстэй (жишээ нь, тэгш байдал ба тэгш оролцоо, байгаль орчны тогтвортой байдал, ёс зүйт практик, олон улсын тавцанд гарах) нийцсэн байхад туушгай анхаарч ажиллах үүрэг хүлээнэ.

# 15 Дижитал судалгааны систем, судалгааны орчинд хөрөнгө оруулалт хийх

**Гол чиглэл:**
Дижитал стратеги | Номын сан, сургалтын нөөц
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Судалгааны үр дүнг үр дүнтэй удирдан зохион байгуулах, хадгалахад чиглэсэн дижитал технологи ашиглан хугацаатай болон хугацаагүй хадгалалтын стратеги, бодлогыг боловсруулж байгаа.
- Дижитал хадгалалтын туршилтын төслүүдийг дэмжих санхүүжилт бий. Дижитал/өгөгдлийн хөрөнгийн судалгаа болон оролцогч талуудын дүн шинжилгээг хийж, хөрөнгийн хэмжээ, тэдгээрийг хэрхэн ашиглаж, хэрхэн удирдах ёстойг тодорхойлсон.
- Ажилчдыг дадал хэвшлээ өөрчлөхөд дэмжлэг үзүүлж, зохих сургалтыг санал болгодог.
- Өгөгдлөл хадгалалт, аюулгүй байдал, мэдээллийн нөөцлөл, нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын болон мэдээлэл хуваалцах талаарх байгууллагын бодлого, практикт дижитал судалгааны өгөгдлийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанууд тусган оруулсан.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Хугацаатай болон хугацаагүй дижитал хадгалалтын стратеги, бодлогыг боловсруулж гаргасан бөгөөд эдгээрийн дагуу хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг хийдэг. Байнгын, урсгал төсөвт урт хугацааны нөөцийн хэрэгцээг тусгасан.
- Өгөгдлийг хугацаатай болон хугацаагүй хадгалах энгийн систем, ажлын дараалдыг үүсгэн бий болгосон. Дотоодын системүүдийг нэгтгэн холбох ажил энгийн түвшинд хийгдсэн.
- Шилдэг туршлага, нээлттэй өгөгдлийн зарчмууд, өгөгдлийн тэгш хүртээмжид анхаарсан дижитал судалгааны өгөгдлийн удирдлагын цогц арга барилыг нэвтрүүлсэн.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Өөрчлөгдөн буй хэрэгцээ, тэргүүлэх чиглэлүүдийг тусган авч дижитал хадгалалтын стратеги, бодлогуудаа тогтмол хянаж, шинэчилдэг.
- Системүүдийг нэгтгэсэн бөгөөд ажлын дарааллуудыг (дотоод болон гадна) бүрэн тодорхойлон ашиглаж байгаа.
- Шилдэг туршлага, холбогдох бодлого, дүрэм журмыг дагаж мөрдөн, судалгааны хөрөнгийн удирдлагын найдвартай системүүдээр дамжуулан өгөгдлийг хадгалж, хуваалцаж, өгөгдөлд хандах боломжтой болсон.
- Дижитал судалгааны өгөгдлийн удирдлагын цогц систем ашиглан, нээлттэй өгөгдлийн зарчмуудыг баримтлан, мэдээллийн тэгш хүртээмжид анхаарч судалгаа шинжилгээний ажлыг явуулдаг.



# 16 Судалгааны дижитал болон бодит дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх

**Гол чиглэл:**
Дижитал стратеги | Найдвартай дижитал дэд бүтэц
| Хөрөнгө оруулалт
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Судалгааны дижитал дэд бүтцэд аюулгүй, найдвартай технологи, хэрэгсэл, холболт, сүлжээ, үйлчилгээ, мэдээлэл, цуглуулга, өгөгдөлд хандах эрхийг оруулна.
- Судлаачид өөрсдийн мэргэжлийн чиглэлд тохирох тусгай программ хангамж, багаж хэрэгсэл, бодит орон зайг (жишээлбэл, статистик шинжилгээний программ хангамж, өгөгдөл дүрслэх программ хэрэгсэл, лаборатори, симуляци болон загварчлалын программ хангамж, хэрэгсэл) ашиглах, нэвтрэх эрхтэй.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Судалгааны шинэчилсэн, нэгдсэн дижитал дэд бүтэц нь нарийн төвөгтэй, том хэмжээний эсвэл тооцоолох хүч шаардсан ажлуудыг гүйцэтгэх өндөр хүчин чадалтай тооцоолох төхөөрөмж зэрэг дэвшилтэт технологи, үйлчилгээнүүдийг агуулдаг. Үүлэнд суурилсан үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийснээр судлаачдад хэрэгцээ, шаардлагадаа нийцүүлэн тооцооллын нөөц буюу систем, төхөөрөмжүүдэд хүссэн үедээ хандан ашиглах боломжийг олгодог.
- Янз бүрийн судалгааны чиглэл, ажлын хэрэгцээнд тохирсон програм, хэрэгслүүдийн өргөн сонголттой.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Судалгааны ажилд зориулсан дижитал дэд бүтэц нь судалгаачдын хэрэгцээнд тохирсон. Өөр өөр чиглэлийн судлаачдын тодорхой шаардлага, зорилгод нийцсэн технологийн нөөц, үйлчилгээ, дэмжлэгийн системүүдийг боловсруулж, хэрэгжүүлсэн.
- Судлаачид хамгийн тохиромжтой, үр дүнтэй програм хэрэгсэлд нэвтрэн ашиглах боломжтой бөгөөд энэ нь тэдэнд илүү үр дүнтэй, үр бүтээлтэй ажиллах боломж олгодог.
- Судалгааны үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж, стратеги төлөвлөлтийг мэдээллээр хангаж, ирээдүйн өгөгдөл боловсруулах хэрэгцээ, програм хангамжийн сонголт, хамтын ажиллагааны шаардлагуудыг тодорхойлон дэмждэг.
- Төрөл бүрийн хэрэгсэл, үйлчилгээ, техник хангамж, програм хангамж ашиглан тооцоолох ажлын олон янзын хэрэгцээ, ачааллын шаардлагууд болон судалгааны ажлын чиглэл нэг бүрийн өвөрмөц хэрэгцээг хангадаг.

## 17 Олон улсын судалгааны хамтын ажиллагааны боломж

**Гол чиглэл:**

Олон улсын үйл ажиллагаа | Судалгааны хамтын ажиллагаа | Дижитал бүлэг үүсгэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Өөр өөр мэргэжлийн чиглэлүүд болон олон улсын хамтын ажиллагаа нь сургалт, судалгааны тэнхим, хэлтсүүдийн уламжлалт арга барилаас хамаардаг.
- Нээлттэй судалгаа хийх, хэвлэн нийтлэх туршлага бий болж байгаа бөгөөд эдгээр хандлагыг хэрэгжүүлэхэд судлаачдад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал арга барил хэрэгжүүлснээр мэдлэг солилцох үйл ажиллагаа болон өөр өөр мэргэжлийн чиглэлүүдийн хамтын ажиллагааны боломжийг сайжруулж, улмаар олон улсын байгууллагуудын томоохон сүлжээтэй түншлэлийг харилцаа үүсгэсэн.
- Нээлттэй судалгаа, хэвлэн нийтлэх туршлагыг улам бүр нэвтрүүлж, эдгээр хандлагыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж буй судлаачдад илүү их дэмжлэг үзүүлсэн.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал мэдлэг солилцох үйл ажиллагаа явуулж, өөр өөр мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй судлаач, багш нарын хамтын ажиллагаа, инновацыг дэмждэг. Гадаад түншүүдтэй өргөн хүрээнд хамтран ажиллаж, олон улсын байгууллагуудын томоохон сүлжээнд нэгдсэн.

- олон улсын түвшинд нийцсэн бодлого, зохицуулалт, дэд бүтцийг бий болгож, хөгжүүлэх зорилгоор олон улсын судалгааг дэмжиж, түншүүдтэй хамтран ажиллах технологи, системд стратегийн хөрөнгө оруулалт хийхээр тодорхойлсон
- Байгууллага, санхүүжүүлэгч болон засгийн газрын бодлогын дагуу судалгааны түншлэлд эрсдлийн дүн шинжилгээ хийх, төвлөрсөн хяналт, удирдлагыг хэвийн үргэлжлүүлэх үүрэг хүлээсэн.
- Нээлттэй судалгаа болон хэвлэлийг тууштай дэмжсэнээр судлаачдад өөрсдийн ажлыг хүртээмжтэй, дахин ашиглах боломжтой болгоход ихээхэн нэмэр үзүүлдэг.



## 18 Ёс зүйтэй, хариуцлагатай, ил тод, аюулгүй судалгаа

**Гол чиглэл:** Ёс зүй | Байгууллагын үнэт зүйлс

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Судалгааны үнэнч шударга байдал, ёс зүйд анхаарсан, итгэмжлэгдсэн судалгааны арга барил боловсруулах дижитал боломжуудыг судалж байгаа.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөн, үнэнч шударгаар судалгаа хийх явдлыг нэмэгдүүлж, итгэмжлэгдсэн, сайжруулсан судалгааны арга барилыг нэвтрүүлсэн.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Итгэмжлэгдсэн судалгааны арга барилд онцгой анхаарал хандуулснаар тус байгууллага нь ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөн, үнэнч шударгаар судалгаа хийдэг хэмээн өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн. Бүх судалгаа нь ёс зүйтэй, хариуцлагатай, үнэнч шударга, найдвартай, дахин давтагдах боломжтой, ил тод, нээлттэй. Судалгааг мөн аюулгүй орчинд хийдэг.

## 19 Судлаачдын хөгжлийг дэмжих, таатай орчин

**Гол чиглэл:**
Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Байгууллагын үнэт зүйлс

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Судалгааны соёлд дижитал технологи мэдэгдэхүйц нэвтэрсэн бөгөөд судлаачид дижитал программ хэрэгсэл, арга техник ашиглахдаа илүү итгэлтэй, чадварлаг болж байгаа. Номын сангийн зүгээс дижитал судалгаа хийхэд шаардлагатай үйлчилгээ, сан хөмрөг, нөөц, дэмжлэгийг санал болгодог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Судлаачдад зориулсан илүү олон янзын сургалт, дэмжлэг үйлчилгээ бүхий дижитал технологи ашиглан өргөтгөсөн судалгааны соёл тогтсон. Номын сангийн зүгээс өгөгдлийн удирдлага, өгөгдлийн дүрслэл, текст олборлолт зэрэг шинэлэг судалгааны арга барилыг дэмжих үйлчилгээ, нөөцийг санал болгодог.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Судлаачид дижитал программ хэрэгсэл, арга техникийг гаргууд эзэмшсэн, байгууллагын зүгээс сургалтын болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээг (жишээлбэл, өгөгдлийн мэргэжилтнүүд, номын сан ба мэдээллийн мэргэжилтнүүд, мэдээллийн технологийн систем, судалгааг дэмжих багууд) өргөн хүрээнд санал болгодог, дижитал технологи ашиглан өргөтгөсөн судалгааны соёл бүрэн тогтсон. Эрх тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцооны ойлголтуудыг судалгаа хийх бүх төрлийн арга барилд нэвтрүүлсэн.



## 20 Судлаачдыг ажилд авах, тогтвортой ажиллуулах

**Гол чиглэл:** Судалгааны ур чадвар дээшлүүлэх, сургалтанд хамрагдах

**Төлөвшлийн түвшинг сонгох:**

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагын зүгээс судлаачдыг дижитал технологи ашиглахдаа итгэлтэй, чадвартай байх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

- Дижитал ур чадвар бүхий өндөр ур чадвартай судлаачдыг татах, ажилд авах, тогтвортой ажиллуулах зарим журамд нөөцийн хомсдол, түр болон богино хугацааны гэрээний улмаас саад тотгор учирч болзошгүй. Дижитал хэрэгслийг судалгаандаа үр дүнтэй ашиглах талаар тогтмол сургалтыг судлаачдад санал болгодог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллага нь дижитал технологи ашиглахдаа итгэлтэй, чадварлаг судлаачдыг сонгон шалгаруулж, тогтвортой ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах боломж бүрдүүлэх, өрсөлдөхүйц цалин хөлс амлах, урт хугацааны гэрээ хийх гэх мэт олон янзын ашигтай, үнэ цэнэтэй нөхцлүүдээр ажилтнуудыг татан, тогтвортой ажиллуулдаг. Судалгааны дижитал ур чадвар, мэдлэгийг байгууллага даяар үнэлдэг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллагын зүгээс дижитал ур чадвар бүхий судлаачдын дижитал шилжилтэд оруулах үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, хамгийн шилдэг ажилтнуудыг татах зорилгоор ажилд авах, тогтвортой ажиллуулах, хөгжүүлэх стратегийн, шинэлэг хандлагыг баримталдаг.

- Ахлах судлаачид байгууллагын стратеги, бодлого боловсруулах, судалгааны ажилд инновац нэвтрүүлэхэд идэвхтэй оролцдог.

- Дижитал технологи ашиглахдаа итгэлтэй, туршлагатай судлаачид янз бүрийн мэргэжлийн бүлгүүд болон судалгааны нийгэмлэгүүдэд (Нийгмийн шинжлэх ухааны академи, Британийн академи, Язгуууртны нийгэмлэг, Vitae гэх мэт) мэдлэг, туршлагаараа хувь нэмэр оруулдаг.

## 21 Судлаачдыг хөгжүүлэх, сургах

**Гол чиглэл:**

Судалгааны ур чадвар дээшлүүлэх, сургалтанд хамрагдах | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллага нь судлаачдад шинэ ур чадвар эзэмшүүлэх, хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, технологиос хоцрохгүй байхад нь туслах зорилгоор сургалт, хөгжлийн боломжуудад хөрөнгө оруулалт хийж байгаа. Судалгааны багуудын дижитал итгэлийн түвшин, чадавхын талаар ойлголт дутмаг, өөр өөр тэнхим, хэлтэст ажилладаг багш, судлаачид хоорондоо мэдлэг, туршлагаа хуваалцах боломж байхгүй.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Судлаачдын хөгжлийг дэмжих, дижитал ур чадвараа шинэчлэн сайжруулахад нь чиглэсэн сургалтад ихээхэн хөрөнгө оруулалт хийж байгаа. Мэргэшил, мэргэжлийн чиглэлүүдээр зохих ахисан түвшний гэрчилгээ авах боломжуудыг санал болгож байгаа.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь судлаачдын хөгжил, сайн сайхны төлөө тууштай хөрөнгө оруулалт хийж, мэргэжлийн өсөлт, дэвшлийг дэмждэг соёлыг бий болгосон. Судалгааны багууд дижитал систем, үйлчилгээ, сүлжээг судалгааны практикт нэвтрүүлэхийн тулд бусад зохих багуудтай нягт хамтран ажилладаг.

- Ажилтнууд судалгаа, эрдэм шинжилгээний нийтлэл, мэргэжлийн сүлжээ, арга хэмжээнүүдээр дамжуулан дижитал судалгааны мэдлэг чадвар болон байгууллагаас гадуурх туршлагаа хуваалцдаг. Нээлттэй арга барилыг дэмжин, хүлээн зөвшөөрч, урамшуулдаг.



## 22 Судлаачдад мэргэжлийн туслалцаа үзүүлэх

**Гол чиглэл:**

Судалгааны дэмжлэг | Судалгааны удирдлага, дэмжлэг | Номын сан, сургалтын нөөц

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Судалгааны үйл ажиллагаа олон баг дэмждэг. Багууд хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа хязгаарлагдмал бөгөөд зарим үед уялдаа холбоогүй системүүдээс үүдэн мэдээллийн чанар, менежмент алдагддаг.

- Дижитал итгэл, чадавхын түвшийн багуудад харилцан адилгүй байх бөгөөд судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор дижитал чадавхыг хөгжүүлэх уялдаа холбоо бүхий арга барил байхгүй.
- Судалгааг дэмжих технологи, хэрэгсэл, сүлжээг байгууллагын мэдээллийн технологийн стратегид тусган оруулсан. Номын сангаар дамжуулан эрдэм шинжилгээний ном зохиол, мэдээллийн сан болон бусад судалгааны эх сурвалжуудыг хангадаг.

- Судалгааг дэмжих мэргэшсэн багууд (жишээлбэл, буцалтгүй тусламж болон санхүүжилт, гэрээ хэлцэл, нийцэл, ёс зүй) өөрсдийн ажил үүрэгт дэмжлэг болох тусгай программ, хэрэгслийг ашигладаг.
- Бусад төв оффисууд судалгааны дэмжлэгийг үйлчилгээндээ нэгтгэсэн (жишээлбэл, олон улсын асуудал хариуцсан алба, хууль эрх зүй, харилцаа холбоо гэх мэт).

**Тогтворжсон-Сайжирсан**

- Стратегийн хөрөнгө оруулалт, дижитал дэд бүтцэд өөрчлөл хийснээр судалгааг дэмжих систем, программ хэрэгсэл, өгөгдлийг хооронд нь нэгтгэх процессыг сайжруулсан.

- Судалгааны дэмжлэг үзүүлэх багуудын эзэмшвэл зохих дижитал ур чадварыг байгууллагын дижитал чадавхын төлөвлөгөөнд тусган оруулсан бөгөөд багуудын чадавхыг шалгаж сул болон давуу талыг тодорхойлдог.

- Дижитал харилцаа холбоо, хамтын ажиллагааны хэрэгслээр дамжуулан судалгааг дэмжих багуудын уялдаа холбоог сайжруулсан.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Судалгаанд дэмжлэг үзүүлэх цогц экосистемийг найдвартай, аюулгүй дижитал дэд бүтэц, байнгын ажиллагаа болон холболт бүхий сүлжээ, өндөр чанартай өгөгдөл болоод хөрөнгийн удирдлагын системүүд, уялдаа холбоотой хамтран ажилладаг судалгааны дэмжлэг үзүүлэх багуудаас бүрдүүлэн бэхжүүлдэг.
- Дижитал эрдэм судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор номын сангийн (болон архивын) үйлчилгээг идэвхтэй түншийн хувиар шаардлагатай дижитал эрдмийн болон судалгааны ажилд бүрэн нэвтрүүлсэн.
- Номын сангийн (болон архивын) үйлчилгээ нь дижитал судалгааны ур чадварыг хөгжүүлж, таниулахад, мөн дижитал эрдэм судалгааны ажлыг дэмжих формат бүхий агуулга, өгөгдлөөр хангахад идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг.
- Тус номын сан нь Их Британийн Судалгааны номын сангуудын консорциумын гишүүн бөгөөд судалгааны номын сангийн зорилтыг тодорхойлон чиглүүлэх санаачлагуудад хувь нэмрээ оруулдаг.



# Шинийг санаачлах

Бүтээлч байдал, бизнес сэтгэлгээ, дижитал манлайллыг уриалан дэмжих замаар шинэ санаа, шийдлүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Тохирох буюу шаардлага хангасан инновацыг стратегийн зорилго, алсын хараа, одоо ашиглагдаж буй арга барил, хуучны системүүд болон процессуудтай уялдуулах.



## 23 Зохих инновацыг дэмжих, идэвхжүүлэх

**Гол чиглэл:**

Инновацын стратеги | Дижитал бүтээлч байдал | Дижитал манлайлал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Бизнесийн удирдлага, боловсрол, судалгааны дижитал шийдлүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэх зарим нэг албан ёсны процессууд бий болсон. Инновацыг ихэвчлэн хувь хүн эсвэл тусдаа хэлтэс санаачилдаг.
- Дээд шатны удирдагчид дижитал инновацыг удирдан чиглүүлэх зохих ур чадвар, туршлагагүй байж болно.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Тус байгууллага нь боловсрол, удирдлага, судалгааны чиглэлээр дижитал инновацын чадавхыг сайжруулж, зохицуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа. Удирдагчдыг манлайлал үзүүлж, шинэлэг арга барилыг үлгэрлэн харуулахыг уриалан дэмжиж байгаа.
- Дээд шатны удирдлагуудад дижитал инновацын чиглэлээр дэмжлэг үзүүлж, сургалтанд хамрагдахыг санал болгож байгаа.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь боловсрол, удирдлага, судалгааны үйл ажиллагааны хүрээнд дижитал инновацад чиглэсэн стратегийн, уялдаа холбоо бүхий арга барилтай бөгөөд үүнд тухайн мэргэжлийн чиглэлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэж, өөр өөр мэргэжлийн чиглэл хоорондын болон тухайн мэргэжлийн чиглэл дэх инновацын түншлэлийг онцлон авч үздэг. Бүх оролцогч талууд санал бодлоо илэрхийлэх, оролцох боломжтой.
- Байгууллагын удирдагчид нь оюутнуудын сургалтын үр дүнг болон удирдлагын үйл явцыг сайжруулах, шинэлэг судалгаа явуулахад чиглэсэн шинэлэг дижитал шийдлүүдийг боловсруулж, хэрэгжүүлдгээрээ салбар даяар хүлээн зөвшөөрөгдөн танигдсан.

## 24 Шинэлэг практикийг идэвхжүүлэх

**Гол чиглэл:**

Дижитал бүтээлч байдал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Бүтээлч, шинийг санаачлагч ажилтнууд зарим тохиолдолд одоо хэрэгжиж буй бодлого, арга барил, хязгаарлалтын улмаас шинэ санаа нэвтрүүлэх, хөгжүүлэх боломжгүй байдаг. Ажилтнууд одоо хэрэгжиж буй арга барилыг эргэцүүлэн бодох, шинэ арга барилыг авч үзэх цаг зав, орон зайгүй байдаг. Оюутнуудад санаа бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох боломж хомс байдаг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллага нь түншлэлийг илүү өргөн хүрээнд хөгжүүлж, бизнесийн боломжуудыг дэмжих замаар ажилтнууд болон оюутнуудын бүтээлч санааг үнэлж, хөхүүлэн дэмждэг. Мөн бүтээлч дижитал мэргэжилтнүүдийг  ажилд авахыг эрмэлздэг. Дижитал хөгжил тэдэнд хэрхэн нөлөөлж байгаа талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг оюутнуудад олгодог.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Дэвшүүлсэн санааны эхний хөгжүүлэлтийг дэмжих зорилгоор инновацад зориулан тусдаа төсөв тусгаарлан (ring-fenced budget) төлөвлөдөг ба оюутнуудад түншээр оролцох боломж олгодог. Гадны инновацын буцалтгүй тусламж, бусад боломжуудад хүсэлт гаргах уялдаа холбоо бүхий стратегийн арга барилтай болсон. Урьдчилан тооцоолсон эрсдэлийг хүлээх, шинэ буюу өөр технологиудыг туршиж үзэх тал дээр ажилтнуудад урам зориг өгч, дэмждэг.



## 25 Дижитал систем, хэрэгсэл, үйлчилгээг бий болгох, ашиглах шинэлэг арга барил

**Гол чиглэл:**

Дижитал стратеги | Инновацын стратеги | Дижитал бүтээлч байдал | Дижитал манлайлал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал технологиудыг сургалтын удирдлагын систем эсвэл дижитал судалгааны мэдээллийн сан гэх мэт гол гол хэрэгцээтэй чиглэлүүдэд байгууллага даяар ашигладаг. Байгууллага шийдвэр гаргах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор өгөгдлийн аналитик болон бусад дижитал хэрэгслийг ашиглаж байгаа.
- Мэдээллийн технологийн өмнөх санаачилга, төслүүдийн үр дүнд инновацын тодорхой жишээнүүдтэй болсон бөгөөд байгууллагын дотоод шийдэл, системүүдийг үүсгэн, бий болгосон.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллага нь заах болон суралцах үр дүнг сайжруулах, удирдлагын үйл явцыг оновчтой болгох, судалгаанд инновацыг нэвтрүүлэх зорилгоор хиймэл оюун ухаан эсвэл виртуал бодит байдал зэрэг дэвшилтэт технологийг ашиглаж байгаа. Мөн оролцогч талуудтай холбогдож, инновацын соёлыг төлөвшүүлэхийн тулд нийгмийн сүлжээ эсвэл онлайн хамтын ажиллагааны хэрэгсэл зэрэг дижитал платформуудыг ашиглаж байгаа.
- Одоог хүртэл ашиглах боломжтой байгаа хуучны системүүдийн засвар болон дэмжлэг үйлчилгээтэй шинэ аргачлалуудыг хослуулсан, тэнцвэржүүлсэн байдлаар хөрөнгө оруулалт хийх стратегийн шийдвэрүүд гаргадаг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллага нь нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэх, инновацыг дэмжих зорилгоор блокчэйн эсвэл квант тооцоолол зэрэг шинэлэг технологи ашиглаж байгаа (жишээлбэл, дижитал гэрчилгээ болон диплом олгож, баталгаажуулах, өгөгдөл хуваалцах, квант тооцооллын судалгаа хийх). Байгууллага даяар хамтын ажиллагаар хөгжүүлж, инновацыг дэмжих зорилгоор дижитал инновацын лаборатори эсвэл инкубатор байгуулахын ашиг тусыг тооцон авч үзэн.
- Ирээдүйн хөгжил дэвшилд нийцүүлэн ашиглах боломжтой техникийн дэд бүтцийг бий болгох зорилгоор хуучин системүүдийг шинэ систем, үйлчилгээнүүдтэй нэгтгэхэд хүчин чармайлт гаргасан.

# Өргөн хүрээний нөлөөлөл

Судалгаа, инновацын төслүүдийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, тодорхой бүлгүүдэд зохих журмаар түгээх



## 26 Байгууллагын судалгаа, бизнес, инновацын орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд үзүүлэх нөлөө

**Гол чиглэл:**
Маркетинг, харилцаа холбоо | Гадаад харилцаа | Орон нутгийн / бүс нутгийн / үндэсний нөлөөлөл | Дижитал хүрээлэл үүсгэх | Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●–○–○ Эхлэл-Тогтворжсон**

- Тус байгууллага нь судалгаа, бизнес, инновацын үйл ажиллагааныхаа өргөн хүрээний нөлөөллийг судалж эхэлж байгаа. Энэ нь статистикийн тоо баримт гаргаж өгөх судалгаанд тавигдах дүрэм, журмын шаардлагад нийцэх боловч нөлөөллийг үнэлэх албан ёсны үйл явц байхгүй. Тухайн тохиолдлоор эсвэл оролцогч талуудын албан бус санал дүгнэлтээр нөлөөллийн талаарх мэдээллийг авдаг. Байгууллагын зүгээс нөлөөлөлтэй холбоотой чиг хандлага, ойлголтыг тодорхойлохын тулд өгөгдлийн шинжилгээний программ хэрэгслүүдийн ашиглахаар судалж байгаа.
- Судлаачид судалгааны өгөгдөл, үр дүнг удирдахдаа, мөн дижитал судалгааны нийгэмлэгүүд болон олон нийттэй харилцахдаа, аюулгүй байдлыг хангаж, ёс зүйг баримтлах.

**○–●–○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллага нь судалгаа, бизнес, инновацын үйл ажиллагааныхаа үр нөлөөг үнэлэх чадавхыг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд албан ёсны үйл явц, стратегийн арга барилыг бий болгосон. Мөн нөлөөллийн олон төрөл хоорондын харилцаа, хэв загварыг тодорхойлох зорилгоор ахисан түвшний өгөгдлийн аналитикийн болон дүрслэлийн программ хэрэгслүүдийг ашигладаг.
- Дижитал программ хэрэгсэл, харилцаа холбоог ашигласнаар судалгаанд суурилсан сургалтыг дэмжих, эрдэм шинжилгээний сайн туршлагыг сурталчлах, судалгааны хүрээлэн буй орчин, нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтийг хамарсан яриа өрнүүлэх эрдэмтдийн хүрээлэл, нийгэмлэгүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

**○–○–● Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллага нь үйл ажиллагааныхаа нөлөөллийг үнэлэх, мэдээлэх тухайд манлайлагч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд нөлөөллийн үнэлгээний тусгай алба эсвэл мэргэжлийн төвийг байгуулсан байж болно. Аж үйлдвэр, олон нийтийн байгууллага гэх мэт гадны түншүүдтэй хамтран ажилласнаар ойрын хүрээлэл дэх оролцогч талуудаас гаднах үйл ажиллагааны өргөн хүрээний нөлөөллийг илүү сайн ойлгоход тусалдаг.
- Байгууллага нь нөлөөллийг тодорхойлох, үнэлэх зорилгоор нийгмийн сүлжээний дүн шинжилгээ, машин сургалт зэрэг дэвшилтэт аргуудыг ашиглаж байгаа. Энэхүү нөлөөллийн мэдээллийг нийтэд нээлттэй тайлан, хяналтын самбар эсвэл бусад сувгаар дамжуулан оролцогч талуудад идэвхтэй хүргэж байгаа.
- Дижитал програм хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслийг идэвхтэй хэрэглэснээр тухайн байгууллага нээлттэй судалгаа, олон нийтийн оролцоо, мэдлэг солилцох чиглэлээр глобал түвшинд нөлөөлөгч болсон.

## 27 Байгууллагын технологийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, ашиглалттай холбоотой шийдвэрүүдийн бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

**Гол чиглэл:** Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Технологийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, ашиглалтын үндсэн үнэлгээг бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаар хязгаарлагдмал ойлголттойгоор хийдэг.
- Технологийн холбогдолтой шийдвэрүүдийг зохион байгуулалтын уялдаа холбоогүйгээр бие даасан хэлтэс, багууд тус тусдаа үнэлдэг.
- Технологийн хөрөнгө оруулалт болон ашиглалтын санхүүгийн болон үйл ажиллагааны тал дээр анхаараад, боловсрол, судалгаа болон бусад бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг тэдийлэн тооцон авч үздэггүй.
- Технологийн шийдвэрийн амжилт, үр нөлөөг хэмжихэд тоон болон чанарын хэмжүүрүүдийг хязгаарлагдмал байдлаар ашигладаг.
- Асуудлыг системчилсэн байдлаар биш тухайн тохиолдолд буюу түр зуурын байдлаар шийдвэрлэж, сайжруулдаг.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага нь илүү өргөн хүрээний бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж,  боловсронгуй хэмжүүрүүд ашиглан технологийн холбогдолтой шийдвэрүүдийг үнэлэх системтэй арга барил хэрэгжүүлсэн.
- Технологийн холбогдолтой шийдвэрүүдийн бизнесийн янз бүрийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаарх иж бүрэн ойлголтыг бий болгох зорилгоор үнэлгээг хэлтэс, багууд хооронд уялдаа холбоотой зохицуулдан хийдэг.
- Үнэлгээгээр санхүүгийн болон үйл ажиллагааны талаас гадна боловсрол, судалгаа, бизнесийн бусад үйл ажиллагаанд технологийн хөрөнгө оруулалт хийх болон технологи ашиглалтын нөлөөллийг авч үздэг.
- Технологийн холбогдолтой шийдвэрүүдийн амжилт, үр нөлөөг үнэлэхдээ хэрэглэгчийн сэтгэл ханамж, сургалтын үр дүн, судалгааны бүтээмж, байгаль орчны тогтвортой байдал зэрэг олон төрлийн тоон болон чанарын хэмжүүрүүдийг ашигладаг.
- Технологийн холбогдолтой шийдвэрүүдийн бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг сайжруулахын тулд үнэлгээ хийж сайжруулах боломжуудыг тодорхойлж, өөрчлөлтүүдийг хийдэг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын бизнесийн үйл ажиллагааны бүх тал дээр технологийн холбогдолтой шийдвэрүүдийн нөлөөллийг оновчтой болгох зорилгоор өгөгдөлд тулгуурласан дүгнэлт, үр дүнгийн эргэх холбооны циклийг ашигласан тасралтгүй үнэлгээ, сайжруулалтын соёл тогтсон.
- Иж бүрэн үнэлгээ гэсэн ойлголтод технологийн холбогдолтой шийдвэрүүдийн боловсрол, судалгаа, бизнесийн бусад үйл ажиллагаанд үзүүлэх бүх төрлийн нөлөөлөл, түүнчлэн зохион байгуулалтын өргөн хүрээг хамруулан авч үзнэ.
- Үнэлгээг стратеги төлөвлөлтийн үйл явцтай нэгтгэж, технологийн холбогдолтой шийдвэрүүдийг ерөнхий зорилго, зорилтуудтай тасралтгүй нийцүүлэн уялдуулж байдаг.
- Технологийн холбогдолтой шийдвэрүүдийн амжилт, үр нөлөөг хэмжихдээ одоогийн болон ирээдүйн төлөв байдлын үзүүлэлтүүдийг хослуулан, мөн үнэлгээний шинэлэг аргуудыг ашигладаг бөгөөд ингэснээр тэдгээрийн үр нөлөөг нарийн ойлгох боломжтой болдог.
- Үнэлгээгээр тодорхойлсон сайжруулалтыг хэрэгжүүлэх системчилсэн тогтсон процессуудтай. Тасралтгүй суралцах, дасан зохицох соёлоор дамжуулан тасралтгүй сайжруулалтыг удирдан дэмжиж, технологийн холбогдолтой шийдвэрүүдийг бизнесийн бүх үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг байхад анхаарч ажилладаг.

# Мэдлэг дээшлүүлэх

Бүх оролцогч талуудын дижитал орчинд сурч, ажиллаж, хөгжих боломжийг хангахын тулд байгууллагын хүрээнд мэдлэг дээшлүүлэх, хөгжиж боловсрох явдлыг дэмжих.
Дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх арга замыг дахин бодож, сайжруулах.



# Сургалтын хөтөлбөр боловсруулах

Хичээлийг хянах, төлөвлөх, боловсруулах. Үүнийг ерөнхийд нь төгсөлтийн үр дүн болон жишиг үзүүлэлтүүдтэй харьцуулж, мэргэжлийн стандартуудад нийцүүлсэн, тодорхой баримт бичиг (жишээ нь, хичээлийн гарын авлага, хуваарь, виртуал сургалтын орчны материалууд) хэлбэрээр боловсруулан гаргадаг, хэлтсийн болоод байгууллагын түвшний албан ёсны үйл явц хэмээн тодорхойлж болно.



## 28 Дижитал технологи ашиглан суралцах, заах, үнэлэх стратегийн арга барил

**Гол чиглэл:**
Суралцах, заах, үнэлэх стратеги | Дижитал стратеги | Сургалтын хөтөлбөрийн дизайн | Сургалтын загвар | Сургалтын хөтөлбөрийн тогтолцоо | Магадлах | Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

●-○-○ **Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагын үнэт зүйлс, алсын хараа (жишээ нь, тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо, байгаль орчны тогтвортой байдал) болон байгууллагын бусад стратегитай уялдуулахын тулд дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх стратегийн аргачлалыг боловсруулахаар төлөвлөж байгаа.
- Байгууллагад хамгийн тохиромжтой арга барилыг тодорхойлохын тулд гадны сургалтын хөтөлбөрийн тогтолцоо/загвар, дизайны зарчмуудыг судалж байгаа.
- Сургалтын үр дүнд хүрэхийн тулд шаардлагатай нөхцөлд дижитал хэлбэрээр суралцах болон заах аргыг ихэнх хичээлүүдэд янз бүрийн хэмжээгээр нэвтрүүлсэн. Дижитал технологи нэвтрүүлсний үр ашиг, нөлөөллийг тэр бүр тодорхойлж үнэлдэггүй, суралцагчдад ил тод харуулдаггүй. Сайн туршлага нь тохиолдлын чанартай бөгөөд байнга хуваалцдаггүй. Баталгаажуулах үйл явц нь заримдаа инновацад саад болдог.
- Дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх процессуудыг дэмжих, мөн түүнчлэн зохих төхөөрөмж, эрчим хүчний эх үүсвэр, аюулгүй холболт, орон зай, сургалтын удирдлагын системд нэвтрэн хандах боломжийг хангах бодит болон дижитал дэд бүтэц бий болсон.
- Бүх багш нар дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэхэд оролцдоггүй бөгөөд энэ нь сургалт, дэмжлэг бараг байдаггүйтэй зарим талаараа холбоотой. Дижитал дэмжлэгийг гадны багуудаас авах боломжтой (жишээ нь, МТ, сургалтын технологи, заах болон суралцах туршлагын жишиг төвүүд, номын сан).

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Багш нар, оюутнууд болон тэнхимүүдийн оролцоотойгоор дижитал сургалт, үнэлгээний нэгдсэн стратегийг боловсруулсан (эсвэл одоо байгаа сургалт, үнэлгээний стратегиудад нэмж оруулсан). Энэхүү стратеги нь сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бөгөөд байгууллагын үнэт зүйлс, зорилго, зорилтуудтай нийцсэн байна.
- Байгууллага даяар дижитал хэлбэрээр заах, суралцах, үнэлэх үйл ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд чиглэсэн системтэй арга барил бүрэлдсэн.
- Дижитал сургалтын өөрчлөгдөн буй хэрэгцээ, шаардлагуудыг тусгахын тулд чанарын баталгаа, сайжруулалтын тогтолцоонуудыг тогтмол хянан, шинэчилдэг. Шилдэг туршлагыг нэвтрүүлэх, шинээр гарч ирж буй сорилтуудыг шийдвэрлэх, холбогдох стандарт, дүрэм журамтай нийцүүлэх зорилгоор өөр өөр бүлгийн оролцогч талууд энэхүү үйл явцад саналаа оруулдаг.
- Бодит болон дижитал дэд бүтэц нь сургалтын удирдлагын систем, виртуал анги танхим, бүтээлч орон зай, дижитал төв, мультимедиа нөөц зэрэг олон төрлийн дижитал сургалтын хэрэгсэл, орон зай, платформыг дэмждэг.
- Олон тооны багш, судлаачид дижитал сургалт, үнэлгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд оролцдог бөгөөд тэдний итгэлийн түвшин, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор байнгын сургалт, дэмжлэг үзүүлэх боломжтой. Сургалтын технологич, номын санч нар сургалтын хөтөлбөрийн багуудтай мөр зэрэгцэн хамтран ажилладаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал хэлбэрээр суралцах, заах, үнэлэх аргачлалын стратеги нь ирээдүйг харсан, нөхцөл байдалд тохируулан өөрчлөх боломжтой, тасралтгүй инновац, сайжруулалтад чиглэсэн байна.
- Өндөр чанартай, уян хатан, холимог сургалтыг загварчлан, баталгаажуулж, явуулах шинэлэг, сурган хүмүүжүүлэх ухаанд тулгуурласан арга барилуудтай. Тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо, байгаль орчны тогтвортой байдал, өөрчлөгдөн буй суралцагчдын хэрэгцээ, шаардлага зэрэгтэй холбоотой хүчин зүйлс дээр үндэслэн суралцах, заах, үнэлэхэд дэмжлэг үзүүлэх технологийн ёс зүйтэй, зохистой хэрэглээг тодорхойлдог.
- Бодит болон дижитал дэд бүтэц нь сургалтад дижитал программ хэрэгсэл, орон зай, платформ, агуулгыг тасралтгүй нэгтгэх боломжийг олгодог. Сургалтын зорилгод хүрэхийн тулд шинэ технологийг зохих ёсоор ашигладаг.
- Багш, судлаачид дижитал хэлбэрээр сургалт явуулж, үнэлгээ хийхдээ итгэлтэй, чадварлаг бөгөөд дижитал сургалтын стратеги, программ хэрэгсэл, туршлагыг хөгжүүлж, сайжруулахад идэвхтэй хувь нэмэр оруулдаг. Сургалтын хөтөлбөр боловсруулахдаа өөр өөр алба, нэгжүүдийн төлөөлөл (сургалтын технологич, номын санч, заах арга зүйч, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх төв гэх мэт), оюутнууд, заримдаа бусад тэнхим, хэлтсийн мэргэжилтнүүдийн мэдлэгийг ашигласан холимог багаар ажилладаг.



## 29 Сургалтын хөтөлбөр, дижитал сургалтад нөөцийг боловсруулж, ашиглах стратегийн арга барил

**Гол чиглэл:**
Сургалтын хөтөлбөрийн дизайн |
Сургалтын нөөц

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллага нь сургалтын нөөцийг боловсруулах, удирдах, ашиглах талаар стратеги эсвэл бодлого боловсруулах төлөвлөгөөтэй байгаа.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал технологи ашиглан суралцах, заах, үнэлэхтэй холбоотой стратегид сургалтын хөтөлбөр болон дижитал сургалтад сургалтын нөөцийн боловсруулалт, ашиглалтыг (жишээлбэл, боловсролын нээлттэй эх сурвалж, цахим ном, цахим сэтгүүл болон бусад дижитал контент үүсгэх, ашиглах) тусган оруулсан. Сургалтын нөөц ашиглалтыг тогтмол хянаж, дүгнэж байдаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Сургалтын хөтөлбөрийн багууд дижитал сургалт, үнэлгээнд ашиглах сургалтын нөөцийг боловсруулах, удирдах, ашиглахдаа бусадтай нягт хамтран ажиллах (жишээлбэл, оюутнууд, сургалтын технологич, номын сан ба мэдээллийн мэргэжилтнүүд, мэдээллийн технологийн ажилтнууд). Ашиглалтын талаарх мэдээлэл дээр суурилан нөөцийг тасралтгүй хөгжүүлдэг.

## 30 Сургалтын хөтөлбөр боловсруулахад оюутны оролцоог дэмжих

**Гол чиглэл:**

Сургалтын хөтөлбөрийн дизайн | Оюутны сонголт

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Оюутны дижитал чадавх, төхөөрөмж болон сүлжээнд нэвтрэн ашиглах хүртээмж, ажлын байрны зах зээлийн талаарх өгөгдөл мэдээлэл дээр суурилан хичээл, курс, модулийн дизайныг тодорхойлон гаргадаг.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Суралцагчдаас дижитал технологий ашиглан суралцсан туршлагынх нь талаарх санал хүсэлтийг цуглуулж, сургалтын хөтөлбөрийн загварыг гаргахдаа оруулсан.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Оюутнууд хичээл, курс, модулийг дахин төлөвлөх, дижитал технологи ашиглахтай холбоотой шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог. Тэд сургалтын хөтөлбөрийг хамтран боловсруулдаг.



## 31 Одоогийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, цаашид тэлэх боломжтой сургалтын загварууд

**Гол чиглэл:**

Сургалтын хэлбэрүүд

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Бүх хичээл, курсыг тодорхой хэмжээгээр холимог хэлбэр рүү шилжүүлж, танхимд (биечлэн) суралцах үйл ажиллагаар дижитал сургалтын үйл ажиллагаа, нөөцтэй хослуулсан. Ихэнх сургалтыг холимог хэлбэрт оруулсан ч сургалтын өөр өөр хэлбэрүүдэд зарцуулсан цаг хугацаа харилцан адилгүй.
- Уламжлалт болон технологийн дэвшилтэт аргуудыг байгууллага даяар хослуулан ашиглаж байгаа хэдий ч сургалтын хөтөлбөрийн дийлэнх хувийг уламжлалт, биечлэн заах аргаар явуулдаг хэвээр байна.
- Одоогийн оюутнууд, төгсөгчид болон гадаад түншүүдийг (жишээ нь зайны, нийтэд нээлттэй онлайн курс, онлайн, холимог/хосолмол) татан оролцуулж, сургалтыг илүү өргөн хүрээнд тэлж, бүр олон оюутан, суралцагчдад хүргэх боломжийг нэмэгдүүлэх хичээлийн загвар, сургалтын хэлбэрийн шинэ арга барилыг судлан, хянаж байгаа.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал сургалтыг өөр өөр мэргэжлийн чиглэл, оюутны бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн онлайн, холимог болон хосолсон (ихэвчлэн нэг хичээл дээр танхимын болон/эсвэл онлайн үйл ажиллагааг хослуулах аргыг санал болгох сургалт) аргуудыг ашиглан явуулах байдлаар ихэнх хичээл, хөтөлбөрүүдэд тусган оруулсан.
- Тухайн мэргэжлийн чиглэл, оюутны хэрэгцээг тусгах хамгийн тохиромжтой хичээлийн төрөл, загваруудыг тодорхойлж, баталгаажуулсан. Шинэ хичээлийн төрлүүдийг зохих ёсоор баталгаажуулан, тодорхойлж байгаа.

- Хичээл, курсуудыг боловсруулж, суралцагчдад заах буюу хүргэхэд чиглэсэн бодлого, удирдамжийг боловсруулсан.

- Тохиромжтой хүнийг ажилд авч ба/буюу ажилтнуудын ур чадварыг хөгжүүлснээр шинэ арга барилыг үр дүнтэй хэрэгжүүлэн ашиглах чадвартай, чадварлаг ажилтнуудыг бий болгодог.
- Байгууллага нь янз бүрийн арга барилын үр дүнг хянах, сайжруулах зорилгоор өгөгдөл, аналитик ашигладаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал сургалтын хэлбэр бүх хичээл, курс, хөтөлбөрүүдэд гүн гүнзгий нэвтэрсэн бөгөөд оюутны төрөл бүрийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн олон төрлийн уян хатан, хувь хүнд чиглэсэн сургалтын арга замуудыг ашигладаг.

- Олон улсын болон өөр өөр салбарын түншүүдтэй хамтран ажилласнаар хичээл, курсын төрлийг өргөжүүлж, одоо байгаа хичээлүүдэд шинэлэг арга барил хэрэгжүүлэхэд дэмжлэг болж, янз бүрийн бүлгийн оюутнуудын суралцах туршлагыг сайжруулж байгаа.



## 32 Төгсөгчдийн ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийг тусгах

**Гол чиглэл:**
Сургалтын хөтөлбөрийн дизайн | Сургалтын загвар | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Хичээлийн хөтөлбөр төлөвлөлт нь ирээдүйг идэвхтэйгээр тодорхойлохын оронд төгсөгчдийн ажил мэргэжил, ажлын зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, идэвхгүй хандлагатай. Зарим тэнхимийн зүгээс төгсөгчдийн ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагын өөрчлөлт, ирээдүйн хөгжлийг урьдчилан харахын тулд идэвхтэй хүчин чармайлт гаргадаг. Мэдээ, үйл явдлын тухай уламжлалт хэвлэл мэдээллийн сувгууд, албан бус яриагаар дамжуулан авдаг.

- Төгсөгчдийн ажил мэргэжлийн гараанд шаардагдах ур чадвар, чадамжийн талаар ойлголт авах зорилгоор салбарын түншүүд болон ажил олгогчидтой зарим талаар харилцаа үүсгэсэн.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Сургалтын хөтөлбөр төлөвлөлт нь ирээдүйг харсан, дасан зохицох чадвартай бөгөөд төгсөгчдийн ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийг урьдчилан харж, зохих хичээл сургалтыг санал болгодог. Салбарын тайлан, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, төгсөлтийн үр дүнгийн талаарх Их Британий дээд боловсролын салбарын статистикийн албаны тайлан, шинжээчдийн сүлжээ зэрэг мэдээллийн өргөн хүрээний эх сурвалжийг ашигладаг.
- Сургалтын хөтөлбөрийг тогтмол хянаж, санал болгож буй хичээл, сургалтыг төгсөгчдийн ажил мэргэжил, хөдөлмөрийн зах зээлийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, ач холбогдолтой байлгахад анхаардаг.
- Төгсөгчдийн ажил мэргэжилд шаардагдах ур чадвар, чадамжийн талаар ойлголттой болохын тулд салбарын түншүүд, төгсөгчид болон ажил олгогчидтой идэвхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд үр дүнг нь сургалтын хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгадаг.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Хичээлийн хөтөлбөр төлөвлөлтөнд өнөөгийн чиг хандлагыг тусгаж, өөрчлөлтийг урьдчилан харж, оюутнуудыг ирээдүйн ажил мэргэжил, хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлд бэлтгэхэд анхаардаг. Салбарын түншүүдийн саналыг чиг хандлага болон хөгжил дэвшлийн дүн шинжилгээтэй уялдуулж, өгөгдөлд тулгуурласан дүгнэлтийг мэргэжилтнүүдийн дүгнэлт болон чанарын судалгаатай хослуулдаг.
- Төгсөгчдийн ажил мэргэжил, ажлын зах зээлийн өөрчлөлтийг тусгахын тулд сургалтын хөтөлбөрийг тухай бүрт нь баталгаажуулах процессийн хүрээнд зохих ёсоор батлуулан өөрчилж, сургалтын хөтөлбөр төлөвлөлтийг тасралтгүй сайжруулах, шинэчлэх соёл тогтсон.
- Салбарын удирдагчид, ажил олгогчид болон төгсөгчидтэй урт хугацаанд түншлэл үүсгэж, төгсөгчдийг ажил мэргэжилдээ амжилт гаргахад нь шаардагдах ур чадвар, чадамжыг суралцах хугацаандаа хөгжүүлэхэд нь хамтран дэмждэг.



## 33 Дижитал үнэлгээ, дүгнэлтийн дизайн

**Гол чиглэл:**

Үнэлэх, дүгнэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Үнэлгээний загвар гэдэгт дижитал хэрэгсэл, технологийг ашиглан үнэлгээ, дүгнэлтийн уламжлалт арга барилыг дэмжих явдлыг хамааруулан ойлгоно. Жишээ нь, сургалтын удирдлагын систем эсвэл виртуал сургалтын орчноор дамжуулан гүйцэтгэх боломжтой олон сонголттой асуулт хариулт, онлайн эссэ, богино хариулттай асуултууд гэх мэт үнэлгээ, дүгнэлтийн аргууд.
- Үнэлгээний дизайн, удирдлага, дүн тавих зэрэгт дижитал программ хэрэгсэл ашиглахад нь ажилтнуудаа тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг. Ажилтнууд болон оюутнууд бүтээлийн хулгайг илрүүлэх программ хангамжийн талаар сайн мэддэг. Үнэлгээнд шинэ дижитал аргыг ашиглах, ялангуяа аливаа сургалтын төгсгөлд хийгддэг, өндөр ач холбогдолтой ур дүнгийн үнэлгээний хувьд хийгдэх үнэлгээг магадлах механизм, үйл ажиллагаанд эрсдэлээс болгоомжлох аргачлалыг баримталдаг.
- Аюулгүй, найдвартай байдал гэдэг бол үнэлгээний техникийн дэд бүтцэд тавигдах гол шалгуурууд юм. Дижитал үнэлгээний бүх загварт үнэнч шударга, ёс зүйт байдал, тэгш хүртээмжтэй байдлыг чухал хүчин зүйл болгон авч үздэг.

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал хэрэгсэл, технологийг уран сэтгэмжтэй ашиглан илүү сонирхолтой, хүртээмжтэй, шинэлэг үнэлгээний загвар боловсруулсан. Суралцагчийн төрөл бүрийн хэрэгцээ, сонголтод нийцүүлэн мультимедиа төсөл, онлайн үзүүлэн, симуляци, тоглоомын үнэлгээ аргачлал (жишээ нь, тэмдгээр урамшуулах) зэрэг дижитал үнэлгээний янз бүрийн аргуудыг нэвтрүүлж/эсвэл туршиж байгаа.
- Үр ашиг, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор үнэлгээний автоматжуулсан систем, сургалтын аналитик зэрэг дэвшилтэт үнэлгээний хэрэгслүүдийг нэвтрүүлж байгаа.
- Хүчин төгөлдөр, найдвартай, тэгш оролцоог хангасан, жинхэнэ шалгалт, үнэлгээг бий болгож, дижитал үнэлгээний шинэ чиг хандлага, шилдэг туршлагаас хоцрохгүй байхад нь ажилтнуудыг дэмжиж мэргэжил дээшлүүлэх боломжуудыг санал болгож байгаа. Хичээлийн хөтөлбөрийн баг хамтран ажиллаж, мэдлэгээ хуваалцах байдлаар дижитал үнэлгээний шинэлэг аргуудыг хөгжүүлж, нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулдаг.
- Бүх оюутнуудыг дижитал үнэлгээ, шалгалтанд оролцох боломжтой болгохын тулд дижитал орчны тэгш хүртэмж, тэгш оролцоог сайжруулахад анхаарч байгаа бөгөөд тухайлбал, шаардлагатай нөхцөлд үнэлгээг өөр хувилбаруудаар санал болгох.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал үнэлгээг хичээл, сургалтын хөтөлбөрт нэгтгэсэн. Хиймэл оюун ухаан, машин сургалт, дасан зохицох сургалтын систем зэрэг дэвшилтэт технологиудыг тухайн оюутны хэрэгцээ, ахицад нийцүүлэн өөрчлөгддөг хувь хүнд чиглэсэн үнэлгээг бий болгоход ашиглаж байна. Дижитал технологи ашиглан хамтран суралцагчдаа болон өөрийгөө үнэлэх боломжтой бөгөөд суралцагчид өөрсдийн амжилтын бүртгэлийг эргэн харах, бүртгэх, удирдах, хуваалцахын тулд дижитал хэрэгсэл, үйлчилгээг ашигладаг.

- Өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах үйл явцын дэмжлэгтэйгээр оюутны гүйцэтгэл, санал хүсэлт, сургалтын аналитик дээр суурилсан дижитал үнэлгээний стратегийг тасралтгүй үнэлж, боловсронгуй болгодог.
- Тэнхим хооронд санаа бодлоо солилцсоноор дижитал үнэлгээтэй холбоотой шилдэг туршлага, хэрэгсэл, нөөцийг хуваалцах боломж үүсдэг.

- Сургалтыг бодитой, сонирхолтой болгох үүднээс виртуал болон өргөтгөсөн бодит байдал гэх мэт дижитал үнэлгээний шинэлэг аргуудыг явцын үнэлгээ дүгнэлтэд туршиж үзэхийг ажилтнуудаа зөвлөдөг. Оюутнуудыг үнэлгээг ёс зүйтэй, шударга, аюулгүй байлгахад дижитал программ хэрэгслийн (жишээлбэл, хэлний томоохон загвар) үзүүлэх нөлөөллийн тухай санаа бодлоо солилцохыг уриалдаг.

- Тус байгууллагыг дижитал үнэлгээний инновацын чиглэлээр манлайлагчид тооцож, энэ чиглэлээр судалгаа шинжилгээ, мэдлэг түгээхэд хувь нэмрээ оруулж буй хэмээн үздэг.



## 34 Дижитал технологи ашиглан суралцах чадавх болон суралцах ур чадварыг хичээл, курсэд тусган оруулах

**Гол чиглэл:** Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь шинэ оюутанд зориулсан сургалт дээр болон ирээдүйд шаардлага гарсан үед үндсэн технологиуд болон дижитал ур чадварын ерөнхий сургалтыг санал болгодог.

- Суралцах ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах нөөцөөр хангадаг.

- Зарим сургалтын баг, оюутны төлөөлөгчид дижитал чадавхыг сургалтын үр дүнд оруулахыг дэмжиж байгаа ч энэ нь сургалтын хөтөлбөрт хараахан тусгагдаагүй.

- Дижитал чадавхыг сургалтын чухал үр дүн, ажилд орох чадвар гэж үздэг.

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Оюутнууд төслийн ажил, үнэлгээгээр дамжуулан технологийг нөхцөлд байдалд тохируулан хэрэглэх ойлголттой болж, дижитал болон суралцах ур чадвараа хөгжүүлдэг.

- Байгууллагын чанар баталгаажуулалтын процесст сургалтын хөтөлбөрт дижитал чадавхыг тусган оруулахыг дэмждэг.

- Сургалтын хөтөлбөр/судалгааны загварт дижитал туршлагыг оруулж өгөх нь хүссэн ажилдаа сонгогдох үр дүнг бий болгох чухал алхам юм.

- Оюутнууд/судлаачид ирээдүйн/өөрсдийн мэргэжлийн чиглэлээр хамгийн сүүлийн үеийн дижитал хэрэгслийг ашиглан туршлага хуримтлуулж, дижитал практик дадлагын бүлгүүдэд хамрагддаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Зохих шаардлагатай дижитал чадавх, суралцах ур чадварыг хөгжүүлэх явдлыг сургалтын хөтөлбөрийн загварт бүрэн тусган оруулсан бөгөөд үүнийг суралцагч/төгсөгчийн ур чадвар, судалгаа хийх зааварчилгаа, төгсөх буюу ур дүнгийн үнэлгээ зэрэгт тусгасан байдлаар магадлан итгэмжлэгдсэн.
- Дижитал технологийн шинэлэг хэрэглээ нэвтрүүлэх нь тухайн байгууллагын сургалтыг өрсөлдөгчийнхөөс ялгах гол хүчин зүйл юм.
- Төгсөгчийн дижитал чадавхыг зохих ёсоор хичээл, курсуудад оруулж, ажил эрхлэлтийн хөтөлбөрт бүрэн тусгасан.
- Виртуал орчин, симуляци гэх мэт дижитал хэрэгслүүд ашиглан жинхэнэ мэт орчин үүсгэж суралцах явцыг хурдасгаж, сайжруулдаг. Ирээдүйд ажилд ороход тавигдах шаардлагуудыг урьдчилан таамаглах зорилгоор аж үйлдвэр, ажил олгогчидтой нягт уялдаатай байж сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг.



## 35 Дижитал болон онлайн сургалтын талаарх судалгааг уриалан дэмжих

**Гол чиглэл:**
Сургалтын хэлбэрүүд | Үр бүтээмжтэй дижитал суралцагчид | Оюутан суралцах
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал болон онлайн сургалтын боломжийг судлах судалгааг тусгай баг (жишээ нь, сургалтын шилдэг туршлагын төв, заах арга зүйч, сургалтын технологичид) эсвэл сонирхсон эрдэмтэн судлаачид удирдан явуулдаг.
- Судалгааны үйл ажиллагаа нь дижитал сургалтын технологи, сурган хүмүүжүүлэх арга барил, үр дүнтэй дижитал сургалтын орчныг ойлгоход чиглэгддэг. Үүнийгээ байгууллага доторх стратеги төлөвлөлт, ажилтны хөгжил/дэмжлэг, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэгт тусган оруулдаг. Туршилтын төслүүдээр дамжуулан байгууллагын хүрээнд дижитал болон онлайн сургалтыг хэрэгжүүлэх боломжийн талаар судалж байгаа.
- Бусад байгууллагуудтай зарим талаар хамтран ажиллаж, судалгааны үйл ажиллагаа, үр дүн, туршлагаа хуваалцдаг.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал болон онлайн сургалтын талаарх судалгаанд эдгээрийн тэнхимүүдэд хэрхэн хэрэгжиж буйг үнэлэх гүнзгийрүүлсэн судалгааг мөн хамруулна. Судалгааны үр дүнд суурилан оюутны үр бүтээмжийг сайжруулах олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өгөгдлийн аналитикийн үр дүнг судалгаанд тогтмол ашигладаг.
- Дижитал сургалтын судалгаа, хөгжлийн тусгай төв нь мэдлэг туршлага солилцох, хамтран ажиллах төвийн үүрэг гүйцэтгэнэ.
- Салбарын манлайлагчид, edtech буюу боловсролын технологийн компаниуд болон бусад боловсролын байгууллагуудтай түншилж судалгааны цар хүрээ, үр нөлөөг өргөжүүлдэг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь дижитал болон онлайн сургалтын судалгааны чиглэлээр манлайлагч хэмээн танигдсан. Сургалтыг сайжруулах шинэлэг, тэсрэлтэт технологийг (жишээлбэл, боловсролын салбар дахь хиймэл оюун ухаан, дасан зохицох буюу нөхцөл байдлаас хамааруулан өөрийгөө тохируулдаг сургалтын технологи, хувь хүнд чиглэсэн сургалт) хэрхэн ашиглах талаар судлаачид судалж байгаа. Дижитал болон онлайн сургалтын тэгш байдал, олон талт байдал, тэгш оролцоо, байгаль орчны тогтвортой байдал, чанар, сургалтын туршлагад үзүүлэх нөлөөллийг судалгааны бүх үйл ажиллагаанд тооцон авч үзсэн буюу оруулсан.
- Тус байгууллага нь дижитал болон онлайн сургалтын талаарх үндэсний болон олон улсын бодлогыг боловсруулахад идэвхтэй оролцож, тэгш хүртээмж, чанарын баталгаа сурталчлан дэмждэг. Мөн дижитал сургалтыг боловсронгуй болгон, сайжруулахад судалгааны үр дүнг ашиглан тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлж, шилдэг туршлагыг бусад эрдэмтэн судлаачидтай хуваалцдаг.

# Дижитал технологи ашиглан суралцах

Дижитал төхөөрөмж, мэдээллийн хэрэгсэл, орчин, эсвэл дижитал программаар дамжуулан суралцах үйл явц. Дижитал сургалт нь шууд биечлэн, шууд онлайнаар эсвэл асинхрон буюу шууд бус хэрэгсэл, орчноор дамжуулан явагдах боломжтой.
Үүнд ажилтнуудын дижитал сургалт, хөгжил, түүнчлэн оюутнуудын албан болон албан бус сургалтууд багтана



## 36 Дижитал хувь хүний/мэргэжлийн хөгжлийн боломжууд

**Гол чиглэл:**
Ажилтны хөгжил | Ажилд авах, тогтвортой ажиллуулах | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Ажилтнууд өөрийн ур чадварт дүн шинжилгээ хийх, мэргэжлийн хөгжил эсвэл гүйцэтгэлийн үнэлгээний зорилгоор дижитал хэрэгслийг ашиглах албан ёсны боломж хязгаарлагдмал байдаг. Эрүүл мэнд, аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, MS Teams эсвэл MS Office зэргийн лицензээр хамгаалагдсан технологи гэх мэтийг танилцуулах сургалтын хүрээнд онлайн сургалт явуулах зарим нэг боломж байгаа (буюу худалдаж авсан).
- Ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөрт биечлэн оролцох сургалтыг тодорхой өдөр заан явуулах, багийн хөгжлийн сургалт, гадны сургалт, арга хэмжээнүүдэд голчлон анхаарна.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллага нь тухайн ажилтны ажил үүргийн хэрэгцээнд нийцүүлэн дижитал чадавхын төлөвлөгөөний нэг хэсэг болох дижитал сургалтын боломжоор хангаж санал болгодог.
- Ажилтнуудыг мэргэжлийн хөгжил, үнэлгээний үйл ажиллагааны хүрээнд өөрсдийн дижитал чадавхыг бие даан үнэлж, хөгжлийн хэрэгцээгээ тодорхойлохыг дэмждэг.
- Заах арга зүйн сайн загвар дээр суурилсан, ажил үүргээ биелүүлэх явцад сурч мэдсэн зүйлдээ дүн шинжилгээ хийж, батлан харуулах боломж олгох механизмуудтай нэгтгэсэн дижитал сургалтын боломжуудыг ажилтанд санал болгодог
- Байгууллагаас гадуурх мэргэжил нэгтнүүдийн хамт ур чадвараа дээшлүүлэх, туршлага солилцох, харилцаа холбоо тогтоох зорилгоор гадны онлайн сургалтуудад хамрагдахыг ажилтнуудад (өөрөөр хэлбэл, цаг хугацаа, дэмжлэг) уриалан дэмждэг.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал сургалтанд хамрагдан сурсан зүйлдээ дүн шинжилгээ хийх, сургалтанд хамрагдсан явдлыг сайшаан, урамшуулах боломжийг байгууллага даяар дэмжин, санал болгодог.

- Байгууллагын дотоодын дижитал сургалтын мэдлэг, туршлагыг хуримтлуулан байгууллагаас гадуурх дээд боловсролын салбарын ажилтнуудын хөгжил (жишээ нь, богино хэмжээний курс, нээлттэй курс, практик дадлагын хамтын бүлэг) дэвшилд ашигладаг.

- Дижитал сургалтад төвлөрсөн хичээл, курсуудыг янз бүрийн түвшинтэйгээр (богино хэмжээний курс, диплом, бакалавр, магистр гэх мэт) санал болгодог бөгөөд салбарын мэргэжилтнүүдэд сайн туршлагыг үлгэрлэн харуулна.
- Ажилтнууд мэргэжлийн ахисан түвшний ур чадвар (жишээ нь, үндэсний заах арга зүйн тэтгэлэг, мэргэжлийн итгэмжлэл) олж авах, мэргэжлийнхээ чиглэлээр судалгаа хийх зорилгоор байгууллагаас олгосон дижитал хэрэгслийг зохих ёсоор ашигладаг.



## 37 Суралцагчдын дижитал чадавхыг хөгжүүлэх

**Гол чиглэл:**
Үр бүтээмжтэй дижитал суралцагчид | Оюутан суралцах | Дижитал чадавх | Номын сан, сургалтын нөөц

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Байгууллагаас оюутнуудад дижитал чадвар, бүтээлч байдлаа хөгжүүлэхэд нь анхаарч, суурь түвшний дижитал чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Байгууллагаас хангасан технологи, хэрэгсэл, платформыг ашиглахад шаардлагатай дэмжлэг, зааварчилгаа бий бөгөөд үүнийг зарим нэг онлайн хичээлээр мөн дамжуулан үзүүлдэг.
- Сүлжээ, платформ, сургалтын орон зайд хандах хандалтын үйлчилгээг оюутны хотхонд буй оюутнуудад нэн тэргүүнд үзүүлдэг. Шинэ оюутанд зориулсан танилцуулах сургалтыг тэнхимд биечлэн явуулахдаа үндсэн чиг баримжаа олгох ерөнхий мэдээллийг өгдөг.
- Оюутнуудын программ хэрэгсэл, сүлжээ, платформд хандах хандалтын талаар зарим өгөгдлийг цуглуулдаг ба асуудлыг шийдвэрлэхэд идэвхгүй хандлага давамгайлдаг.

- Хичээлийн дизайнд зарим интерактив элементүүд болон мультимедиа контентууд багтдаг боловч оюутнуудын дижитал сургалтын чадавхын түвшний талаарх ойлголт хязгаарлагдмал байдаг.

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал технологи ашиглан үр дүнтэй суралцах чадавхыг хөгжүүлэхэд оюутнуудад дэмжлэг хэрэгтэй гэдгийг байгууллага хүлээн зөвшөөрдөг. Суурь түвшний дижитал боловсрол эзэмших сургалт, семинар, зааварчилгаа болон нэмэлт сургалтуудыг олон төрлийн дижитал чадавхын (жишээлбэл, дижитал харилцаа холбоо, хамтын ажиллагаа, мэдээлэл ба өгөгдлийн суурь боловсрол, дижитал дүр төрх бүрдүүлэх менежмент, дижитал сайн сайхан байдал, дижитал сургалт) хүрээнд санал болгодог.
- Шаардлагатай программ хэрэгсэл, платформ, сургалтын болон суралцах орон зай, нөөцөд хандах боломж олгоход идэвхитэй хүчин чармайлт гаргадаг ба үүнд зээлээр олгох төхөөрөмж, туслах технологи, дасан зохицох сургалтын технологи, олон төрлийн сургалтын орон зай орно.

- Уян хатан, сонирхолтой хичээлийн загварт төрөл бүрийн мультимедиа контент, интерактив элементүүдийг, мөн зохион байгуулалттай үйл ажиллагаа, төслүүдээр дамжуулан онлайнаар харилцах, хамтран ажиллах илүү өргөн боломжуудыг багтаасан байдаг.

- Оюутнууд виртуал ажлын цаг, түргэн хариу өгдөг харилцааны сувгууд зэрэг олон төрлийн баг, үйлчилгээнээс дэмжлэг үйлчилгээ, үнэлгээ дүгнэлтийг хялбар авах боломжтой.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Оюутнуудыг үр дүнтэй дижитал суралцагч болоход нь дэмжлэг үзүүлэх нь байгууллагын дижитал чадавхыг хөгжүүлэх төлөвлөгөөний чухал хэсэг юм. Дижитал чадавхыг сургалтын хөтөлбөрт нэгтгэж, цагийн менежмент, өөртөө дүн шинжилгээ хийх, шүүмжлэлтэй оролцох, өөрийгөө удирдан залах болон дижитал сургалтын амжилтанд зайлшгүй шаардлагатай бусад ур чадварын удирдамж, дижитал нөөцөөр хангадаг. Байгууллага даяар үр дүнтэй суралцахад шаардагдах дижитал чадавхтай холбоотой нийтлэг ойлголттой бөгөөд үүнд олон багийн санал зөвлөмж тусгагдсан байдаг.
- Биет болон дижитал механизмыг хослуулснаар ахиц дэвшил, амжилтыг бүртгэн хянах явдлыг нэмэгдүүлэхдээ цаг алдалгүй, түргэн дэмжлэг үзүүлж, санал зөвлөмж өгч, удирдамжаар хангадаг.
- Тэгш оролцоог хангахад чиглэсэн дэмжлэг үзүүлж, санаачилгууд хэрэгжүүлснээр оюутнуудад оюутны хотхон дотор болон гаднаас программ хэрэгсэл, платформ, сургалтын болон суралцах орон зай, дижитал контентод хандахад саад бэрхшээл учирдаггүй.
- Оюутнуудыг хамтрагчаар татан оролцуулснаар сургалтын төрөл бүрийн хэрэгцээ, сонголтод нийцсэн хичээлийн дизайн гаргах боломж бүрдсэн.
- Байгууллагын программ хэрэгсэл, платформууд нь онлайн харилцаа, хамтын ажиллагаар дэмжиж, оюутнуудад оюутны хотхоноос гадуур байх үедээ ч гэсэн бусдынхаа хамт байгаа мэт мэдрэмж төрүүлнэ.



## 38 Өөрөө зохицуулан, бие даан суралцахыг дэмжих дижитал боломжууд

**Гол чиглэл:**
Бие даан суралцах | Номын сан, сургалтын нөөц
Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Дижитал сургалтын платформууд нь бие даан суралцахад дэмжлэг үзүүлэх үндсэн боломжуудыг санал болгодог (жишээлбэл, хичээлийн материалд хандах, ахиц дэвшлийг хянах, үнэлэх хэрэгсэл).
- Хамтран суралцагчид хоорондын дижитал хамтын ажиллагаа, харилцаа холбоог бий болгох зарим боломжуудаар хангадаг боловч үр ашгийнх нь талаар оюутнууд сайн ойлгодоггүй. Оюутнууд сурч мэдэхээс илүүтэй төгсгөлийн шалгалт өгөхөд анхаардаг.
- Дижитал номын сангийн үйлчилгээгээр илүү өргөн хүрээний сан хөмрөг, нөөцөд хандах боломжтой ба оюутнуудад курсын ажлын судалгаагаа өргөжүүлэхэд нь туслах онлайн хичээлүүдийг санал болгодог.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал сургалтын платформууд нь мультимедиа контент, гар утсанд тохирсон интерфэйс зэргийг ашиглан тэгш хүртээмж, уян хатан байдлыг сайжруулах замаар өөрөө бие даан суралцах сургалтыг дэмждэг.
- Явцыг хянаж, дүн шинжилгээ хийх нь суралцагчдад зорилго тавьж, гүйцэтгэлээ хянах боломжийг олгодог.
- Сургалттай холбоотой хэлэлцүүлгийн форум, баг болж хийх төслүүдээр дамжуулан хамт суралцагчидтайгаа хамтран ажиллах боломжийг уриалан дэмждэг.
- Тус байгууллага нь хувь хүнд чиглэсэн сургалтын хэрэгцээ, сонголтыг дэмжих зорилгоор дасан зохицох буюу нөхцөл байдлаас хамааруулан өөрчлөгддөг сургалтын технологи, хувь хүнд чиглэсэн боломжуудыг нэвтрүүлсэн.
- Олон төрлийн дижитал сургалтын эх сурвалж, материалд ашиглах боломжтой болсноор олон ургалч үзэл бодлыг төлөвшүүлэхэд нөлөөлдөг бөгөөд мэдээллийн суурь боловсролын дэмжлэг үзүүлж, сургалт явуулснаар олон төрлийн материалаас мэдээлэл авч, идэвхтэй судлах үүд хаалгыг нээнэ.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Найдвартай, хүртээмжтэй, уян хатан программ хэрэгсэл, платформ, сүлжээ, контентуудаар хангаснаар өөрөө зохицуулалт хийн, бие даан суралцах боломжийг олгодог. Оюутнууд суралцаж буй хичээлийнхээ хүрээнд бие даан суралцах боломжтой бөгөөд ашиг тусыг нь ойлгодог.
- Явцыг хянаж, аналитик дүгнэлт хийн, шуурхай санал зөвлөмж өгснөөр суралцагчид өөрсдийн сургалтын стратегид нийцүүлэн өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах боломж олгодог.
- Суралцагчид, багш нар, туслах багш нар өөрсдийн мэргэжлийн чиглэлээр оролцоогоо өргөжүүлж, харилцан мэдлэг туршлага солилцох зорилгоор сургалтын нийгэмлэг, бүлгүүд, мэргэжлийн хүрээлэл үүсгэж, идэвхтэй оролцдог.
- Хувь хүнд чиглэсэн сургалтын арга замууд нь дасан зохицох сургалтын дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанд суурилсан зөвлөмжүүдийг нэвтрүүлсэн байдаг.
- Оюутнууд өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн бүтээл, гадны эх сурвалжаас бэлтгэсэн материал, нээлттэй контент зэрэг баялаг, олон төрлийн сургалтын нөөцөд хандах боломжтой. Мөн тэднийг өөрсдийн бүтээлээ хуваалцахыг дэмждэг.
- Цагийн менежмент, бүтээлч байдлыг дэмжих программ хэрэгслүүдийн тусламжтайгаар суралцагчид сурах арга барилаа удирдаж, боловсролын зорилгодоо илүү анхаардаг.



## 39 Суралцагчдын сонгосон мэргэжлийн замналд шаардагдах дижитал ур чадварын тухай ойлголт ба суралцах хугацаандаа үүнийг хөгжүүлж, дадлагажих боломж

**Гол чиглэл:**
Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал чадавхыг суралцагч/төгсөгчийн сургалтаар олж авах чухал үр дүн, хөдөлмөр эрхлэх ур чадвар хэмээн үздэг.
- Дижитал ур чадвар, бүтээмж, дижитал харилцаа холбоо, хамтын ажиллагаа зэрэг ерөнхий дижитал чадавхыг дэмжих зорилгоор дижитал суурь боловсролын талаарх үндсэн зааврыг онлайн байршуулж, дэмжлэг үзүүлнэ.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал практик дадлыг сургалтын хөтөлбөр/судалгааны загварт оруулж өгөх нь оюутан, суралцагчдыг ажил хөдөлмөрийн гараанд бэлдэх чухал алхам юм.
- Оюутнууд/судлаачид өөрсдийн мэргэжлийн чиглэлээр/ирээдүйн мэргэжлээрээ хамгийн сүүлийн үеийн дижитал хэрэгслийг ашиглан туршлага хуримтлуулж, дижитал практик дадлагын нийгэмлэг, бүлгүүдэд хамрагддаг.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дижитал чадавхыг зохих журмын дагуу хичээл, курсуудад бүрэн оруулж өгсөн ба өөрчлөгдөн буй хэрэгцээ, ирээдүйд хүлээгдэж буй эрэлт хэрэгцээг тусган шинэчилдэг.
- Виртуал орчин, симуляци гэх мэт дижитал хэрэгслүүд ашигласнаар жинхэнэ мэт орчин үүсгэж суралцах, үнэлгээг илүү бодитой болгох боломжуудыг бий болгож, сургалтыг түргэтгэж, сургалтаас авах туршлагыг сайжруулдаг.
- Оюутнууд сургалтын хөтөлбөрийн баг, төгсөгчид, салбарын болон мэргэжлийн түншүүдтэй ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, чиг хандлагын талаар ярилцаж, энэ нь эргээд хичээл, курсын хөгжилд хувь нэмэр оруулдаг.

## 40 Суралцагчид амжилтаа бүртгэх, гаргаж буй ахиц дэвшилдээ дүн шинжилгээ хийх боломжууд

**Гол чиглэл:**
Оюутны ахиц | Э-портфолио | Хувь хүнд чиглэсэн сургалт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Зарим дижитал шийдлүүдийн тусламжтайгаар оюутнууд өөрсдийн амжилт, ахиц дэвшлийг хянах боломжтой болдог. Сургалтын удирдлагын систем ашигласнаар оюутнуудыг хичээлийн материалд хандах, даалгавараа илгээх, дүнгээ харах боломжоор хангадаг.
- Уламжлалт ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээгээр биечлэн зөвлөгөө өгөх ба ажлын байрны жагсаалт, анкетын загвар зэрэг ерөнхий онлайн эх сурвалж бүхий ажлын байрны ярмаг зохион байгуулна.
- Өгөгдлийн аналитикийг зарим талаар хэрэглэж оюутны ахиц дэвшлийг хянаж, санал зөвлөмж өгөх боломжтой болсон

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Ахисан түвшний программ хэрэгсэл болон системүүдээр дамжуулан суралцагчдад өөрсдийн амжилт, ахиц дэвшлийг хянах, өөрийн хөгжил, ур чадвартаа дүн шинжилгээ хийхэд тусалдаг. Үүнд хувь хүний сургалтын төлөвлөгөө, бодит хугацаанд ахиц дэвшлээ хянах, ажил мэргэжлийн чиглэлээр зураглал гаргах, онлайн портфолио болон чадамжид суурилсан үнэлгээ орно.
- Сургалтаар ажил мэргэжлийн чиглэлээр хөгжихтэй холбоотой ойлголтуудыг хичээл, курсын загварт нэгтгэн оруулсан бөгөөд оюутнууд ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиглэлээр хүмүүстэй холбогдох боломжууд, ажил мэргэжлийн үнэлгээний хэрэгсэл, виртуалаар танилын хүрээ өргөжүүлэх арга хэмжээ зэрэг олон төрлийн ажил мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж өгөх үйлчилгээг авах боломжтой.
- Мэдээллийн аналитик ашиглан оюутны гүйцэтгэлийн хэв маягийг тодорхойлдог ба өсөлт, хөгжилтийг нь дэмжих зорилтот арга хэмжээнүүдийг санал болгодог.
- Оюутнуудын сурсан ур чадвар, ахиц дэвшлийг үнэлэн, харуулах зорилгоор дижитал тэмдэг, микро кредит олгодог.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Цогц бөгөөд хувь хүнд чиглэсэн сургалтын экосистемийн дэмжлэгтэйгээр оюутнуудад өөртөө дүн шинжилгээ хийх боломж олгож, амжилт, ахиц дэвшлийг нь бүртгэх олон төрлийн механизмаар хангадаг.
- Хувь хүний сургалтын хэрэгцээнд дасан зохицох хиймэл оюун ухаанд суурилсан системүүдээр дамжуулан оюутны амжилтыг сайжруулахад тохирсон сургалтын арга зам, нөөцийг санал болгодог.
- Дижитал ажил мэргэжлийн үйлчилгээнд төгсөгчид болон салбарын мэргэжилтнүүдээс виртуал зөвлөгөө авах боломжууд, ажлын байранд тохируулан холбох алгоритмууд болон хувь хүний ажил мэргэжлийн замын зураглал зэрэг орно.
- Сургалтын аналитик, урьдчилан таамаглах аналитик болон дасан зохицох сургалтын технологийг нэгтгэн оруулж сургалтын туршлагыг тасралтгүй сайжруулж, сурагчдын ахиц дэвшлийг идэвхтэй дэмждэг.
- Орон нутгийн үйлдвэрлэл, аж үйлдвэрийн салбартай нягт түншилж практик, ур чадварт суурилсан сургалтын туршлага олгоход анхаарч, оюутнуудын ажил мэргэжлийн боломжийн талаар санал зөвлөмжийг бодит хугацаанд буюу цаг тухайд нь шууд хүргэдэг.

## 41 Дижитал суралцагчдын олон талт хэрэгцээ

**Гол чиглэл:**
Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Оюутны сонголт | Уян хатан сургалт | Оюутанд үзүүлэх дэмжлэг | Хувь хүнд чиглэсэн сургалт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь технологи, сүлжээ, дижитал контент болон сургалтын орон зайд нэвтрэх (болон ашиглах) зэрэгтэй холбоотой асуудлыг тодорхойлохын тулд янз бүрийн суралцагчдын бүлгийн олон төрлийн хэрэгцээ, шаардлагыг авч үзэн үнэлдэг. Судалгаа, фокус бүлэг, сургалтын аналитик программ хэрэгслээс авсан өгөгдлийн шинжилгээн дээр суурилан энэ процессийг хэрэгжүүлдэг.
- Оюутны илэрхийлсэн хэрэгцээ, шаардлагад зарим талаараа нийцсэн контент, технологи, туслах үйлчилгээ бий.
- Кампусаас гадуурх оюутнуудад үйлчилгээ үзүүлэхийн тулд сургалтын янз бүрийн хэлбэрийг судлан, авч үзэж байгаа. Удирдамж, дүрэм журамд заасны дагуу онлайн контентыг ерөнхийд нь ашиглах боломжтой.
- Олон янзын хэрэгцээ, шаардлагад идэвхгүй байдлаар ханддаг бөгөөд суралцах үйл явцад олон янзын хэрэгцээ шаардлага байдаг талаар ойлголт хязгаарлагдмал байдаг (жишээлбэл, дижитал болон өгөгдлийн ядуурал, хөгжлийн бэрхшээл, мэдрэлийн гажуудал, сэтгэцийн эрүүл мэнд, хэлний бэрхшээл болон бусад нийгмийн харилцааны бэрхшээлүүд, олон улсын оюутнууд).
- Танилцуулах өдөрлөг, хичээл, семинар, зааварчилгаа өгөх гэх мэтээр дамжуулан программ хэрэгсэл, технологийг (жишээ нь, хиймэл оюун) ёс зүйтэй, зохистой ашиглах талаар оюутнуудтай тогтмол ярилцах боломж байдаг.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал сургалтын үйл ажиллагаа, нөөц, дэмжлэг, платформ, хэрэгслийн загварыг гаргаж, төлөвлөхдөө янз бүрийн хэрэгцээ, шаардлага байдгийг харгалзан үздэг ба тэгш оролцоо, тэгш хүртээмжийн асуудлыг байгууллагын үнэт зүйл, стратегид онцолсон байдаг.
- Дижитал дэд бүтцийг хөгжүүлж оюутны хотхон доторх болон гаднах оюутнуудын янз бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн найдвартай байдал, аюулгүй байдал, холболтыг сайжруулсан.
- Тогтсон процессоор суралцагчдын янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээг тодорхойлж, үнэлдэг. Эдгээр процесст өгөгдөлд тулгуурласан дүгнэлт, оюутнууд болон сонирхогч талуудын байнгын харилцаа, санал зөвлөмж гэх мэт орно. Оюутнууд өөрсдийн дижитал чадавх болон ямар программ, хэрэгсэл, технологид хандан ашиглах хэрэгцээгээ үнэлэх боломжтой. Дижитал сургалтын өмнөх туршлагыг хүлээн зөвшөөрч, харгалзан үздэг (жишээлбэл, олон улсын оюутнуудын хувьд).
- Холимог сургалтын хэлбэрийг санал болгосноор оюутнуудыг өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрхэн, хэзээ оролцохоо сонгох зарим нэг боломжоор хангасан. Алсын зайнаас суралцагчдад зориулсан дижитал сонголтуудаар (жишээ нь чат, видео хурал) дамжуулан мэргэжилтний дэмжлэг үйлчилгээг өргөжүүлсэн. Оюутнууд өөрсдийн төхөөрөмж, хэрэгслээ ашиглахад, мөн эдгээрийн аюулгүй, найдвартай байдлыг хангаж, хичээл сургуулийн орчинд ёс зүйтэй ашиглахад дэмжлэг үзүүлдэг.
- Салбарын түншүүд болон бусад байгууллагууд зэрэг олон оролцогч талуудтай хамтран ажиллаж, суралцагчдын тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад тулгуурлан үйлчилгээгээ тасралтгүй сайжруулах, өргөжүүлэхэд анхаардаг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Оролцоо, хэрэгцээг системтэй үнэлэх замаар нийгмийн өөр өөр бүлгийн суралцагчдын хэрэгцээг хангах нь байгууллагын эрхэм зорилго, үнэ цэнд тодорхойлж буй гол зорилго юм.
- Санал асуулга, фокус бүлэг, хиймэл оюун ухаан, машин сургалт, урьдчилан таамаглах аналитик зэрэг суралцагчдын төрөл бүрийн хэрэгцээг тодорхойлж, үнэлэхдээ биет болон дижитал аргуудыг хольж ашигладаг.
- Шинэ оюутныг хүлээн авч, танилцуулах сургалтаар оюутнуудад суралцахад тавигдах шаардлага, технологийг хэрхэн ашиглах талаар бодит мэдээлэл, тодорхой ойлголт өгдөг.
- Танилцуулах сургалтаар хувь хүний сургалтын төлөвлөгөө боловсруулж, технологийн шаардлага, дижитал сургалтын чадавх, дижитал хэлбэрээр суралцахад тодорхойлох хэрэгцээ зэргийг эхний байдлаар үнэлж, дүгнэнэ. Оюутнуудад үүнийгээ суралцах хугацааныхаа туршид биет болон дижитал аргууд хослуулан үе үе хянаж байхыг уриалан, дэмжинэ.
- Үнэлж гаргасан хэрэгцээ, шаардлагад үндэслэн дасан зохицох сургалтын систем, виртуал болон өргөтгөсөн бодит байдал, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын аналитик зэрэг сургалтын шинэлэг арга, технологиуд ашигласнаар илүү хувь хүнд чиглэсэн, хүртээмжтэй сургалт явуулах боломжийг нэмэгдүүлсэн.
- Оюутнууд тасралтгүй сайжруулалт, инновацын соёлыг төлөвшүүлж, систем, үйлчилгээ, контентыг төлөвлөж, боловсруулахад идэвхтэй оролцдог.
- Бүх оролцогч талууд систем, үйлчилгээнд нэвтрэх үед мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангана.

## 42 Дижитал мэдээлэлд бодитоор болон зайнаас саадгүй нэвтрэх

**Гол чиглэл:**
Номын сан, сургалтын нөөц | Оюутанд үзүүлэх дэмжлэг
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Номын сангийн зүгээс оюутны хотхон дотор болон гаднах оюутнуудад туслах олон төрлийн дижитал үйлчилгээг санал болгодог. Тогтсон технологи, хэрэгсэл, системүүдийн дэмжлэгтэйгээр номын сангийн бүх үйл ажиллагаа явагддаг. Цуглуулгын буюу сан хөмрөгийн менежмент, мэдээлэл олж илрүүлэх, татах, хадгалах, өгөгдөл цуглуулж дүн шинжилгээ хийх, судалгаа хийх, суралцахад дэмжлэг үзүүлэхэд технологи ашиглах тал дээр өндөр түвшний мэдлэг, туршлага бий.
- Багш, оюутнуудыг ном болон бусад нөөцөөр хангахад "нэгдүгээрт дижитал технологи" хандлагыг дэмжих бодлогыг номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд боловсруулсан.
- Сургалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлах зорилгоор дижитал цуглуулга, сан хөмрөгийг тогтмол хянах үйл ажиллагаар байгууллага даяар зохион байгуулдаг.
- Суралцах, заах, судалгаа хийх үйл ажиллагаар дэмжих зорилгоор номын сангийн зүгээс цахим ном, цахим сэтгүүл, мэдээллийн сан, мультимедиа материал, нээлттэй боловсролын эх сурвалж зэрэг олон янзын дижитал нөөцөөр хангадаг. Тухайн номын санд хадгалагдаагүй материалыг олж авах боломжоор хангаж, номын сан хооронд зээлдүүлэх механизм бий.
- Оюутнуудад дэмжлэг үзүүлж судалгааны гарын авлага, хичээл зааварчилгаа болон бусад онлайн нөөцөөр хангадаг.
- Номын сангийн нийгмийн сүлжээний хуудсанд тогтмол мэдээлэл оруулж, шинэчилж байдаг нь суралцагчдын оролцоог дэмжиж, шинэ мэдээг хуваалцаж, номын сангийн үйлчилгээ, сан хөмрөгийг сурталчилдаг.
- Семинар хийж, онлайн хичээлүүд явуулснаар оюутнууд болон багш нарт мэдээллийн суурь боловсролын ур чадвараа хөгжүүлж, дижитал нөөцийг удирдахад тусалдаг.
- Дижитал хэрэгсэл, суралцах орон зайд хандан ашиглах боломж олгон, дэмжлэг үзүүлснээр бие даан болон хамтран суралцах үйл явцыг дэмждэг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Хэрэглэгчийн туршлагыг сайжруулж, сургалт, судалгааг дэмжих технологи, тогтсон практик туршлагыг ахисан түвшинд хэрэглэж, сургалтын үйл явцад дижитал шилжилт хийхэд номын сан чухал хувь нэмэр оруулдаг.
- Дижитал хэлбэрт шилжүүлэх замаар бүрэн цогц сан хөмрөгийн нөөцөөр багш, судлаач, оюутнуудыг хангахад туслах систем, ажлын дараалал бий болсон. Мета өгөгдлийн стандартчилал болон хайлтын системд дижитал контентыг оруулж өгснөөр хэрэгтэй материалаа хайж олоход дөхөмтэй болсон. Номын сангийн ажилтнуудын зүгээс дундын дижитал нөөцөөр хэрхэн хангах талаар шинэлэг арга барилыг судалж байгаа.



- Төрөлжсөн мэдээллийн сан, дижитал архив, байгууллагын сан зэргийн тусламжтайгаар сургалтыг дэмжих дижитал нөөцийн төрлийг нэмэгдүүлдэг.
- Номын сангийн вэб сайт/портал нь хувь хүн хүсэл, сонирхолдоо нийцүүлэх боломжтой сонголтуудыг агуулсан. Нийгмийн сүлжээний хуудсыг идэвхтэй ажиллуулснаар хэрэглэгчдийг татан, оролцоо хүрээллийг бий болгон, ашиглах боломжтой нөөцийн талаарх мэдээлэл өгдөг. Номын сангийн дэмжлэг үйлчилгээг алсын зайнаас хандан авах боломжтой, жишээлбэл, виртуал лавлах чат эсвэл номын санчтай онлайнаар зөвлөлдөх.
- Номын сангийн систем болон сургалтын удирдлагын системийг нэгтгэн саадгүй ажилладаг болгосноор оор үнэн зөв, өндөр чанартай өгөгдөл, сургалтын аналитик мэдээллийг хуваалцахад хялбар болсон.
- Технологи ашиглан өргөтгөсөн хувийн сургалтын орон зай, дижитал төв, бүтээлч орон зай, багаар ажиллах орон зайгаар хангах замаар янз бүрийн хэлбэрээр суралцах үйл явцыг дэмжих чухал нөөцөд номын санг тооцдог.
- Багш нартай нягт түншлэн ажилласнаар сургалтын хөтөлбөр боловсруулах, заах арга зүйг сайжруулах боломж олгодог.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Номын сан нь технологийг өндөр түвшинд ашиглаж, сургалтын үйл ажиллагааг дэмжсэн шинэлэг номын сангийн үйлчилгээ явуулдагаараа салбартаа (болон олон улсад) тэргүүлэгч хэмээн тооцогддог.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд дижитал сургалт, үнэлгээний стратеги төлөвлөгөөнд хувь нэмрээ оруулдаг.
- Номын сангийн системүүдийг нэгтгэснээр (жишээ нь, каталогуудыг нэгтгэсэн) хэрэгтэй материалаа хайж, олох боломжоор хангасан. Чатбот, машин сургалтын алгоритм зэрэг хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлж хэрэглэгчийн туршлагыг сайжруулж, номын сангийн үйлчилгээг сайжруулсан.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд нь сонгосон дижитал нөөцийг хэрэгцээтэй, зарцуулсан зардлынхаа үнэ цэнд хүрч буй эсэхийг баталгаажуулахаар тэнхим, багш нартай нягт харилцаатай байдаг ба сургалт, үнэлгээний үйл ажиллагаанд мэдээллийн суурь боловсрол болон дижитал нөөцийн зохистой ашиглалтыг тусгуулахаар сургалтын хөтөлбөрийн багуудтай хамтран ажилладаг.
- Номын сан хооронд нөөц зээлдүүлэн хэрэглэх төрөл бүрийн механизмуудын дэмжлэгтэйгээр хүссэн дижитал контент руу нэвтрэн ашигладаг.
- Дижитал хадгалалтын дэвшилтэт стратегиуд боловсруулан дижитал сан хөмрөг, цуглуулгын урт хугацааны хүртээмж, ашиглалтыг хангасан.
- Оюутны суралцах явцын өгөгдөлд аналитик шинжилгээ хийх, мэдээллийг дүрслэн гаргах программ хэрэгсэл ашиглан гаргасан үр дүнд суурилан стратеги төлөвлөлтийг боловсруулж, номын сангийн үйлчилгээг үнэлж, хэрэглэгчийн хэрэгцээг илүү сайн ойлгож авдаг.

# Дижитал технологи ашиглан заах

Дижитал төхөөрөмж, мэдээллийн хэрэгсэл, орчин, эсвэл дижитал программаар дамжуулан заах үйл явц. Дижитал технологиор дамжуулан заах үйл явц нь шууд биечлэн, шууд онлайнаар эсвэл оюутнуудыг янз бүрийн асинхрон буюу шууд бус нөөц хэрэгсэл, орчноор дамжуулан дэмжих замаар явагдах боломжтой. Мөн оюутнуудын дижитал суралцах чадварыг нь дэмжинэ.



## 43 Дижитал сургалт, үнэлгээний дэд бүтэц

**Гол чиглэл:**
Сургалтын орчин | Үнэлэх, дүгнэх | Сургалтын материаллаг бааз |Холимог/хосолсон аргачлал | Нээлттэй боловсролын туршлага | Нээлттэй боловсролын нөөц | Сургалтын нөөц | Оюутанд узүүлэх дэмжлэг | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал сургалт, үнэлгээнд сургалтын удирдлагын систем, виртуал сургалтын орчин, янз бүрийн технологи, системүүд (жишээ нь, онлайн хамтын ажиллагааны хэрэгслүүд, видео хурлын платформууд, э-портфолио, видео бичиж засварлах программ хангамж) ашигладаг. Эдгээр хэрэгслүүдийг нэгтгэн ашиглаагүй байх тохиолдлууд нэлээд бий бөгөөд байгууллага даяар нэвтрүүлэх нь зарим нэг чадварлаг ажилтнаас хамаарах нь түгээмэл.

- Бүх сургалтыг тодорхой хэмжээгээр холимог хэлбэрт шилжүүлж, биечлэн суралцах үйл явцыг дижитал сургалтын үйл ажиллагаа, нөөцтэй хослуулж өгсөн байдаг. Байгууллага даяар уламжлалт болон технологи ашигласан аргуудыг хослуулан хэрэглэдэг.

- Тохиромжтой систем, үйлчилгээгээр (номын сангийн портал ба платформ, сургалтын удирдлагын систем, тэнхимийн вэбсайт) дамжуулан дижитал сургалтыг дэмжих онлайн нөөцүүдийг ашиглах боломжтой.
- Ихэнх явцын болон төгсгөлийн үнэлгээний практикт дижитал хэрэгслийг ашиглаж, үнэлгээний загвар, хэрэгжилт, тэмдэглэгээ, бүртгэлийг хийж, үр дүнг удирддаг. Оюутнууд даалгавраа хийгээд, илгээхдээ технологи ашигладаг (жишээлбэл, шалгалт өгөх аюулгүй платформ, онлайн тест, дижитал материал илгээх систем, оюуны өмчийн хулгайг илрүүлэх программ хангамж).

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал сургалтын экосистемд сурагчдын ахиц дэвшлийг хянах аналитик систем, хувь хүнд чиглэсэн сургалтыг дэмжих хиймэл оюун ухаан болон машин сургалтыг ашигласан дасан зохицох сургалтын программ хангамж зэрэг сургалтын удирдлагын системийн сайжруулсан функцуудыг багтаасан.
- Виртуал бодит байдал, өргөтгөсөн бодит байдал, симуляцийн хэрэгслүүдийг зарим тэнхимүүдэд бодит ертөнцийн ажлын орчныг тусгаж, ажил эрхлэх ур чадварыг бий болгон, сургалтыг сонирхолтой болгох үүднээс туршиж байгаа.
- Тус байгууллага нь нээлттэй боловсролын нөөцийн адил хичээлийн материалыг хадгалах, хуваалцах дижитал сангуудыг хөгжүүлсэн.
- Дижитал технологи ашиглан заах аргыг олон тооны курс, хөтөлбөрүүдэд нэвтрүүлсэн ба өөр өөр мэргэжлийн чиглэл болон оюутны бүлгүүдэд тохируулан онлайн, холимог, хосолсон аргуудаас ашигласан.
- Үнэлгээний автоматжуулсан систем, сургалтын аналитик, дасан зохицох тест, чадамжид суурилсан үнэлгээг ашиглаж байгаа эсвэл туршиж байгаа. Даалгаврыг дижитал хэлбэрт оруулснаар оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдын төрөл бүрийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлэх зорилготой.
- Тус байгууллага нь ёс зүй, бодит үнэлгээ, оюуны бүтээлийн хулгай, хуулах, оюутны олон төрлийн хэрэгцээтэй холбоотой асуудлуудад хариу өгөхийн тулд одоогийн үнэлгээний практикийг эргэн хянаж авч үзэж байгаа.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал сургалт, үнэлгээний стратегийн аргачлалыг сонирхолтой, хувь хүнд чиглэсэн сургалтыг дэмжих функцууд бүхий бүрэн нэгтгэсэн сургалтын удирдлагын системээр (жишээ нь: хиймэл оюун ухаанаар ажилладаг чатботууд, вакуум сургалтын орчин, онлайн бүлэг, сошиал орчинд харилцан, хамтарч суралцах, мэргэжлийн олон чиглэлийн агуулга оруулсан сургалт) дамжуулан хэрэгжүүлдэг.
- Оюутны төрөл бүрийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн олон төрлийн уян хатан, хувь хүнд чиглэсэн сургалтын арга замууд бүхий дижитал хэлбэрээр заах аргыг бүх хичээл, хөтөлбөрт суулгаж өгсөн. Ийнхүү сургалтад нэгтгэж өгснөөр оюутны оролцоог олон хэлбэрээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Суралцагчдад тохиромжтой, хаанаас ч, хэзээ ч хамрагдаж болох уян хатан асинхрон үйл ажиллагаанууд бүхий биечлэн болон оюутны хотхоноос гадуур оролцож болох янз бүрийн синхрон сургалтын үйл ажиллагааг санал болгодог.
- Технологийн дэмжлэгтэй үнэлгээ, дүгнэлтийг байгууллагын хэмжээнд ашиглах стратегийн аргачлал хэрэгжүүлсний үр дүнд сургалтын хөтөлбөрийн баг, оюутнууд болон хөндлөнгийн шалгагчид бүгд нэгэн жигд, нэг стандартын үнэлгээ ашиглах боломжтой юм.
- Суралцагчид явцын дүгнэлтийн үнэ цэнийн талаар тодорхой ойлголттой бөгөөд хамт суралцагчдаар үнэлүүлэх болон өөрийгөө үнэлэх замаар үүнд оролцдог. Оюутнууд ахиц дэвшил, амжилтаа бүртгэх, удирдах, хуваалцахдаа дижитал хэрэгсэл, үйлчилгээг ашигладаг.
- Тус байгууллагыг дижитал сургалт, үнэлгээний чиглэлээр салбартаа тэргүүлэгч хэмээн үздэг.



## 44 Багшлах бүрэлдэхүүнийг ажилд авах тогтвортой ажиллуулах

**Гол чиглэл:** Ажилтнуудыг хөгжүүлэх | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Багш нарын дижитал технологи ашиглан сургалт явуулж, үнэлгээ хийхдээ өөртөө итгэлтэй, чадвартай байхын ач холбогдлыг байгууллага хүлээн зөвшөөрдөг.
- Өндөр ур чадвартай дижитал багшлах мэргэжилтнүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулах зарим үйл явцад нөөцийн хомсдол, түр зуурын, богино хугацааны гэрээ зэргээс болж саад учирч болзошгүй. Тус байгууллага нь дижитал сургалт, үнэлгээний хэрэгслийг үр дүнтэй ашиглах талаар багшлах бүрэлдэхүүнд тогтмол сургалт явуулдаг.

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага нь дижитал технологи ашиглахдаа итгэлтэй, чадварлаг багшлах бүрэлдэхүүн сонгон шалгаруулж, тогтвортой ажиллуулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах нөхцөл, өрсөлдөхүйц цалин хөлс, урт хугацааны гэрээ, олон янзын тэтгэмж, урамшуулал гэх мэт сайн ажилтнуудыг татах, тогтвортой ажиллуулах нөхцөлүүдийг санал болгодог. Ажилтнуудын дижитал сургалт, үнэлгээний ур чадвар, туршлагыг байгууллага даяар үнэлдэг.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллага нь өндөр ур чадвартай багш нарын дижитал шилжилтэд оруулах үнэ цэнийг зөвшөөрдөг бөгөөд шилдэг ажилтнуудыг татах, тогтвортой ажиллуулахын тулд ажилд авах, тогтвортой ажиллуулж хөгжүүлэх стратегийн, шинэлэг хандлагыг авч үзэн хэрэгжүүлдэг.
- Ахлах багш нар байгууллагын стратеги, бодлого боловсруулах, дижитал сургалт, үнэлгээний инновацид нөлөөлөх ажилд идэвхтэй оролцдог.
- Дижитал технологи ашиглахдаа өөртөө итгэлтэй, туршлагатай багш нар мэргэжлийн бүлгүүд болон багш нарын нийгэмлэгт (Адванс Эйч-Ий, Өөрчлөгч шинэчлэгчдийн сүлжээ [CAN], Их Британийн ажилтнууд болон боловсролын хөгжлийн холбоо гэх мэт) мэдлэг, туршлагаараа хувь нэмэр оруулдаг.

## 45 Багшлах бүрэлдэхүүнийг хөгжүүлэх, сургах

**Гол чиглэл:**

Ажилтны хөгжил | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь багш ажилтнуудад шинээр ур чадвар эзэмшүүлэх, хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, технологитой танилцахад нь тусалж, дэмжих зорилгоор сургалт, хөгжлийн боломжуудад хөрөнгө оруулалт хийж байгаа. Багш нарын дижитал итгэлтэй байдал, дижитал чадавхын одоогийн түвшин хэр зэрэг байгаа талаарх ойлголт хангалтгүй, тэнхим хооронд мэдлэг, туршлага хуваалцах боломж байхгүй.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Багшлах бүрэлдэхүүнийг мэргэжил дээшлүүлж, ур чадвараа сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх сургалтад ихээхэн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа. Цаашид багшлах гэрчилгээ олгох боломжийг санал болгож, технологийн дэмжлэгтэй сургалтын үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, урамшуулдаг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын зүгээс сургалтын хөтөлбөрийн баг, багшлах бүрэлдэхүүний хөгжил, сайн сайхан байдалд тогтмол хөрөнгө оруулалт хийж, мэргэжлийн өсөлт, дэвшлийг дэмждэг соёлыг бий болгосон. Систем, үйлчилгээ, сүлжээ технологийг дижитал сургалт, үнэлгээний практикт нэгтгэх зорилгоор хичээлийн хөтөлбөрийн багууд удирдлагын болон бусад зохих багуудтай нягт хамтран ажиллаж байгаа.

- Ажилтнууд судалгаа шинжилгээний ажил, эрдэм шинжилгээний нийтлэл өгүүлэл, мэргэжлийн хүрээлэл болон арга хэмжээнүүдээр дамжуулан байгууллагаас гадуур дижитал сургалт, үнэлгээний мэдлэг, туршлагаа хуваалцдаг. Нээлттэй боловсролын практикийг дэмжиж, өндөр чанартай боловсролын хүртээмжийг өргөжүүлж, нэмэгдүүлэх чухал арга зам гэж үздэг.

## 46 Сургалтын болон сурах орон зай

**Гол чиглэл:**

Номын сан, сургалтын нөөц | Сургалтын орон зай | Сурах орон зай

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Хуучин болон шинэ барилга байгууламжуудад суралцах, заах, судлах олон янзын орон зай бий. Үүнд тэнхимийн байр, номын сан болон кафе, оюутны зөвлөлийн гэх мэт бусад нийтийн эзэмшлийн талбайнууд багтана.

- Сургалтын орон зай нь зохион байгуулалт, хэв маяг, багтаамж, дижитал байгууламж, чанараараа ялгаатай. Үүнд хэдэн зуун оюутан хүлээн авах боломжтой том лекцийн заал, жижиг лекцийн танхим болон хичээлийн танхим маягийн өрөө, арав гаруй оюутанд зориулсан семинарын өрөө, чимээгүй бие даан сурах орон зай, багаар ажиллах талбай зэрэг багтдаг.
- Өрөөнүүдийн талаарх зөрүүтэй мэдээллийг (захиалга, тоног төхөөрөмж, ашиглалт) өөр өөр хэлтэсүүд хадгалдаг.

- Шинээр баригдсан сургалтын зарим орон зай нь харилцаа холбоо, хамтын ажиллагаа, эрчим хүчний менежмент, хандалтын нэгдсэн дижитал системтэй. Байгууллагын зүгээс хуучин сургалтын орон зайг сайжруулж болох шинэ шийдлүүдийг туушгай эрэлхийлдэг.

- Үндсэндээ эд хөрөнгийн удирдлага, технологийн нөөц боломжид тулгуурласан цэвэр прагматик үүднээс хандаж сургалтын орон зайн дизайныг тодорхойлдог.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Сургалтын болон сурах орон зайн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, бүтээн байгуулалтын стратегийн аргачлалыг нэвтрүүлсэн.

- Одоо байгаа төрөл бүрийн орон зайд иж бүрэн аудит хийснээр бүтээн байгуулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд туслах ба оновчтой болгож, ур дүнтэй ашиглахгүй байгаа газруудыг тодруулдаг.
- Сургалтын орон зайн дизайныг эд хөрөнгийн болон мэдээллийн технологийн багууд удирддаг. Үр дүн нь ихэвчлэн сургалтын үйл ажиллагааны практикт бус үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг.

- Ихэнх сургалтын орон зай нь уламжлалт загвар, арга барилыг тусгасан байдаг (жишээ нь, нэг чиглэлд харсан олон тооны суудал, сургалтын орон зайн урд тал руу хандуулсан аудиовизуал болон дижитал төхөөрөмж, лекцэнд суурилсан нүсэр, том шийдлүүд).

- Тавилга, тоног төхөөрөмж, өрөөний зохион байгуулалт нь сургалтад оролцогчдын хооронд саад үүсгэдэг бөгөөд олон өрөөнд асуудал гарсан үед техникийн туслалцаа шаардлагатай байдаг.

- Технологийг хэр зэрэг, хэн, хэзээ ашиглаж байгаа талаар бодитой ойлголт байхгүй.

- Сургалтын орон зай нь үндсэндээ албан хэрэглээний бөгөөд кафе, хоолны газар эсвэл оюутны зөвлөлд зарим нэг албан бус сургалтын орон зай байдаг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Ухаалаг оюутны хотхоны дизайнд стратегийн хөрөнгө оруулалт хийсний үр дүнд байгууллага даяар суралцах, заах, судлах орон зайгаар хангах зохион байгуулалттай аргачлал бий болсон. Уян хатан сургалтын орон зайд олон төрлийн хэв маяг, үйл ажиллагаа бүхий сургалт явуулах боломжтой. Сурах орон зайн сонголт олширсноор ганцаарчлан олон багаар хамтран сурах боломжтой. Хичээлийг төлөвлөхдөө оюутнуудын өөрийн гэсэн суралцах орон зай, хувийн төхөөрөмжийг мөн харгалзан авч үздэг.
- Дээд шатны удирдлага, эд хөрөнгө хариуцсан болон мэдээллийн технологийн ажилтнууд, багшлах бүрэлдэхүүн, номын сан, сургалтын технологийн ажилтнууд, оюутнуудаас тогтох тэгш оролцоог хангасан гишүүнчлэл бүхий төвлөрсөн нэг зөвлөл буюу хороогоор дамжуулан сургалтын орон зайн дизайныг удирддаг.
- Сургалтын орон зайн архитектурын шийдэл, визуал элементүүдийг зөв хослуулснаар, нийгмийн янз бүрийн бүлгийн хэрэглэгчдэд тэгш, хүртээмжтэй, оролцоог хангасан орчин нөхцөлийг бүрдүүлж, бусадтайгаа харилцаа холбоо үүсгэж, хамтдаа суралцах боломжтой болоход туслана.
- Тусгай зориулалтын орон зайд виртуал буюу загварчилсан, бодит ертөнцтэй төстэй орчин (жишээ нь, эмнэлгийн тасаг, барилгын талбай) бүрдүүлдэг. Өргөтгөсөн бодит байдлын төхөөрөмжүүд ашиглан бодит орон зайд жинхэнэ мэт туршлага хуримтлуулах боломжтой.
- Бүх орон зайд хэрэглэгчид байнга туршлага хуримтлуулж, программ хангамж, техник хангамжийг ашиглаж сурахад дэмжих, ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх зэргээр хэрэглэгчдийн өөртөө итгэх итгэлийг дээшлүүлж, дэмждэг.
- Сургалтын орон зайн технологийг үүлэнд суурилсан платформоор удирдаж, идэвхтэй, урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээг идэвхжүүлдэг. Технологи, платформууд нь ашиглалт, хэрэглэгчийн төрөл, ашиглалтын хугацааг бүртгэх функцтэй.

- Ажилтнууд болон оюутнуудад захиалгаа шуурхай, уян хатан хийх боломжтой болгохын тулд дижитал захиалга өгөх дэлгэцийг бүх орон зайн гадна байрлуулсан.

- Програм хангамжийн бүх шийдлүүд нь орон зайн ашиглалтын талаарх мэдээллийг гаргаж, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах боломжийг олгодог. Орон зайн дизайн эсвэл зориулалтад өөрчлөлт хийхдээ сайн судалж, нягтлан, удирдах зөвлөлийн түвшинд батлуулдаг бөгөөд стратегид нийцүүлэн, тусгайлан хөрөнгө оруулж, хэрэглэгчийн туршлагыг сайтар бодолцдог.

- Байнгын төлөвлөлт болон ирээдүйн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор нэргүй өгөгдлийг (байршил, цаг хугацаа, барилга доторх хэрэглэгчдийн тоо) утасгүй сүлжээний аналитикаар цуглуулж, сургалтын орон зайн стратеги хариуцсан бүлэгт мэдээлдэг.



## 47 Сургалтын аналитик дүн шинжилгээг ёс зүйтэй ашиглах стратеги

**Гол чиглэл:** Өгөгдлийн аналитик | Ёс зүй

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Байгууллага нь сургалтын аналитик дүн шинжилгээг заах арга зүй, сургалтын хөтөлбөр боловсруулахад тустай гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч үүнийг стратегийн хувьд хэрэгжүүлээгүй байгаа.
- Мэдээлэл цуглуулах, удирдах, дүн шинжилгээ хийх үйл явцы нь уялдаа холбоогүй, зохицуулалтгүй, нэгтгээгүй системүүд хооронд дамжуулах боломжгүй.

- Сургалтын аналитик дүн шинжилгээний чадавх багуудын хооронд харилцан адилгүй бөгөөд заах арга зүйн болон сургалтын хөтөлбөрийг боловсруулахад оюутны өгөгдлийг ёс зүйтэй ашиглах талаар ойлголт, заавар бага байдаг.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дэд бүтцийн хөгжил, системийн интеграцчлал нэмэгдсэнээр мэдээлэл цуглуулах, удирдах, суралцагчдын мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцыг сайжруулсан. Мэдээллийг ашиглах ёс зүйн дүрмийг боловсруулж, үр ашгийнх нь талаар ажилтнууд болон оюутнууд нийтлэг ойлголттой болсон.

- Ажилтнууд өгөгдлийн удирдлага болон дүрслэлийн программ хэрэгсэл, системд (жишээ нь, хяналтын самбар) хандан ашиглах боломжтой бөгөөд тэдгээрийг үр дүнтэй ашиглах сургалтанд хамрагдсан. Сургалтын аналитик дүн шинжилгээний үр дүнд суурилан заах арга зүй, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, оюутны оролцооны талаарх ойлголтыг бэхжүүлж, оюутны туршлагыг сайжруулахын арга хэмжээг эртнээс авдаг.
- Дижитал сургалтанд ашиглаж буй бүх хувийн мэдээлэл өгөгдөл хамгаалах хууль тогтоомжийн дагуу, ил тод.

- Урьдчилан таамаглах аналитик дүн шинжилгээний тусламжтайгаар сургуулиа орхих эрсдэлтэй оюутнуудыг тодорхойлж, зохих зорилтот дэмжлэг үзүүлдэг ба машин сургалт болон хиймэл оюун ухаан ашиглан өгөгдлийн шинжилгээ хийдэг.

## Сайжирсан-Төлөвшсөн

- Сургалтын аналитик дүн шинжилгээний үр дүнг сургалтын хөтөлбөр боловсруулах, бодит болон дижитал дэд бүтцийг төлөвлөх, номын сангийн зохистой үйлчилгээгээр хангах, ахиц дэвшлийг хянах, зохих арга хэмжээ авах, оюутнуудад санал зөвлөмж өгөхөд үр дүнтэй ашиглаж байгаа. Суралцагчийн мэдээллийг ил тод, хариуцлагатай, шударга ашигладаг хэмээн бүх оролцогч талууд итгэдэг.

- Өгөгдлийг цогц байдлаар, үнэн зөв цуглуулж, нэгтгэн, дүн шинжилгээ хийх чадавх дээр үндэслэн шийдвэр гаргаж, хөрөнгө оруулалт хийж, төлөвлөдөг.

- Сургалтын аналитик дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан олон төрлийн хувь хүнд чиглэсэн сургалтын санаачлага болон зорилтот арга хэмжээг удирддаг. Багшийг хөгжүүлэх сайн хөтөлбөрүүд хэрэгжүүлж бүх багш нарыг сургалтын аналитик дүн шинжилгээ ашиглан заах хөтөлбөр, арга зүйгээ дээшлүүлэх чадвартай болоход анхаардаг.
- Гүйцэтгэлийн үзүүлэлтээ жиших, харьцуулах санаачилгуудыг хэрэгжүүлэн шилдэг туршлага, өгөгдөл хандалтад ойлголт, мэдээлэлд үндэслэн сургалтын үр дүнг тасралтгүй сайжруулдаг.



# Суралцагчийн туршлага

Хөтөлбөрийн дагуу заасан хичээлүүд болон хичээлээс гадуурх дараах үйл ажиллагаануудыг оруулаад тухайн суралцагчийн суралцах хугацаандаа хуримтлуулсан нийт туршлага: хувиараа бие даан суралцах хэлбэр, суралцах ур чадвараа хөгжүүлэхэд авсан дэмжлэг, номын сангийн нөөц хэрэгсэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох дэмжлэг, хамтран суралцах албан бус сургалтын хэлбэр гэх мэт. Үүнд сэтгэл санааны болон хувийн сайн сайхан байдлыг мөн оруулна.



## 48 Суралцах хугацаандаа олж авсан олон янзын туршлага оюутны хөгжилд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох

**Гол чиглэл:**
Оюутны туршлага | Дижитал цогц чадвар | Олон улсын хамтын ажиллагаа
Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагын зүгээс оюутнуудын туршлагыг танин, тодорхойлохын тулд хэд хэдэн механизм ашигладаг боловч үр дүнг харилцан уялдаатай авч үздэггүй.
- Хэт олон асуулттай, олон давтамжтай судалгаа авсны улмаас хүмүүс дутуу, буруу бөглөж үр дүнгүй болдог бөгөөд санал, хүсэлтийн үнэ цэнэ, ач холбогдлын талаар оюутнууд тэр бүр ойлгодоггүй.
- Модулийн үнэлгээний судалгаа, оюутны туршлагын жил тутмын судалгаа, үндэсний оюутны жил тутмын судалгаа, Jisc буюу Хмсх-ын оюутны дижитал туршлагын талаарх судалгаа зэрэг төрөл бүрийн судалгааны үндсэн дээр оюутны туршлагыг сайжруулах олон санаачилгуудыг төлөвлөн боловсруулдаг.
- Оюутнууд оюутны төлөөлөл, оюутны зөвлөл, оюутны холбооны төлөөлөгчдөөр дамжуулан санал хүсэлтээ гаргах албан ёсны механизм бий.
- Зарим тодорхой асуудлаар санал хүсэлт авахад фокус бүлэг, ярилцлага зэрэг илүү нарийн арга ашигладаг.
- Оюутнууд албан бус санал хүсэлтээ шууд багш нарт гаргадаг.
- Нэрээ нууцалсан санал хүсэлтийг биет санал хүсэлтийн хайрцаг эсвэл онлайн маягтаар дамжуулан цуглуулдаг.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал дэд бүтцийг хөгжүүлсний ачаар оюутны туршлагын өгөгдлийг цуглуулах, удирдах, дүн шинжилгээ хийх найдвартай, бат бөх механизмуудтай болсон.
- Эдгээр механизмуудыг суралцагчдаас шууд хэлбэрээр судалгаа аван цуглуулсан санал хүсэлтийн хамт ашиглан хувь хүний туршлагыг бүрэн дүр зургаар нь харуулахын зэрэгцээ суралцах, амжилт, ахиц гаргах, дижитал чадавхаа хөгжүүлэх гэх мэт дижитал туршлагын суурь болон жишиг үзүүлэлтийг харьцуулах боломжтой.

**○-○-●Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь оюутнуудтай хамтран ажилладаг, оюутнуудын дуу хоолойг сонсдог гэдгээрээ танигдсан. Оюутны оролцоог сайшаан дэмжсэн олон төрлийн шагнал урамшуулал байдаг учир оролцоог улам идэвхжүүлдэг ба оюутнууд олон чиглэлээр (жишээлбэл, дижитал чадавх, хөдөлмөр эрхлэх ур чадвар) дээд боловсролын салбарт манлайлал үзүүлж, элч төлөөлөгч болох боломжтой.
- Суралцагчийн туршлагыг сургалтын хөтөлбөрийн дизайн, дижитал хэрэгсэл, дижитал технологи, оюутны үйлчилгээ, дижитал цуглуулга буюу сан хөмрөг, сургалтын нөөцийг хөгжүүлж сайжруулахад тусган оруулдаг.
- Оюутны хэрэгцээ шаардлагын олон талт байдлыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд дижитал сургалт, үнэлгээний дизайн, хэрэгжилтэд тусган оруулдаг. Бодит болон виртуал орчин нэгдсэн кампуст суралцсанаар суралцагчдад элсэн орсон цагаас авахуулаад төгсөлтийн дараах хүртэл эрэг, бүрэн цогц туршлага хуримтлуулах боломж олгодог.





## 49 Оюутнуудыг илүү өргөн хүрээнд туршлага хуримтлуулахыг дэмжих

**Гол чиглэл:**
Харьяалагдах хэрэгцээ | Оюутанд үзүүлэх дэмжлэг | Дижитал бүлэг үүсгэх | Эдийн засаг/ Санхүүгийн боловсрол

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Оюутны хотхоны бодит орчин нь оюутнуудыг нийгмийн харилцаанд орох, хамт олонтойгоо цагийг өнгөрүүлэх олон төрлийн уламжлалт орон зай, үйлчилгээ, боломжоор хангадаг.
- Тус их сургуулийн вэб сайт нь шинээр элссэн, хичээл сургуулийн гараагаа эхэлж буй оюутнуудад таатай анхны сэтгэгдэл төрүүлж, элсэлт болон дасан зохицох үйл явцыг нь дэмжиж өгнө.
- Санхүүгийн болон захиргааны дэмжлэгийн мэдээллийг өргөдөл гаргах явцад вэбсайт болон оюутны дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээр дамжуулан өгдөг.

**○-●-○Тогтворжсон-Сайжирсан**

- Оюутнуудад үе тэнгийнхэнтэйгээ харилцах, танилын хүрээгээ тэлэхдээ нийгмийн сүлжээ, онлайн платформуудыг ашиглахыг зөвлөдөг.
- Оюутнууд клуб, нийгэмлэг, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд онлайнаар оролцох боломжтой бөгөөд зарим нэг виртуал арга хэмжээнд оролцож, онлайн мэдээллийн санд хандах боломжтой.
- Санхүүгийн тусламж, нөөц, өргөдлийн маягтын талаарх мэдээллийг онлайнаар авах боломжтой. Дижитал хэрэгсэл ашиглан санхүүгийн тусламжийн өргөдлийн явц, тусламжийн төлөлтийг хянах боломж олгодог.
- Санхүүгийн мэдлэгийг чухалд тооцож, санхүүгээ зохицуулахад бэрхшээлтэй байгаа оюутнуудад зориулсан заавар, дэмжлэг үзүүлэх боломжтой.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллага нь бүх суралцагчдад элсэн орсон цагаас эхлээд сургалтын бүхий л хугацаанд, мөн төгссөний дараа ч гэсэн дэвшилттэй, дэмжлэг бүхий, хүртээмжтэй туршлага хуримтлуулах нөхцөлийг бүрдүүлэхээр тууштай ажилладаг.
- Дижитал хэрэгслүүдийг иж бүрэн хэрэглэснээр тэгш оролцоог хангасан, байнгын холбоотой байж болох онлайн бүлэг үүсэж, оюутнууд оюутны хотхон дотор болон гадна хамт олонтойгоо бүрэн харилцаатай байж чаддаг. Клуб, нийгэмлэг, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд виртуал болон биетээр оролцсоноор танилын хүрээгээ тэлж, нийгмийн
- харилцаагаа идэвхжүүлдэг.
  Оюутнуудад зориулсан дижитал чадавхын төлөвлөгөөнд санхүүгийн суурь боловсролын дижитал талуудыг тусгасан. Санхүүгийн тусламж хүссэн өргөдлийн явц, олгосон тусламжийн төлөлт зэргийг хянах хэрэгсэл, онлайн нөөц, виртуал санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- зэрэг дижитал санхүүгийн иж бүрэн тусламж авах боломжтой.
  Оюутнуудыг санхүүтэй холбоотой асуудлуудаа ярилцахыг дэмжиж, санхүүгийн дэмжлэг хэрэгтэй хүнийг тодорхойлж, тусламжийн үйл явцыг хялбаршуулах боломжтой нэгдсэн дижитал хэрэгслийг ашиглахыг зөвлөдөг.



## 50 Төгсөгчдийн оролцоо

**Гол чиглэл:**

Харьяалагдах хэрэгцээ | Дижитал бүлэг үүсгэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь төгсөгчдийг дэмжих баг эсвэл албанаас зохион байгуулдаг зөвлөх, бусадтай холбох болон бусад үйл ажиллагаануудаар дамжуулан төгсөгчдөд сургуулийн арга хэмжээнүүдэд оролцох боломжийг санал болгодог.

### ○-●-○Тогтворжсон-Сайжирсан

- Төгсөгчид программ хэрэгсэл ашиглан сургууль, байгууллагатайгаа холбоотой байж, олон нийтийн болон танилын хүрээгээ тэлэх үйл ажиллагаанд оролцох боломжтой.

### ○-○-●Сайжирсан-Төлөвшсөн

- Төгсөгчид нь чухал түншид тооцогддог бөгөөд дижитал орчинд танилын хүрээ тэлэх болон бусад программ хэрэгслийн тусламжтайгаар оюутнуудад зөвлөн дэмжиж, суралцсан хугацааны туршлагаа хуваалцаж, ажилд ороход шаардагдах ур чадвар/мэргэжлийн ур чадварын талаар мэдлэг туршлагаа хуваалцдаг.

## 51 Оюутнуудын дижитал болон хувийн сайн сайхан байдлыг дэмжих

**Гол чиглэл:**

Дижитал сайн сайхан байдал | Дижитал чадавх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Сайн сайхан байдлыг дэмжих багууд биечлэн туслах үйлчилгээнд анхаарлаа төвлөрүүлэх хандлагатай байдаг. Шинэ оюутанд зориулсан танилцуулах сургалт, багш ажилтнууд болон вэб хуудсуудаараа дамжуулан тусламж, чиглүүлэх үйлчилгээг санал болгодог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал сайн сайхан байдал нь оюутны эрүүл мэнд, сайн сайхан байдлын нэгэн чухал ойлголт гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Байгууллага нь оюутнуудад технологи, сүлжээ ашиглалтаас үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бодолцож үзэхийг уриалан, тэдгээрийг багасгах тал дээр заавар, дэмжлэг үзүүлдэг. Программ хэрэгсэл, заавар зааварчилгаагаар дамжуулан хувь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмждэг бөгөөд дижитал туслах технологи ашигласнаар суралцах үйл ажиллагаанд нь хэр зэрэг дэм, тус үзүүлж байгааг тодорхойлж гаргахыг оюутнуудаа бүгдэд нь уриалдаг.
- Сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих онлайн нөөц, өөртөө туслах хэрэгслүүдтэй байдаг. Виртуал зөвлөгөө, дэмжлэгийг оюутны хотхоноос гадуурх оюутнууд авах боломжтой.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал сайн сайхан байдлыг оюутнуудын дижитал чадавхыг дэмжих үйлчилгээнд нэгтгэсэн байдаг. Эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих иж бүрэн дижитал нөөц (жишээ нь, өөртөө туслах онлайн хэрэгсэл, тусламж үзүүлэх виртуал бүлгүүд, зөвлөгөө өгөх үйлчилгээ) бий. Нэгдсэн дижитал систем, хэрэгслүүд ашиглан оюутны сайн сайхан байдлыг ёс суртахуунтай, зохистой байдлаар идэвхтэй хянаж, дэмждэг.
- Оюутнууд дижитал сайн сайхан байдлын бүх ойлголтын талаар мэдлэгтэй ба үүнд, бие махбодь болон сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, ямар ямар талуудыг нь сайжруулж болох, тусламж, дэмжлэг хэрхэн хүсэх, эрүүл мэнд, сайн сайхан байдлаа сайжруулахын тулд технологийг хэрхэн ашиглах зэрэг орно.



# Мэдлэгийг удирдах, хэрэглэх

Байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг, тэр дундаа судалгаа, сургалт явуулах үйл ажиллагааг дэмжиж өгөгдөл, мэдээллийн хүртээмж, ашиглалтыг сайжруулах. Шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангах зорилгоор мэдээлэл болон өгөгдлийг нэгтгэх, хадгалах, удирдах, хуваалцах, ашиглах боломжтой байх.



Мэдээллийн удирдлага, хэрэглээ >>

Өгөгдлийн удирдлага, хэрэглээ >>

Бизнесийн оюун >>

Шийдвэр гаргах >>

# Мэдээллийн удирдлага, хэрэглээ

Мэдээллийг үр дүнтэй олж татан, ашиглах боломжтой байхаар цуглуулж, цэгцэлж, хадгалж, хуваалцахтай холбоотой аргачлал, дүрэм журмууд. Үүнд байгууллагын зүгээс үүсгэсэн болон гуравдагч талаас нийлүүлсэн мэдээлэл орно.



## 52 Мэдээллийн удирдлагын стратегийн арга барил

**Гол чиглэл:**
Номын сан, сургалтын нөөц | Мэдээллийн суурь боловсрол | Удирдлагын мэдээлэл | Мэдээллийн стратеги | Дижитал мэдээлэл | Дижитал цуглуулгийн буюу сан хөмрөгийн удирдлага | Дижитал хадгалалт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага нь дижитал мэдээллийн стратеги, мэдээллийг үр дүнтэй удирдах протокол боловсруулах төлөвлөгөөтэй байгаа.
- Зарим дижитал мэдээллийн удирдлагын стратеги, бодлого, протоколууд хэрэгжиж байгаа боловч дижитал мэдээллийг үр дүнтэй ашиглах дэд бүтэц, дэмжлэг хязгаарлагдмал байдаг.
- Үндсэн бодлогоороо дижитал мэдээллийн удирдлагын асуудлуудыг дэмждэг бөгөөд дижитал өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлын зохицуулалт, оюуны өмчийн эрхэд голчлон анхаардаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага даяар дижитал мэдээллийн чанар, хүртээмж, хэрэглээг сайжруулах тодорхой зорилго, зорилтуудыг агуулсан дижитал мэдээллийн нэгдсэн стратеги боловсруулсан.
- Дижитал мэдээллийн удирдлагын стратеги, бодлого, протоколууд боловсруулснаар цогц аргачлал хэрэгжүүлж, системүүдийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Мэдээллийн засаглал, өгөгдлийн чанар, мэдээлэл хуваалцах, нээлттэй хандалтын зарчим зэрэг дижитал мэдээллийн удирдлагын өргөн хүрээний үйл ажиллагааг бодлогоор дэмждэг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах, байгууллагыг амжилтанд хүргэхийн тулд дижитал мэдээллийн стратеги нь тасралтгүй шинэчлэл, сайжруулалтад чиглэсэн байдаг.
- Дижитал мэдээллийн удирдлага нь бизнесийн бүх үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Тохиромжтой технологиуд ашиглан, практик дадлуудыг хэрэгжүүлснээр дижитал мэдээллийн нэгдсэн экосистем бүрдсэн.
- Өгөгдлийн засаглал, өгөгдлийн чанар, мэдээлэл хуваалцах, нээлттэй хандалт, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах зэрэг дижитал мэдээллийн удирдлагын бүх талыг цогц бодлогоор шийдсэн

## 53 Мэдээллийн удирдлагыг дэмжих системүүд

**Гол чиглэл:**

Мэдээлэл хадгалах, татан ашиглах | Дижитал цуглуулгийн удирдлага | Дижитал хадгалалт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Дижитал мэдээллийн удирдлагын дэд бүтцийн хүрээнд өгөгдөл хадгалах энгийн шийдлүүд, зайлшгүй чухал программ хангамж, кибер аюулгүй байдлын наад захын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

### Тогтворжсон-Сайжирсан

- Өгөгдөл хадгалах сайжруулсан шийдэл, мэдээлэл боловсруулах дэвшилтэт программ хэрэгсэл, өгөгдлийн аналитик платформ зэрэг дижитал мэдээллийн удирдлагыг илүү найдвартай дэмжих дэд бүтэцтэй.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлээр хамгийн тохиромжтой технологиуд бүхий, харилцан уялдаа холбоотой саадгүй ажилладаг дижитал мэдээллийн удирдлагын хэрэгсэл, платформыг нэгтгэсэн дэд бүтэцтэй. Мэргэшсэн номын сангийн программ хэрэгсэл, нийлүүлэгчдийн санал болгож буй платформуудыг үнэлэх найдвартай шалгууруудтай.



## 54 Мэдээллийн удирдлагын ур чадвар, мэдлэг туршлага

**Гол чиглэл:**

Дижитал чадавх | Ажилтнуудыг хөгжүүлэх | Мэдээллийн боловсрол

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Байгууллагын зүгээс ажилтнууд болон оюутнуудаа дижитал мэдээллийн удирдлагын ур чадвараа хөгжүүлэхэд бага зэрэг дэмжлэг үзүүлэх буюу хааяа нэг сургалт санал болгож, маш бага хэмжээний дэмжлэг үзүүлж, зааварчилгаа өгдөг. Стратегийн, уялдаа холбоотой арга барил баримтлахын ач холбогдлын талаар алба, хэлтэсүүд нийтлэг ойлголтгүй.
- Номын сангийн тухай танилцуулах үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн суурь боловсролын хичээлийг оюутнуудад санал болгодог бөгөөд оюутнуудын суралцах хугацаанд цөөн хэдэн удаа дээрх мэдлэгийг сэргээдэг. Номын сангийн гадна байгаа оролцогч талууд дижитал мэдээллийн суурь боловсролын тухай болон үүний дижитал чадавхтай уялдах ач холбогдлын талаар бүрэн ойлголтгүй.
- Хүсэлт гаргасан ажилтнуудад мэдээллийн суурь мэдлэг олгох дэмжлэг хязгаарлагдмал байдаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Ажилтнууд болон оюутнуудыг дижитал мэдээллийг удирдах ур чадвараа хөгжүүлэхэд нь туслах зорилгоор семинар, нөөц хангамж, зориулалтын баг, ажилтнуудаас тусламж авах боломж зэрэг байнгын сургалт, дэмжлэг үзүүлдэг.
- Мэдээлэл, судалгааны суурь мэдлэгийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг. Судлаач оюутан, ажилтнуудад зорилтот сургалт, дэмжлэг, зааварчилгаар санал болгодог.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд бодитоор явуулахад хязгаарлагдмал байдаг үйлчилгээг өргөтгөн вэб-д суурилсан өргөн хүрээний дэмжлэг үзүүлж, зааварчилгаа өгч, онлайн хичээлүүдийг явуулдаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Ажилтнууд болон оюутнууд дижитал мэдээллийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн төдийгүй; дижитал мэдээллийн удирдлагын стратеги, бодлого, практикийг хөгжүүлэх, сайжруулахад идэвхтэй хувь нэмэр оруулдаг.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд сургалтын хөтөлбөрийн багуудтай хамтран ажиллаж бүх хичээлд мэдээлэл, судалгааны мэдлэгийг тусган оруулах, ингэснээр шүүмжлэлтэй эргэцүүлэн бодох, дижитал орчинд бодит байдалд дөхсөн дадлага хийх зээргт дэмжлэг үзүүлж, дижитал сургалтын чадавхыг сайжруулахыг зорьдог.
- Дижитал мэдээллийн суурь боловсрол нь бүх оролцогч талуудын хувьд чухал чадвар хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд үүнийг бүх ажилтан, оюутнуудад зориулсан дижитал чадавхын ерөнхий төлөвлөгөөнд оруулсан байдаг.

## 55 Дижитал номын сан, архивын сан хөмрөг

**Гол чиглэл:**

Мэдээлэл хадгалах, татан ашиглах | Дижитал цуглуулгийн удирдлага | Дижитал хадгалалт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Судалгаа хийх, дижитал эрдмийн ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор өгөгдөл эзэмших/кураторуудын тухай ойлголтыг нэвтрүүлж, хэсэгчлэн хэрэгжүүлсэн (глобал эзэмшил).
- Сургалтын хөтөлбөр, судалгааны шаардлагын дагуу хэрэгцээтэй сан хөмрөг, цуглуулгын хамрах хүрээний талаар сайн ойлголттой байдаг.
- Батлагдсан стандартын дагуу дижитал каталогжуулалтын ажил тууштай явагддаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Судалгаа, дижитал эрдмийн ажилд батлагдсан албан тушаал бүхий өгөгдөл эзэмшихтэй холбоотой тусгай ажилтнууд / кураторууд  дэмжлэг үзүүлдэг. Цуглуулга буюу сан хөмрөгийг удирдахад өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах хандлагыг дэмжих систем, процессууд ашигладаг.
- Жигд, зохион байгуулалттай дижитал каталогжуулалтын тусламжтайгаар системүүд харилцан ажиллах, сан хөмрөгөөс хайлт хийх боломжтой болсон
- Нээлттэй эх сурвалж, хэвлэлийг хөгжүүлэхийг дэмждэг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Судалгаа, дижитал эрдмийн ажилд дэмжлэг үзүүлж хувь хүний өгөгдлийг эзэмшин хариуцах мэргэжилтнүүд / кураторуудтай, мөн тэдний залгамж халаар хэрхэн үргэлжлүүлэхийг сайтар төлөвлөсөн.
- Сан хөмрөгийг баяжуулах, хөгжүүлэх явцыг удирдан чиглүүлэхийн тулд сан хөмрөгийн удирдлагатай холбоотой шийдвэр гаргах өгөгдөлд суурилсан арга барилыг (жишээ нь, аналитик болон ашиглалтын статистик) бий болгосон.
- Цуглуулга, сан хөмрөгийн удирдлагыг дэмжих системүүдийг холбон, нэгтгэсэн. Хоорондоо холбоотой өгөгдөл ба/буюу нэгж хоорондын холбоос дээр суурилсан аргачлал ашиглан бодит үнэ цэнтэй өгөгдлийн сан үүсгэснээр мэдээллийг хялбархан олж илрүүлэх, ашиглах, мөн сургалтын болон судалгааны зорилгоор ашиглах боломжтой болсон.
- Нээлттэй эх сурвалж, хэвлэлийг хөгжүүлэх, түүний дотор байгууллагын сан хөмрөг, цуглуулгыг дижитал болгохыг дэмждэг.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд сургалт болон судалгаанд дижитал нөөцийг, тэр дундаа байгууллагын бий болгосон контентыг оруулахын тулд багш нартай нягт хамтран ажилладаг. Дижитал сан хөмрөг, цуглуулгын ашиглалтыг хянаж, нөлөөллийг нь хэмжиж тодорхойлдог.



## 56 Номын сан, мэдээллийн үйлчилгээний дижитал шилжилт

**Гол чиглэл:** Номын сан, сургалтын нөөц

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Номын сангийн үйлчилгээ нь суралцах, заах, судлах үйл ажиллагаар дэмжих дижитал дэд бүтэцтэй. Үүнд дижитал каталог, номын сангийн удирдлагын нэгдсэн систем, цахим ном, цахим сэтгүүл, мэдээллийн сан болон мэдээллийн эх сурвалжийн үйлчилгээ, номын сангийн вэб сайт, портал зэрэг багтана. Мэдээллийн суурь боловсрол олгох сургалтыг шинэ ажилтнууд болон оюутнуудад ажиллах, суралцах хугацааных нь туршид янз бүрийн түвшинд явуулан, хамруулах боломжтой.
- Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, оюуны өмчийн эрхийн талаар бодлого, журам байдаг.
- Байгууллагыг хамарсан системүүдээс номын сангийн системүүдэд дамжуулж буй мэдээллийн чанар нь жигд бус, өгөгдөл нь заримдаа алдаатай байдаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Номын сангийн стандарт үйлчилгээнээс гадна дижитал сан ашиглан судалгааны ажилд (магистрын болон докторын судалгааны ажил, эрдэм шинжилгээний нийтлэл) хандах боломжтой болсон. Олон системээс нэг дор хайх функц, виртуал лавлах үйлчилгээ, чатын тусламж гэх мэт хэрэглэгчдэд дижитал нөөцийг хайн олоход туслах сайжруулсан программ хэрэгслүүдтэй.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд дижитал сургалтын платформ, мультимедиа эх сурвалж, онлайн хичээлүүдийг ашиглан мэдээллийн суурь боловсролыг нэмэгдүүлж, судалгааны ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.
- Номын сангийн систем, үйлчилгээг сургалтын удирдлагын систем ба/буюу виртуал сургалтын орчинд нэгтгэн дижитал нөөц, үйлчилгээнд саадгүй нэвтрэх боломж олгодог.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд дижитал эрдмийн ажил, цуглуулгын буюу сан хөмрөгийн удирдлага, мэдээллийн удирдлагын үйлчилгээг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний хэлтэс, судалгааны төвүүдтэй нягт хамтран ажилладаг.
- Мэдээллийг цуглуулах, удирдах ажлыг илүү өргөн хүрээнд сайжруулснаар номын сангийн системд оруулсан өгөгдөл ерөнхийдөө өндөр чанартай, үнэн зөв болсон.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Номын сангийн үйлчилгээ нь салбартаа дижитал инновацын тэргүүлэгч бөгөөд байгууллагын дижитал шилжилтийн стратегийн чухал хэсэг болсон. Дижитал номын сангийн бүрэн цогц стратеги боловсруулсан ба энэ нь байгууллагын стратегийн зорилго болон бусад дижитал стратегиудтай нийцсэн.
- Өндөр чанартай эрдэм шинжилгээний номын сангийн үйлчилгээнээс гадна номын сан нь мэдээлэл, өгөгдлийн хяналт, дүрслэл, дүн шинжилгээ зэрэг дэвшилтэт мэдээллийн үйлчилгээг дэмждэг.
- Дижитал өгөгдлийн хадгалалт, архивын үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж дижитал хөрөнгийн хүртээмжтэй байдлыг урт хугацааны туршид хангадаг.
- Нээлттэй боловсролын нөөц болон нээлттэй судалгааны өгөгдөл зэрэг нээлттэй хандалтын санаачилгуудыг дэмжиж, удирддаг.
- Судалгаа, сургалтын шинэ хэлбэрийг (жишээ нь, 3D хэвлэлт, виртуал бодит байдал, хиймэл оюун ухаан) дэмжих зорилгоор шинээр гарч ирж буй технологиудыг хэрэгжүүлж эсвэл туршиж байгаа.
- Хэрэглэгчийн одоогийн болон ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, шилдэг туршлагыг хуваалцах, салбарын хэмжээнд дижитал номын сангийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор бүх оролцогч талууд болон түншүүдтэй идэвхтэй харилцдаг.
- Өгөгдлийн архитектурыг үр дүнтэй хийснээр номын сангийн системд чанартай өгөгдөл ашиглаж, харилцан хоёр чиглэлд солилцох боломжтой болсон.



## 57 Номын сан, мэдээллийн мэргэжилтнийг ажилд авах, тогтвортой ажиллуулах

**Гол чиглэл:**
Номын сан, сургалтын нөөц | Дижитал чадавх | Ажилтныг хөгжил | Мэдээллийн боловсрол

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Тус байгууллага номын сан, мэдээллийн мэргэшсэн мэргэжилтнүүдийг ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Зарим нэг ажилд авах, тогтвортой ажиллуулах үр дүнтэй журмыг боловсруулан гаргасан. Стратеги болон/эсвэл шийдвэр гаргахад нөлөөлөх нөөц бололцоо, боломж хомс байгаагаас өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг татах, тогтвортой ажиллуулахад саад учирсан байж болзошгүй.

### Тогтворжсон-Сайжирсан

- Тус байгууллага нь номын сан, мэдээллийн чиглэлээр мэргэшсэн өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах, өрсөлдөхүйц цалин хөлс болон бусад тэтгэмж гэх мэт ажилчдыг татах, тогтвортой ажиллуулах таатай нөхцөл, давуу талуудыг санал болгодог. Өндөр мэргэшсэн ур чадвар, мэдлэгийг байгууллага даяар үнэлдэг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Тус байгууллага нь өндөр ур чадвартай номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийн стратегийн дижитал шилжилт хийхэд оруулах үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, шилдэг боловсон хүчнийг татах, авч үлдэхийн тулд ажилд авах, тогтвортой ажиллуулах, хөгжүүлэхэд стратегийн, шинэлэг хандлагыг баримталдаг.
- Номын сан, мэдээллийн ахлах мэргэжилтнүүд байгууллагын стратеги, бодлогыг тодорхойлоход идэвхтэй оролцож, мэдээллийн менежмент, сургалт, судалгааны ажилд шинэ санаачилга нэвтрүүлэхэд нөлөөлдөг.
- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийн нэрэмжит хүрээлэн(CILIP), Коллеж, үндэсний болон их сургуулийн номын сангуудын нийгэмлэг (SCONUL) зэрэг мэргэжлийн байгууллагуудын бүлэг, нийгэмлэгүүдэд номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд мэдлэг туршлагаараа хувь нэмэр оруулдаг.

## 58 Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх, сургах

**Гол чиглэл:**
Номын сан, сургалтын нөөц | Ажилтны хөгжил
Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллага нь номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдэд шинэ ур чадвар эзэмшүүлэх, хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, технологитой танилцахад нь туслах зорилгоор сургалт, хөгжлийн боломжуудад хөрөнгө оруулалт хийж байгаа.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалтад ихээхэн хөрөнгө оруулалт хийж байгаа. Цаашид мэргэжилтний гэрчилгээ авах боломжуудыг санал болгож байгаа.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Тус байгууллага нь номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийнхээ хөгжил, сайн сайхны төлөө туушта хөрөнгө оруулалт хийж, мэргэжлийн өсөлт, дэвшлийг дэмждэг соёлыг тогтоон бий болгосон. Шийдвэр гаргах, сургалтын хөтөлбөр боловсруулах, судалгааны үйл ажиллагаар мэдээллээр хангах зорилгоор номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд удирдлага болон бусад зохих багуудтай нягт хамтран ажиллаж байгаа.



## 59 Номын сан, мэдээллийн стратегийн зорилтод түншлэлийн арга замаар хүрэх

**Гол чиглэл:**
Номын сан, сургалтын нөөц | Түншлэл

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Номын сан, мэдээллийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бусад байгууллага, гадны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлсэн.
- Хамтын ажиллагааны хүрээнд нөөц болон туршлагаа хуваалцах, хамтран худалдан авах гэрээг хамтран байгуулах, консорциумд оролцох зэрэг орно. Технологийн чиглэлийн нийлүүлэгчидтэй түншилснээр дижитал номын сангийн системийг нэвтрүүлэх, засвар үйлчилгээ хийхэд дэмжлэг болдог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Номын сан, мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад болон дотоод олон янзын оролцогч талуудтай бат бөх түншлэлийн харилцаа үүсгэсэн.
- Хамтын ажиллагаанд хамтарсан судалгааны төсөл, хамтын санхүүжилттэй албан тушаал, хамтарсан боловсролын хөтөлбөр зэрэг орно. Номын сан, мэдээллийн мэргэжилтнүүд, судалгааны багууд нь нээлттэй хандалттай хэвлэл, дижиталжуулах төсөл гэх мэт номын сан, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх шинэлэг хандлагыг судлах зорилгоор дижитал номын сан, судалгааны санаачилгуудтай хамтран ажилладаг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Түншлэлийн арга барилыг номын сан, мэдээллийн стратегид тусгасан. Тэнхимүүд, бусад байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, технологийн нийлүүлэгчид зэрэг олон янзын оролцогч талуудаас тогтсон хүчтэй, стратегийн түншлэлийг бий болгосон.
- Байгууллага доторх болон гаднах олон төрлийн нөөц, үйлчилгээнд саадгүй нэвтрэх боломжийг олгодог нэгдсэн дижитал номын сангийн экосистемийг бий болгоход анхаардаг. Байгууллага нь нээлттэй хандалтын санаачлага зэрэг дижитал номын сангийн үйлчилгээ үзүүлэх шинэлэг арга барилыг хөгжүүлэх, сурталчлахад идэвхтэй оролцдог.

# Өгөгдлийн удирдлага, хэрэглээ

Өгөгдөлд суурилсан байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг дэмжихийн тулд үр дүнтэй дүн шинжилгээ хийж, ашиглах боломжтой арга замаар өгөгдлийг цуглуулж, зохион байгуулж, хадгалж, хуваалцахтай холбоотой аргачлал, журам гаргах. Үүнд бүх хэлбэрийн өгөгдлийн ёс зүйт хэрэглээ, чанар, засаглал, стандарт, аюулгүй байдал, хууль журмын хэрэгжилт зэрэг багтана.



## 60 Дижитал өгөгдлийг удирдах, ашиглах стратегийн аргачлал

**Гол чиглэл:**
Өгөгдлийн стратеги | Өгөгдлийн аналитик | Өгөгдлийн архитектур | Өгөгдлийн боловсрол | Өгөгдлийн нууцлал | Өгөгдлийн ёс зүй | Өгөгдлийн чанар | Кибер аюулгүй байдал | Нийцэл | Байгууллагын архитектур | Ёс зүй

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Байгууллагын зорилтуудыг дэмжих, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах үйл явцыг мэдээллээр хангахын тулд дижитал өгөгдөл стратегийн аргачлал хэрэгжүүлэх нь чухал гэдгийг тус байгууллага хүлээн зөвшөөрдөг.
- Өгөгдөл цуглуулах, хадгалах, удирдах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа нь байгууллага даяар уялдаа холбоогүй бөгөөд үүний улмаас нэг мэдээллийн олон хувилбар гарч ирдэг бөгөөд тэдгээрийг системүүдээр дамжуулах ашиглахад бэрхшээл үүсдэг.
- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, дүрэм журмын хэрэгжилтийг хангах үүднээс өгөгдлийн засаглалыг сайжруулах ажил хэрэгжиж байгаа.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал өгөгдлийн стратегийн аргачлал боловсруулж байгаа (буюу илүү өргөн хүрээг хамарсан дижитал шилжилтийн эсвэл өгөгдлийн стратегид нэгтгэн оруулж байгаа). Өгөгдлийн стратегийн байгууллагын эрхэм зорилго, зорилгод оруулах хувь нэмрийн талаар нийтлэг ойлголтыг оролцогч талууд хөгжүүлж байгаа.
- Уялдаа холбоогүй системүүдийг нэгтгэсэн өгөгдлийн архитектурыг хөгжүүлснээр өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах үйл явцыг дэмжих боломжтой болсон.
- Өгөгдлийн удирдлагын төвлөрсөн системийг хөгжүүлж, өгөгдлийн чанарыг үнэлж, сайжруулж байгаа.
- Өгөгдлийн засаглалын бодлого, журмыг хэрэгжүүлсэн.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал өгөгдлийн стратегиудын асуудлар санал нэгдсэн бөгөөд дижитал өгөгдлийг үр дүнтэй цуглуулах, удирдах, ашиглах үйл явцыг бүх стратегид нэгтгэсэн.
- Өгөгдөлд тулгуурлан шийдвэр гаргах үйл явцыг байгууллагын үйл ажиллагааны бүх чиг үүргийн хүрээнд нэвтрүүлсэн. Өгөгдлийн бүрэн цогц архитектурыг (Enterprise Architecture [EA] тогтолцоотой уялдуулж, нэгтгэсэн) хэрэгжүүлснээр өгөгдлийг төвлөрүүлэн хадгалах, саадгүй нэгтгэх, өгөгдлийг үр ашигтай удирдах боломжтой болсон.
- Хэрэгжих боломжтой дүгнэлт гарган авах боломжтой дэвшилтэт техник (хиймэл оюун гэх мэт) ашиглан өгөгдлийн аналитик шинжилгээ хийдэг.
- Өгөгдлийн нууцлал, ёс зүй, аюулгүй байдал, дүрэм журмын нийцлийн асуудлаар тодорхой бодлого, журам, хариуцсан эзэн бүхий өгөгдлийн засаглалын цогц тогтолцоо бий болсон.
- Ажилтнууд өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлбарлах өндөр ур чадвартай. Тэд тус тусын албан тушаалын хүрээнд өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах эрх мэдэлтэй.
- Дижитал өгөгдлийн стратегийг оролцогч талуудын санал хүсэлт, хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд үндэслэн тогтмол хянаж, шинэчилж, оновчтой болгодог ба ингэснээр дээд боловсролын орчинд гарсан өөрчлөлтөд шуурхай хариу үйлдэл үзүүлэх нөхцөл боломжоор байгууллагыг хангадаг.



## 61 Оюутны өгөгдлийн шаардлагыг тодорхойлон, зураглах

**Гол чиглэл:**
Өгөгдлийн архитектур |
Өгөгдлийн чанар
Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Байгууллага нь оюутны өгөгдөлд өгөгдлийн шаардлага тодорхойлох ажлыг маш хязгаарлагдмал түвшинд хийдэг ба үүнийгээ өөр өөр систем, хүснэгтүүдэд тусад нь хадгалдаг. Энэ ажлыг зарим тохиолдолд түр зуурын зорилгоор хийсэн байдаг ч нэгдсэн зохион байгуулалт байхгүйгээс алдаатай, бүрэн бус өгөгдөл үүсдэг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Өгөгдлийн шаардлага тодорхойлох ажлыг чухалд тооцдог бөгөөд байгууллагын зүгээс оюутны мэдээллийг удирдах системчилсэн аргачлал боловсруулж байгаа. Өгөгдлийг нэгтгэх үйл явцыг оновчтой болгох, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор оюутны мэдээллийг төвлөрүүлэн хадгалж, удирдах системийг боловсруулж байгаа. Оюутны мэдээллийн зураглал илүү нарийн, мэдээлэл сайтай, найдвартай болж байгаа.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Оюутны мэдээллийн шаардлагыг тодорхойлон, зураглах нь байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй өгөгдлийн удирдлагын практик дадлын салшгүй хэсэг юм. Өгөгдлийн чанар, жигд байдал, нарийвчлал нь өндөр ач холбогдолтой бөгөөд өгөгдлийн цогц архитектурын тусламжтайгаар оюутны өгөгдлийг үр ашигтай, саадгүй удирдах, ашиглах боломжтой болдог. Өгөгдлийг тодорхойлсон зураглалыг маш сайн, үнэн зөв гаргасан бөгөөд өөр өөр систем, хэрэглээний программуудын хооронд өгөгдөл хэрхэн холбогдож, урсаж буйг тодорхой харуулсан.

## 62 Найдвартай өгөгдлийн архитектур

**Гол чиглэл:**
Өгөгдлийн архитектур |
Өгөгдлийн чанар

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Мэдээллийг гэнэтийн буюу аргацаах байдлаар эмхтгэдэг тул чанар, тодорхой байдал нь эргэлзээ төрүүлдэг. Мэдээлэл нь тухайн алба, хэлтэс дотроо хадгалагддаг тул бүх ажилтнуудад хүртээмжтэй байдаггүй бөгөөд уг мэдээлэлд итгэхэд бэрх, үнэний олон, зөрчилдөөнтэй хувилбарууд гарч ирдэг.
- Өгөгдлийн засаглалтай холбоотой асуудлууд нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаарх холбогдох зохицуулалтыг дагаж мөрдөхөд хүндрэл учруулдаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Өгөгдлийг найдвартай эх үүсвэрээс хугацааны тогтмол интервалтайгаар авдаг. Өгөгдлийг харьцуулах боломж өндөр түвшинд хангагдсан. Алба, хэлтэс хооронд өгөгдлийг хуваалцаж, нээлттэй тодорхой болгож, өгөгдөл цуглуулах үйл явц тогтмол, ил тод явагддаг учир мэдээллийн үнэн зөв эсэхэд итгэх итгэлийн түвшин нэмэгдэж байгаа. Мэдээллийн удирдлагын төвлөрсөн системийг нэвтрүүлж байгаа.
- Өгөгдлийн нууцлал ба аюулгүй байдлын механизм харьцангуй сайжирсан тул холбогдох дүрэм журмыг (жишээлбэл, GDPR буюу Европын холбооны мэдээлэл хамгаалах ерөнхий журам) үр дүнтэй дагаж мөрдөх боломж олгодог.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Дотоод болон гадаад эх үүсвэрээс төвлөрүүлэн цуглуулсан нөөц болох өгөгдлийн чанарын баталгаар хангахын тулд бизнесийн ухаалаг системийг байгууллагын хэмжээнд ашигладаг. Байгууллага нь мэдээлэл цуглуулах, шинэчлэх нэгдсэн, уялдаа холбоо бүхий арга барилтай бөгөөд үүний дагуу өгөгдлийг нэгэн жигд, хамгийн сүүлийн хувилбараар шинэчлэгдсэн байхад анхаардаг ба үндсэн зорилго нь байгууллагын хэмжээнд бүгд итгэдэг "үнэний нэг хувилбар" буюу өгөгдлийн төвлөрсөн нэг л үнэн хувилбар ашиглах явдал юм. Өгөгдлийн стандартыг дагаж мөрдсөнөөр цаг хугацааны явцад өгөгдлийн тодорхой, тогтвортой байдал нэмэгдэх боломж бүрдсэн.
- Өгөгдлийн засаглалын бодлого, журмууд нь өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, холбогдох бүх дүрэм журмыг дагаж мөрдөх нөхцөлийг хангасан.



## 63 Мэргэшсэн өгөгдлийн мэргэжилтнүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулах

**Гол чиглэл:**
Дижитал чадавх | Ажилтны хөгжил

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Мэргэшсэн өгөгдлийн мэргэжилтнүүдтэй байхын ач холбогдлыг байгууллага хүлээн зөвшөөрдөг. Ажилд авах, тогтвортой ажиллуулахад чиглэсэн зарим нэг үр дүнтэй журам хэрэгжиж байгаа. Стратегид болон/эсвэл шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх нөөц бололцоо, боломж хомс байгаагаас өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг татан ажиллуулахад саад учирч байх магадлалтай.

### Тогтворжсон-Сайжирсан

- Тус байгууллага өндөр ур чадвартай өгөгдлийн мэргэжилтнүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах, амжилт сайшаах хөтөлбөр, өрсөлдөхүйц цалин гэх мэт ажилчдыг татах, үлдээх ашигтай санал, тэтгэмж, боломжуудыг санал болгодог. Өндөр мэргэшсэн ур чадвар, мэдлэгийг байгууллага даяар үнэлдэг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллага нь өндөр ур чадвартай өгөгдлийн мэргэжилтнүүдийн стратегийн дижитал шилжилтэд оруулж чадах хувь нэмэр, үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, шилдэг боловсон хүчнийг татах, үлдээн ажиллуулахын тулд ажилд авах, тогтвортой ажиллуулах, ажилтныг хөгжүүлэх асуудлаар стратегийн, шинэлэг хандлагыг баримталдаг. Өрсөлдөхүйц нөхөн олговор болон тэтгэмжийн багцууд, инновац болон тасралтгүй суралцах соёл, удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломж, салбартаа сэтгэлгээний манлайлал үзүүлэх боломж зэрэг тогтвортой ажиллуулахад чиглэсэн хүчин чармайлтууд гаргаж байгаа.

## 64 Ажилтны өгөгдөлтэй ажиллах ур чадварыг хөгжүүлэх

**Гол чиглэл:**

Дижитал чадавх | Өгөгдлийн боловсрол | Ажилтны хөгжил

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Ажилтнуудын дижитал өгөгдлийн чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаар тухайн шаардлага гарсан үед, ажилтнуудын хариуцсан ажлаас хамааран байгууллагын алба, хэлтэс, нэгж, багийн түвшинд явуулдаг. Ажилтнууд өгөгдөлд суурилсан аргачлалыг хүлээн зөвшөөрөх дургүй хандлагатай.
- Ажилтны өгөгдлийн тухай суурь боловсрол бага байгаа нь хүлээн зөвшөөрөгдсөн тул сургаж, хөгжүүлэх боломжийг төлөвлөж байгаа.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах анхан шатны ур чадвартай бүх ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх үүрэг хүлээсэн. Ижил төстэй ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай өөр өөр түвшний чадавхыг тодорхойлоход мэргэжлийн ажил үүргийн ур чадварын тодорхойлолтыг ашигладаг.
- Ажилтнуудын өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлбарлах чадварыг сайжруулахын тулд зохих түвшний хөгжлийн боломж, дэмжлэгийг бүх ажилтанд санал болгодог. Ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдал, дүн шинжилгээ, тайлбарлах чадварыг хөгжүүлэх сургалт явуулдаг. Дээд шатны удирдлага дижитал өгөгдлийн суурь мэдлэг олгох, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх тусгай сургалтанд хамрагддаг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Бүх ажилтнууд хувийн болон ажлын зорилгоор өгөгдөл, мэдээллийг ашиглах суурь боловсролын талаар сайн ойлголттой байдаг бөгөөд шаардлагатай бол бусад ажилтнууд эсвэл оюутнуудад дэмжлэг үзүүлэх боломжтой. Инновацыг бий болгох, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах зорилгоор өгөгдөл ашиглах боломжуудыг тодорхойлоход өөр өөр чиглэлийн мэргэшсэн өгөгдлийн ажилтнуудаас бүрдсэн баг байгууллагын хэмжээнд ажилтнуудтай хамтран ажилладаг.
- Өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах суурь мэдлэгийг бүх ажилтнуудын дижитал чадавхын төлөвлөгөөний чухал хэсэгт тооцдог. Өгөгдөлтэй ажиллах чадварыг өндөр түвшинд эзэмшсэн ажилтнууд байгууллагын хэмжээнд үлгэр жишээ үзүүлдэг.
- Өгөгдлийн шаардлага, технологийн дэвшлийг даган сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг цаг тухайд нь тогтмол шинэчилдэг.



## 65 Оюутны өгөгдөлтэй ажиллах суурь чадварыг хөгжүүлэх

**Гол чиглэл:**

Дижитал чадавх | Өгөгдлийн боловсрол | Оюутны суралцахуй

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Өгөгдөлтэй ажиллах суурь боловсролыг зарим хичээлд тусган оруулсан боловч бүх оюутнуудын өгөгдөл, мэдээллийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоотой стратеги байдаггүй.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Оюутнуудад албан ёсны хичээл, зааварчилгаанаас гадуур өгөгдлөл мэдээллийн суурь боловсрол олгох тусдаа сургалтуудыг санал болгодог бөгөөд онлайн хичээлүүдийг вэбсайтаас авах боломжтой.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Өгөгдөл, мэдээллийн суурь боловсролыг бүх оюутнуудад зориулсан дижитал чадавхын төлөвлөгөөний чухал хэсэгт тооцдог. Өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах суурь мэдлэгийг тухайн сэдвийн дагуух зохих бүх хичээлд тусгах оруулж өгсөн.

# Бизнесийн оюун

Бизнес, стратегийн шийдвэрийг мэдээллээр хангах зорилгоор өгөгдөл, мэдээллийг цуглуулах, удирдах, ашиглах. Үүнд бизнесийн байгууллагуудын өгөгдлийн дүн шинжилгээ хийж, бизнесийн мэдээлэл удирдахдаа ашигладаг стратеги, технологиуд орно.



## 66 Байгууллагын өгөгдлийг цуглуулах, удирдах, тайлан гаргах нийтлэг дадалтай болох, өгөгдөл хангамжийг зохицуулах стратегийн, нэгдсэн арга барил

**Гол чиглэл:**
Дижитал манлайлал | Бизнесийн оюунд тулгуурласан стратеги Тайлагнах | Удирдлагын мэдээлэл | Чиг хандлага тодорхойлох | Зах зээлийн судалгаа | Урьдчилсан таамаглал | Ёс зүйт систем, процесс | Хуваалцах | Нээлттэй, ил тод байдал | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт | Суурь түвшин тогтоох | Жишиг тогтоох

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Бизнесийн оюуны үндсэн функцийн тусламжтайгаар оюутны элсэлт, ажилтны ажлын ачаалал, санхүүгийн тайлан зэрэг стандарт тайланг гаргах боломжтой.
- Өгөгдлийн дүн шинжилгээ нь ихэвчлэн тайлбарлан, дүрсэлсэн шинж чанартай бөгөөд энгийн хураангуйлсан дүгнэлт, байгаа өгөгдлийг дүрслэн харуулахаас тогтдог. Тайланг ихэвчлэн алба, хэлтсийн ажилтнуудын ашигладаг хүснэгт, бизнесийн оюуны энгийн систем ашиглан гаргадаг.
- Системүүдийг хооронд нь бараг нэгтгээгүй бөгөөд өгөгдлийг ихэвчлэн тус тусад нь хадгалдаг тул байгууллагын үйл ажиллагааны талаар бүрэн цогц ойлголттой болоход бэрхшээлтэй.

### Тогтворжсон-Сайжирсан

- Төрөл бүрийн эх үүсвэрээс эхтэй өгөгдлийг нэгтгэсэн. Үүнд, оюутны мэдээллийн систем, сургалтын удирдлагын систем, санхүүгийн систем, судалгааны удирдлагын систем зэрэг орно. Байгууллага нь өгөгдлийг төвлөрсөн мэдээллийн санд хадгалдаг бөгөөд түүнд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргахдаа тусгай зориулалтын бизнесийн оюуны програм хэрэгслийг ашигладаг. Өгөгдлийн засаглал, өгөгдлийн чанар, аюулгүй байдалд илүү их анхаарал хандуулж, дээд түвшинд шийдвэр гаргах явдлыг дэмжиж мэдээллийг алба, хэлтэсүүд хоорондоо хуваалцдаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах соёлын хүрээнд бизнесийн оюуныг байгууллагын стратеги, зорилгыг дэмжих стратегийн хөрөнгөд тооцдог. Бизнесийн оюуныг дэмжих үүднээс дижитал мэдээллийн стратеги болон дижитал өгөгдлийн стратегийг уялдуулж, хослуулан ашиглах боломжтойгоор боловсруулсан.
- Урьдчилан таамаглах, зааварлах аналитик зэрэг дэвшилтэт аналитик арга техникүүд ашиглан өгөгдлөөс шийдвэр гаргахад туслах дүгнэлтийг гарган авдаг. Өгөгдлийг чиг хандлага тодорхойлох, оюутны үр дүнг урьдчилан таамаглах, нөөц, үйлчилгээг оновчтой болгоход ашигладаг.
- Ил тод байдлыг хангаж, амжилтанд хамтдаа хүрснийгээ илэрхийлж, гадны оролцогч талууд болон түншүүдийг дэмжих үүднээс өгөгдөлд үндэслэсэн дүгнэлт болон шийдвэр гаргах үйл явцыг оролцогч талуудтай хуваалцдаг.

# Шийдвэр гаргах

Байгууллагын үйл ажиллагааны бүх чиглэлээр стратегийн зорилгод хүрэх арга замуудыг тодорхойлж, шийдвэр гаргахдаа, тухайлбал, хөрөнгө оруулалт хийх, төлөвлөх зэрэгт ашиглах нотолгоо буюу бизнесийн өгөгдөл, түүнийг боловсруулах технологид дүн шинжилгээ хийж, үнэлэх.



## 67 Дижитал өгөгдөлд тулгуурлан шийдвэр гаргах, чанар болон хууль дүрмийн нийцлийг хангах

**Гол чиглэл:**
Дижитал манлайлал | Дижитал алсын хараа | Дижитал цогц чадвар | Дижитал итгэлийн түвшин | Дижитал нотолгоо буюу өгөгдөл | Асуудал шийдвэрлэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●–○–○ Эхлэл-Тогтворжсон**

- Шийдвэр гаргалтад дижитал мэдээлэл болон өгөгдлийн ач холбогдлыг тус байгууллага хүлээн зөвшөөрдөг ч түүнийг цуглуулах, дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байдаг. Системүүд болон өгөгдлийн дүн шинжилгээ хоорондын уялдаа холбоо дутмаг байгаагаас үүдэн дүн шинжилгээ нь урьдчилан таамаглах бус голдуу тайлбарлан дүрслэх шинж чанартай байдаг. Шийдвэр гаргах үйл явц нь өгөгдөлд тулгуурласан дүгнэлтээс илүүтэй мэдрэмж, туршлага дээр суурилдаг.

**○–●–○ Тогтворжсон-Сайжирсан**

- Төрөл бүрийн эх үүсвэрээс авсан дижитал мэдээлэл болон өгөгдлийг нэгтгэж, ахисан түвшний аналитик чадавхыг бий болгож байгаа. Өгөгдлийг төвлөрсөн мэдээллийн санд хадгалдаг бөгөөд бизнесийн оюуны ахисан түвшний хэрэгслүүдийг ашиглан дүгнэлт гарган авч, дүрслэл үүсгэдэг.

- Шийдвэр гаргах үйл явц нь улам бүр өгөгдөлд тулгуурлах хандлагатай байгаа бөгөөд, туршилт, инновацын соёл ч мөн нэмэгдэж байгаа. Гэсэн хэдий ч байгууллагын алба, хэлтэс, нэгж хооронд хил, зааг байсаар байгаа бөгөөд энэ нь байгууллагын хэмжээний үйл ажиллагааны талаар цогц ойлголт авах боломжийг хязгаарладаг.

**○–○–● Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал мэдээлэл болон өгөгдлийг байгууллагын дээд түвшинд шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх стратегийн хөрөнгө гэж үздэг. Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт нь өгөгдөлд тулгуурласан хандлагыг дэмжих ба ажилтан сонгон шалгаруулж, хөгжүүлэх үйл явцын хүрээнд дээд шатны удирдлагын дижитал мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах чадавхыг нэн чухалд тооцдог.

- Инновацыг дэмжих, оюутны үр дүнг сайжруулах, стратегийн зорилгод хүрэхийн тулд урьдчилан таамаглах аналитик болон машин сургалт зэрэг дэвшилтэт аналитик системүүдийг ашиглаж байгаа. Өгөгдөлд тулгуурлан шийдвэр гаргах соёл тогтсон бөгөөд байгууллага нь үйл ажиллагаа явуулах, стратегийн шийдвэр гаргахдаа ашиглах зорилгоор дижитал мэдээлэл, өгөгдөл, дүгнэлтийн шинэ эх үүсвэрүүдийг байнга эрэлхийлж байдаг. Чиг хандлага тодорхойлох үйл ажиллагааны үр дүнг шийдвэр гаргах, төлөвлөлт хийхдээ ашигладаг.

## 68 Мэдээлэлд суурилан шийдвэр гаргах, удирдах

**Гол чиглэл:**

Дижитал манлайлал | Дижитал итгэлийн түвшин

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Дээд шатны удирдах ажилтнууд болон захирлууд дижитал мэдээлэл, өгөгдлийг төрөл бүрийн эх үүсвэрээс тухайн хэрэгцээ, шаардлага гарсан үед эсвэл тодорхой багуудад хүсэлт гарган хүлээн авдаг. Дижитал шилжилттэй холбоотой төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаа нь чиг хандлага тодорхойлох үйл ажиллагаа, алба, хэлтсийн мэдээлэл, хувь хүний оруулсан хувь нэмэр, салангид мэдээлэл зэрэг хуваагдмал мэдээлэлд суурилж, хэсэгчилсэн байдлаар явагддаг.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Дээд шатны удирдлагууд болон захиралууд дижитал манлайллын ач холбогдлыг ойлгон ухамсарладаг ба мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах зохих чадавхыг эзэмшиж, хөгжүүлэхдээ дэмжлэг тусламж авдаг. Тэд мөн их сургуулийн бизнесийн үйл ажиллагааны бүх чиглэлээр шийдвэр гаргах зорилгоор дижитал хэрэгсэл, мэдээлэл, өгөгдлийг ашигладаг.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Шийдвэр гаргах үйл явц нь байгууллагын үнэт зүйл, зорилгыг тусгасан байдаг. Дээд шатны удирдлага болон захирлууд шийдвэр гаргахдаа дижитал хэрэгсэл, систем, мэдээлэл, өгөгдлийг ашиглахдаа өөртөө итгэлтэй байдаг. Байгууллагын дижитал ур чадвар сайтай ажилтнууд болон оюутнууд стратегийн шийдвэр гаргах, түншлэл, хамтран төлөвлөх соёлыг тогтоохоод хувь нэмэр оруулснаар бүх оролцогч талуудад өөрсдийн ажиллах, суралцах хугацаандаа хуримтлуулах туршлагад нөлөөлөх стратегийн төлөвлөлт, шийдвэрт хувь нэмрээ оруулах боломж бийг үлгэрлэн харуулдаг.



# Мэдлэг солилцох, түншлэх

Байгууллагын гол мессежүүдийг дамжуулан түгээх, мөн бүх түнш/оролцогч талуудын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог дэмжих зорилгоор мэдлэг солилцоог нэмэгдүүлэх.





Харилцаа холбоо
>>

Хамтын ажиллагаа
>>

Олон нийтийн оролцоо
>>

Харилцааны удирдлага
>>

# Харилцаа холбоо

Байгууллага нь оролцогч талуудын хоорондын харилцаа холбоог сайжруулан, дэмжих, түүнчлэн байгууллагын гол үзэл санааг буюу мессежийг гадагш түгээх зорилгоор дижитал технологи, сүлжээг хэрхэн ашиглах тухай авч үзнэ.



## 69 Дижитал харилцаа, холбооны стратеги

**Гол чиглэл:**

Дижитал харилцаа холбоо | Дижитал сүлжээ | Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал мэдээллийн хэрэгсэл | Дижитал ёс суртахуун | Нийгмийн сүлжээ | Байгууллагын харилцаа холбоо

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллагын дижитал харилцаа холбооны бодлогыг бий болгож байгаа, мөн түүнчлэн харилцаа холбоог байнгын, хүртээмжтэй байлгах үүднээс төрөл бүрийн дижитал харилцаа холбооны сувгуудыг ашигладаг.
- Оролцогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдсөний үндсэн дээр байгууллагын харилцаа,холбооны бодлогыг боловсруулдаг.
- Аюулгүй байдлын арга хэмжээ, мэдээллийн нууцлалтай холбоотой дадал хэвшил нь энгийн түвшинд байгаа бөгөөд энэ нь дижитал харилцаа холбооны өгөгдөл хамгааллын дүрэм журмыг дагаж мөрдөх нөхцөлийг хангар хэмжээнд байгаа.
- Хэрэглэгчдийн бүлгүүдийн олон янз байдлыг харгалзан үзэх, тэдгээрийн өөр өөр хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дижитал харилцаа холбоог зохион байгуулах нь хязгаарлагдмал.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Хэрэглэгчийн олон янзын бүлгүүдтэй харилцах, агуулгыг оновчлон аль болох олонд хүргэхэд чиглэсэн дижитал харилцаа холбооны бодлого боловсруулсан.
- Олон янзын дижитал сувгуудыг суралцагчид, ажил олгогчид, судалгааны түншүүд, салбарын мэдлэг солилцох түншүүдтэй харилцах, тэдний асуултад шуурхай хариулах зорилгоор ашигладаг.
- Бүх оролцогч талууд хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн өөрт тохирсон харилцааны сувгийг сонгон, олох боломжтой бөгөөд байгууллагын бодлого нь хязгаарлах бус харин дэмжихэд чиглэнэ.
- Хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалахын тулд аюулгүй байдлын найдвартай арга хэмжээ авч, нууцлалын дадал хэвшлийг хэрэгжүүлдэг.
- Дижитал харилцаа холбооны стратегиуд нь янз бүрийн хэрэглэгчийн бүлгүүдийн тодорхой сонирхол, шаардлагыг хангахад чиглэсэн байдаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын бүх хэлтэс, багуудын хийж буй ажил, хөдөлмөр зүтгэлийг үр дүнтэйгээр уялдуулан, синхрончлох дижитал харилцаа холбооны нэгдсэн, уялдаа холбоо бүхий аргачлал хэрэгжүүлдэг.
- Дижитал харилцаа холбооны систем, бодлого, практик дадал зэргийг зөв хослуулан хэрэгжүүлснээр, хэрэглэгчдийг саад тотгоргүй, оролцоог хангасан сонирхолтой туршлага хуримтлуулах нөхцөлөөр хангаж, сургалт, судалгааны чиглэлээр байгууллагын нэр хүндийг өсгөхөд нөлөөлдөг. Оролцогч талууд мэргэжлийн болон эрдэм шинжилгээний нийгэмлэг, бүлэг, хүрээлэлд нэгдэн бусадтай харилцахдаа итгэл төгс, ёс зүйтэй оролцдог.
- Аюулгүй байдлын систем, протоколуудад тогтмол аудит, шинэчлэлт хийж, мэдээлэл хамгаалал, нууцлалын найдвартай арга хэмжээ авдаг.
- Байгууллага нь дижитал программ хэрэгсэл ашиглан суралцагчид болон бусад гол оролцогч талуудад (тухайн хүнд ба/буюу байгууллагад) тохируулан, харилцаа холбоогоо сайжруулдаг.
- Өгөгдлийн аналитик болон хэрэглэгчийн зан төлөвөөр гаргасан дүгнэлт дээр үндэслэн бүх төрлийн сувгаар явагдах дижитал харилцаа, холбоогоо тухайн хувь хүн ба/буюу байгууллагад нийцүүлэн тохируулдаг.
- Аналитик хэрэгслүүдээр дамжуулан дижитал харилцаанд нэвтрүүлсэн арга хэмжээний үр дүнг хянаж, хэрэглэгчийн зан төлөвийг судалсны үндсэн дээр стратегийг илүү боловсронгуй болгодог.



# 70 Дижитал контент бүтээх, түгээх

**Гол чиглэл:** Дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэл

| Нийгмийн сүлжээ  Байгууллагын харилцаа холбоо

Төлөвшлийн түвшин сонгох

### Эхлэл-Тогтворжсон

- Их сургууль, хичээл, тэнхим, судалгаа, арга хэмжээ, мэдээ, холбоо барих мэдээлэл зэргийг агуулсан бүрэн цогц вэбсайт нь гадны оролцогч талуудтай харилцах үндсэн сувгийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь мөн ажилтнууд болон оюутнуудын ажиллаж, суралцахад дэмжлэг болох олон төрлийн агуулгад хандах үндсэн портал болж өгнө.
- Байгууллагын онлайн харилцаа холбоо нь тодорхой сонгосон нийгмийн сүлжээний платформуудад төвлөрсөн бөгөөд хэрэглэгчидтэй бараг харилцаа үүсгэхгүй, гол төлөв мэдээ, мэдээлэл хуваалцдаг.
- Зураг, видео зэрэг зарим мультимедиа контентыг харилцаандаа ашигладаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Зөөврийн болон суурин төхөөрөмжид аль алин дээр нь нээх боломжтой бүрэн цогц вэбсайтаар дамжуулан ажилтнууд, оюутнууд болон гадны оролцогч талуудын хэрэглээнд анхаарч сайжруулсан.
- Нийгмийн сүлжээний олон платформ дээр хуудастай болсноор мэдээ, үйл явдал, судалгааны мэдээлэл, амжилтын түүхээ хуваалцах замаар оролцоог нэмэгдүүлэх боломжтой болсон.
- Харилцаа холбоог сайжруулахын тулд зураг, видео, инфографик зэрэг мультимедиа контентыг тогтмол ашигладаг.
- Хайлтын системийг энгийн түвшинд оновчилж байгууллагын дижитал контентын хайлтын систем дэх илэрцийн зэрэглэлийг нэмэгдүүлсэн.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Хувь хүний хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн тохируулсан контент, интерактив функцууд, саадгүй аялах холбоосууд бүхий бүрэн цогц ажиллагаа бүхий вэбсайтаар дамжуулан бүх оролцогч талуудын хэрэглээг дээд зэргээр хангасан.
- Нийгмийн сүлжээний олон платформ дээр маш идэвхтэй байдаг бөгөөд тэдгээрийн статистик хэмжүүрүүдийг тогтмол хянаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ирээдүйн стратегиудыг боловсруулдаг.
- Байгууллагын үнэт зүйлс, судалгаа, ололт амжилтыг олон нийтэд үр дүнтэй хүргэхийн тулд видео, подкаст, интерактив контент зэрэг мультимедиа контентыг өргөнөөр ашигладаг
- Хайлтын системийн оновчлолын дэвшилтэт аргуудыг хэрэгжүүлсэн бөгөөд дижитал контентыг аль болох олон хүнд харагдуулж, хүргэхээр оновчилсон.

## 71 Тэгш, хүртээмжтэй дижитал харилцаа холбоо

**Гол чиглэл:**
Дижитал мэдээллийн хэрэгсэл | Дижитал ёс суртахуун | Тэгш хүртээмж, тэгш оролцоо
Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Эрх тэгш, хүртээмжтэй дижитал харилцаа холбоог чухалд авч үзэхээр стратегийн баримт бичигт тусган зааж өгсөн. Гэсэн хэдий ч өөр өөрө оролцогч талуудад тулгарч буй асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар ойлголт хязгаарлагдмал байдаг.

- Их Британийн дүрэм журмыг дагаж мөрдөхөд гол анхаарлаа хандуулдаг. Дижитал харилцаа холбоог оюутнуудад илүү хүртээмжтэй болгох үүднээс зарим нэг хувь хүн болон хэлтсийн зүгээс сайжруулалт хийдэг (жишээлбэл, дижитал ёс дүрмийн талаар заавар, дэмжлэг үзүүлэх).

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага нь дижитал харилцаа холбоо, сүлжээг цогцоор нь авч үздэг бөгөөд бүх ажилтан, оюутнуудад тэгш, хүртээмжтэй байх нөхцөлөөр хангадаг.

- Дижитал харилцаа холбоог зүй зохистой ашиглах ур чадварыг дижитал чадавхын төлөвлөгөөний чухал хэсэгт тооцдог. Ажилтнууд болон оюутнуудад дижитал сувгуудаар дамжуулан харилцахад нь туслах хүртээмжийг дэмжсэн хэрэгслүүд болон туслах технологийг санал болгодог.

- Дижитал харилцааны талаарх удирдамж, бодлогуудыг шинэ ажилтан, оюутанд зориулсан сургалтаар заан танилцуулдаг.

- Ажилтнуудад дижитал мэдээллийн хэрэгслийн талаарх дүрэм журмуудыг дагаж мөрдөхөөс гадна дижитал харилцаа холбоог бүх талаар нь илүү тэгш, хүртээмжтэй болгохыг хичээхэд уриалдаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Дижитал харилцаа холбоо, сүлжээтэй холбоотой бүх үйл ажиллагааны чиглэлд тэгш, хүртээмжтэй байдлын соёл нэвтэрсэн. Ажилтнууд болон оюутнууд хэрэгцээ, шаардлагадаа нийцсэн дижитал хэрэгсэл, нөөцийг хамтран бүтээхэд идэвхтэй оролцох бүрэн эрхтэй бөгөөд дижитал харилцааны бодлого, удирдамж боловсруулахад хувь нэмрээ оруулдаг.
- Тус байгууллага нь дижитал харилцаа холбооны технологийг практикт нэвтрүүлэх чиглэлээр салбарын хэмжээнд эерэг өөрчлөлт хийх зорилгоор бусад байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг.

- Бүх дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны сувгуудын үйл ажиллагаа Их Британийн дүрэм журамд нийцсэн бөгөөд мэдээллийг өөр хэлбэрээр хүлээн авах шаардлагатай, оролцоог нь хангахад нэмэлт арга зам шаардлагатай оюутнуудыг өөр аргачлал механизмаар хангаж ажиллах ажилтнуудад цаг гаргаж өгч, сургалт явуулж, дэмжлэг үзүүлдэг.



## 72 Дижитал медиа чиглэлээр ур чадвар, туршлагатай ажилтнуудыг ажилд авах, хөгжүүлэх, үлдээх

**Гол чиглэл:**
Дижитал мэдээллийн хэрэгсэл | Ажилтны хөгжил
Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Байгууллага нь дижитал хэвлэл мэдээллийн хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдтэй байхын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Зарим нэг ажилд авах, тогтвортой ажиллуулах журам ур дүнтэй хэрэгжиж байгаа. Стратеги болон/эсвэл шийдвэр гаргахад нөлөөлөх нөөц бололцоо, боломж дутмаг байдал нь өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг татах, тогтвортой ажиллуулахад саад болох магадлалтай.

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага нь дижитал хэвлэл, мэдээллийн хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг ажилд авах, тогтвортой ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах боломж, амжилт сайшаах хөтөлбөр, өрсөлдөхүйц цалин, үнэ цэнэтэй тэтгэмж зэрэг ажилчдыг татах, үлдээх янз бүрийн хөнгөлөлт, нөхцөлүүдийг санал болгодог. Өндөр мэргэшсэн ур чадвар, мэдлэгийг байгууллага даяар үнэлдэг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллага нь стратегийн дижитал шилжилт хийхэд чадварлаг дижитал хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэргэжилтнүүдийн оруулж чадах үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, шилдэг боловсон хүчнийг татах, тогтвортой ажиллуулахын тулд ажилтныг ажилд авах, үлдээх, хөгжүүлэхэд стратегийн, шинэлэг хандлагыг баримталдаг. Өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллуулах зорилгоор өрсөлдөхүйц нөхөн олговор болон тэтгэмжийн багцууд, инновацын болон тасралтгүй суралцах соёл, удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломж, салбартаа сэтгэлгээний манлайлал үзүүлэх боломж зэргийг хэрэгжүүлдэг.

# Хамтын ажиллагаа

Оролцогч талуудыг бусадтай хамтран ажиллаж тодорхой тавьсан зорилгодоо хүрэхэд нь туслах дижитал технологийг байгууллагын хүрээнд хэрхэн ашиглаж болох тухай авч үзнэ.
Үүнд аюулгүй, тэгш хүртээмжтэй, тусалж дэмжихэд чиглэсэн ажлын болон сургалтын дадал хэвшлүүд орно.



## 73 Дижитал хамтын ажиллагааны соёл

**Гол чиглэл:**
Ажилтны хөгжил | Оюутны хамтын ажиллагаа | Дижитал хамтын ажиллагаа | Тэгш хүртээмж, тэгш оролцоо

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Зарим нэг хэлтэст дижитал хамтын ажиллагааны соёлыг дэмждэг ба дижитал хамтын ажиллагааны эрсдэл, ашиг тусын талаар нэгдсэн стратегийн арга барил, ойлголт байдаггүй.
- Байгууллагын ажилтнууд болон оюутнууд кампусын дотор болон гадна хамтран ажиллахдаа олон төрлийн дижитал хэрэгсэл, үйлчилгээг ашигладаг. Дижитал болон бодит дэд бүтцийг ашиглан дижитал орчинд харилцаж, баримт бичиг хуваалцах боломжтой. Эрсдэлтэй арга замаар мэдээлэл хуваалцаж, хамтран ажиллахыг багасгах зорилгоор мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хамтын ажиллагааны хэрэгслийг ашигладаг бөгөөд зарим тодорхой хэрэгслийг ашиглах сургалт, дэмжлэг авах боломжтой.
- Оюутнууд хичээл, сургалтын үйл ажиллагааны үеэр хамтран ажилладаг боловч энэ нь ямар ашиг тустай талаар тэр бүр мэддэггүй бөгөөд дижитал хэрэгсэл ашиглан багаар ажиллах арга замын талаар тодорхой ойлголтгүй байдаг.
- Оюутнуудад хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн эрүүл мэнд, айдас түгшүүр, мэдрэлийн гажиг зэргээс шалтгаалан нүүр тулсан хамтын ажиллагаанаас татгалзах (эсвэл өөр хувилбараар оролцоог хангах) боломжийг олгодоггүй.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Дижитал хамтын ажиллагааг байгууллагын дижитал шилжилтийн стратегид багтаасан.
- Кампус доторх болон гаднах хүмүүст хамтран ажиллах боломж олгохын тулд байгууллагын дижитал болон бодит дэд бүтцийг (жишээлбэл, үүлэнд суурилсан платформууд, сүлжээ болон харилцаа холбооны системүүд, нууцлал ба аюулгүй байдал, өгөгдлийн аналитик) сайжруулж, аюулгүй, найдвартай дижитал хэрэгсэл болон хамтын ажиллагааны орон зайн хамрах хүрээг өргөжүүлсэн.
- Удирдах ажилтнууд, ажилтнууд, оюутнуудын дижитал чадавхын төлөвлөгөөний нэгэн чухал хэсэг бол дижитал хамтын ажиллагаа хэмээн тодорхойлсон.
- Дижитал хамтын ажиллагааг хичээлийн хөтөлбөр боловсруулах үйл явц болон дижитал сургалтын салшгүй хэсэгт тооцож төрөл бүрийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ялгаатай бүлгийн суралцагчдад түлхүү анхаарсан. Зарим хүмүүсийн хамтран ажиллах үйл явцыг хөнгөвчлөхийн тулд дижитал арга хэрэгслийг ашигладаг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Боловсронгуй дижитал стратеги, сайтар хөгжүүлсэн дижитал дэд бүтцийн дэмжлэгтэйгээр бүх оролцогч талууд дижитал орчинд үр дүнтэйгээр хамтран ажилладаг. Байгууллагын өөр өөр алба, хэлтэс, нэгж хоорондоо хамтран ажилласнаар дижитал манлайлал үзүүлэх, санаа бодол, мэдлэг туршлагаа хуваалцах боломжтой.
- Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлын асуудлаар стратегийн тууштай арга барил хэрэгжүүлснээр дижитал хэрэгсэл, платформын үр дүнтэй, найдвартай ажиллагаар хангах үнэлгээ, тохиргоог тогтмол хийж, тасралтгүй сайжруулах соёлыг дэмждэг.
- Ажилтнууд болон оюутнууд дижитал хамтын ажиллагааны үр ашиг, эрсдэлийн талаар тодорхой ойлголттой бөгөөд өөрсдийн ажиллах, суралцах хэрэгцээ, шаардлагадаа нийцүүлэн дижитал хэрэгсэл, сүлжээ, үйлчилгээг аюулгүй ашиглах итгэлтэй, чадвартай байдаг. Мөн тэд хүртээмжтэй дизайн, оролцооны талаар сайн ойлголттой байдаг. Өөрсдийгөө тогтмол хөгжүүлэх, сүүлийн үеийн технологийн чиг хандлагаас хоцрохгүй байх боломж бүх ажилтнуудад нээлттэй.
- Оюутнууд хамтын сургалтын үйл ажиллагааг төлөвлөхөд оролцох боломжтой.
- Судалгаа, сургалтын чиглэлээр гадны түншүүдтэй сайтар хамтран ажилладаг ба үүний үр дүнд мэдлэг солилцож, хамтын инновац хэрэгжүүлэх боломжтой.
- Тус байгууллага нь дижитал хамтын ажиллагаанд инновацын соёлыг төлөвшүүлж, судалгаа, хөгжлийг дотоод болон гадаадад дэмжин ажилладаг.



## 74 Мэдлэг хуваалцах, солилцох үйл явцыг дэмжих нээлттэй туршлага

**Гол чиглэл:**
Олон нийтийн хамтын ажиллагаа | Олон улсын үйл ажиллагаа | Нээлттэй хуваалцах

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Нээлттэй мэдлэгийг сурталчлах үндсэн алхмуудыг хийсэн бөгөөд үүнийг байгууллагын соёл, практик нэгтгэхийг эрмэлзэж байгаа.
- Нээлттэй хандалтын бодлого нь сонирхсон дээд шатны удирдлага, судалгааны баг, номын сан ба мэдээллийн мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээний алба, багш нар, мэдээллийн технологийн баг, оюутнуудын хамтын хүчин чармайлтаар бий болдог. Гэсэн хэдий ч байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, мэдээлэл өгөх нь бага.
- Цөөн хэдэн хүмүүс нээлттэй боловсролын нөөцийг ашигладаг ба/буюу хөгжүүлдэг.
- Орон нутгийн, үндэсний эсвэл олон улсын түвшинд салбарын болон бусад байгууллагуудтай тухайн шаардлагатай үед хамтран ажилладаг.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Хамтын санаачлага хэрэгжүүлэх, оролцогч талуудын мэдлэгийг дээшлүүлэх замаар нээлттэй мэдлэг солилцоход чухал ахиц дэвшил гарсан.
- Сайтар тодорхойлсон нээлттэй хандалтын бодлого хэрэгжүүлснээр судлаач, багш нар нээлттэй туршлагыг улам бүр хэрэгжүүлэх болсон.
- Тус байгууллага нь нээлттэй боловсролын нөөцийг ашиглахыг дэмждэг бөгөөд ажилтнууд нь нээлттэй боловсролын нөөц үүсгэх, лицензжүүлэх, нийтэд нээлттэй болгох чиглэлээр сургалт, дэмжлэг авдаг.
- Нээлттэй мэдлэгийн арга хэмжээг дэмждэг ба ажилтнууд өөр өөр мэргэжлийн чиглэлүүд хоорондын нээлттэй судалгаанд хамтран ажилладаг.

## Сайжирсан-Төлөвшсөн

- Нээлттэй мэдлэг солилцоог стратегийн зорилгод тусгасан чухал зарчимд тооцдог ба байгууллагын хэмжээнд нээлттэй, хамтын ажиллагааны соёлыг дэмжин төлөвшүүлдэг.
- Нээлттэй хандалтын бодлогыг цогцоор нь, өргөн хүрээнд хэрэгжүүлж, байгууллагын хэмжээнд сайн дэмждэг.
- Нээлттэй боловсролын нөөцийг өргөнөөр ашиглах, хөгжүүлэх нь оюутнуудад үр өгөөжөө өгч, мэдлэг солилцоог сайжруулж, байгууллага болон хувь хүмүүсийн нэр хүндийг өсгөдөг.
- Байгууллагын дижитал агуулгыг (жишээлбэл, дижиталжуулсан давтагдашгүй, өвөрмөц цуглуулга сан хөмрөг, судалгааны бүтээлүүд, нээлттэй монограф) нээлттэйгээр нийтлэн, хамтын ажиллагаа, оролцоог дэмжсэн үйл ажиллагаанд ашигладаг.
- Тус байгууллага нь инновац, хамтын ажиллагааг дэмжиж, салбарын болоод бусад байгууллагууд, нээлттэй эх сурвалжийн нийгэмлэгүүдтэй нягт түншлэн ажилладаг.



# Олон нийтийн оролцоо

Өөрсдөд нь нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад оролцоход нь оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх. Оролцогч талуудад олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломж олгох, дэмжих. Дижитал оролцоог тэгш, хүртээмжтэй байлгах нөхцөлөөр хангах.



## 75 Бүх оролцогч талуудын дижитал оролцоог дэмжих

**Гол чиглэл:**

Дижитал оролцоо | Харьяалагдах хэрэгцээ | Тэгш хүртээмж, тэгш оролцоо

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Зарим систем, үйлчилгээ, арга барил нь дижитал оролцоог дэмждэг боловч тухайн тэнхим, багш нарын соёл, практикаас хамаардаг.
- Хүртээмжтэй байдлын стандарт, дүрэм журмыг боловсруулсан боловч зарим дижитал платформ болон контент нь хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийн хувьд бүрэн нэвтэрч, ашиглах боломжгүй байдаг. Олон хэлний дэмжлэг, соёлын мэдрэмж, дижитал ядуурал зэрэг хүртээмжтэй байдлын талаар анхаарах зүйлс нь платформ, системүүд дээр маш бага буюу жигд бус.
- Ажилтнууд болон оюутнууд багаар болон төслийн бүлгээр үр дүнтэй ажиллах зорилгоор байгууллагын дотоод харилцааны хэрэгслийг (и-мэйл, дундын календарь, дундын драйв буюу хадгалах төхөөрөмж гэх мэт) ашигладаг.
- Дижитал оролцоог дэмжих сургалт, үйлчилгээ нь тодорхой хэрэгслүүдийг ашиглахад чиглэдэг бөгөөд ажлын, хувийн, сургалтын бүлэг, нийгэмлэгт хамрагдан оролцоогоо бүрэн хангах итгэл, чадавхыг бий болгох талаар өргөн хүрээний ойлголтгүй.

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийн хүрээнд ажиллах, суралцах, иргэний хувиар эдлэх боломжуудыг нэмэгдүүлэхэд дижитал оролцоо ихээхэн ач холбогдолтойг хүлээн зөвшөөрдөг.
- Оролцогч талуудад дижитал оролцооны ашиг тусыг ойлгоход нь дэмжлэг үзүүлж, хүссэн үедээ оролцоогоо бүрэн хангах боломж олгох үүднээс тулгарч буй сорилт болон хэрэгцээ шаардлагуудаа тодорхойлж, илэрхийлэхийг нь дэмждэг.
- Дижитал платформ, сүлжээ, контентын хүртээмжтэй байдал нь оролцогч талуудын олон янзын хэрэгцээ шаардлагын талаар илүү нарийн ойлголттой болохын хэрээр байгууллагын хэмжээнд гол анхаарах зүйл болж хувирна.
- Дижитал оролцоог удирдах ажилтнууд, ажилтнууд болон оюутнуудад зориулсан дижитал чадавхын төлөвлөгөөний гол элемент хэмээн үздэг.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Тэгш оролцоо, хамтын ажиллагааг дэмжсэн соёл тогтсоноор бүх оролцогч талууд янз бүрийн бүлэг, холбоо, нийгэмлэгүүдэд (байгууллага дотрох баг, судалгаа болон сургалтын нийгэмлэгүүд, байгууллагын гаднах бүлэг, мэргэжлийн нийгэмлэг гэх мэт) тогтмол дижитал хэлбэрээр оролцох нөхцөлөөр хангагдсан.
- Тогтмол аудит хийж, сайжруулснаар тэгш оролцоо, тэгш хүртээмжтэй байдлын өндөр стандартыг хангадаг бөгөөд олон төрлийн үйлчилгээний стратегийн хөгжилд янз бүрийн хэрэглэгчийн бүлгүүд оролцдог.
- Дижитал оролцооны талаарх сургалт, хөгжилд ёс зүй, эрх тэгш байдал, дижитал сайн сайхан байдал, соёлын асуудлууд, олон янз байдал, дижитал иргэншил зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг багтаасан байдаг.
- Дижитал оролцооны талаар сэдэв, мэргэжлийн чиглэлээр нь тохирох сургалтын хөтөлбөрүүдэд тусган оруулсан. Оюутнууд оюутны хотхон дотор болон гадна хаана ч баг, хамт олонтойгоо холбоотой байж их сургуулийн олон төрлийн бүлэг, нийгэмлэгт дижитал хэлбэрээр хамрагдан оролцох боломж олгодог.



## 76 Мэдлэг солилцоог дэмжиж, дижитал хамтын ажиллагааг өргөжүүлэх

**Гол чиглэл:**
Орон нутгийн иргэд | Бүс нутгийн өсөлт хөгжил | Дижитал бүлэг үүсгэх | Олон улсын үйл ажиллагаа | Нээлттэй хуваалцах

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Байгууллагаас гадуурх мэдлэг солилцоо, дижитал хамтын ажиллагааг өргөн хүрээний эрхэм зорилго, үнэт зүйлсийн хувьд чухалд тооцдог ч эдгээр зорилгыг практик бүрэн хэрэгжүүлэх цогц арга барил байдаггүй. Стратегийн төлөвлөгөө байхгүй, олон нийтийн оролцоо, мэдлэг солилцох үйл ажиллагааг дэмжихэд зориулсан тусгай нөөц байхгүй.
- Судалгааны түншлэл нь судлаач багш нарын амбицыг тусгасан, өөр өөр судалгааны чиглэлүүд хоорондоо бага зэргийн хамаарал, хамтын ажиллагаатай байдаг. Орон нутгийн үйлдвэрлэл, бизнесүүдтэй нягт холбоотой түншилсэн бөгөөд түншлэлийг дижитал оролцооны боломжуудаар хангасан. Гэхдээ ихэвчлэн нэг удаагийн арга хэмжээ эсвэл тухайн тохиолдлын төсөл байдаг. Мэдлэг солилцоог нэмэгдүүлэх үндэсний хэмжээний түншлэлийг тэнхим, хэлтэсүүд удирдан явуулдаг бөгөөд дижитал сүлжээгээр дамжуулан энэ ажлыг илүү өргөн хүрээнд явуулдаг.
- Байгууллагад нээлттэй хандалтын бодлого бий боловч гадны түншүүдтэй хамтран нээлттэй хандалт болон нээлттэй мэдээллийн санаачилгуудыг хэрэгжүүлэхэд байгууллагын зүгээс хязгаарлагдмал дэмжлэгийг санал болгодог.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллагаас гадуурх мэдлэг солилцоо, дижитал хамтын ажиллагааг бүх стратегид тусган оруулсан. Байгууллага дахь оролцогч талууд мэдлэгээ илүү өргөн хүрээнд хуваалцахын ач холбогдлын талаар нийтлэг ойлголттой бөгөөд үүнийг өөрийн амьдрал, практик нэвтрүүлэхэд хүчин чармайлт гаргадаг.
- Судалгааны үйл ажиллагааны олон чиглэлээр (жишээ нь, хамтарсан судалгааны төсөл, хамтарсан нөөц ашиглалт, хамтарсан судалгаа шинжилгээний нийтлэл) дижитал оролцооны боломжийг хангаж, бусад эрдэм шинжилгээний байгууллагууд, салбарын түншүүд болон засгийн газрын байгууллагуудтай түншилдэг.
- Сайтар тодорхойлсон нээлттэй хандалтын бодлогыг судлаачид болон багш нарт таниулж, мэдээлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргадаг. Нээлттэй хандалтат хэвлэл нийтлэл, судалгааны дундын өгөгдөл ашиглалтыг илүү өргөн хүрээнд нэвтрүүлэх зорилгоор санхүүжилт, дэд бүтцийн дэмжлэг үзүүлдэг.
- Чадавх бэхжүүлэх хөтөлбөр, олон нийтийг хамарсан арга хэмжээ, бодлого боловсруулахад оролцоог дэмжих санаачилгуудаар дамжуулан орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хамтын нийгэмлэгүүдтэй идэвхтэй хамтран ажилладаг. Дижитал оролцооны боломжийг хангах замаар мэдлэг хуваалцаж, хамтын ажиллагааг дэмжиж, янз бүрийн бүлэг, нийгэмлэгүүдэд тулгарч буй хэрэгцээ шаардлага, сорилтуудыг шийдвэрлэдэг.

## Сайжирсан-Төлөвшсөн

- Стратегийн зорилгод мэдлэг солилцоо, дижитал хамтын ажиллагааны стратегийг нэгтгэж, нээлттэй байх болон түншлэх соёлыг төлөвшүүлсэн.

- Орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын оролцогч талуудтай судалгааны чиглэлээр хамтран ажиллаж, түншилсэн арвин түүхтэй. Олон өөр чиглэлийн мэргэжилтнүүд бүхий багуудыг хамруулж, томоохон төслүүд хэрэгжүүлэн, урт удаан хугацаагаар түншилдэг явдал нь инновацыг идэвхжүүлж, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлдэг.

- Нээлттэй хандалтын бодлогыг судалгааны соёлын нэгэн хэсэг болгож, байгууллагын зүгээс нээлттэй хандалтат хэвлэн нийтлэл, судалгаанд өгөгдөл хамтран ашиглахыг ихээхэн дэмждэг. Судлаачид, багш нарыг ажлаа нээлттэй хуваалцахыг уриалж, нээлттэй хандалтын шаардлагуудыг дээд зэргээр дагаж мөрддөг.

- Олон нийтийн оролцоо, мэдлэг солилцоог стратегийн түвшинд авч үзсэнээр олон улсын түншлэл хөгжиж, мэдлэг дамжуулах үйл ажиллагаа идэвхжин, салбарын болон цаашдын тогтвортой хөгжлийн зорилтуудтай байгууллагын зорилтууд илүү сайн уялдаж өгдөг.



# Харилцааны удирдлага

Харилцан хамтардаг түнш болон оролцогч талуудын хамтын ажиллагаа, санал хүсэлт, оролцоог нь хангах зорилгоор тэдэнтэй болоод тэдгээрийн хооронд зерэг харилцааг бий болгох, уг харилцааг хэвээр нь хадгалахад дижитал технологи ашиглах.
Үүнд ажлын болон сургалтын харилцаа, өргөн хүрээндээ олон нийтийн харилцаа багтана.



## 77 Тогвортой, уялдаа холбоо бүхий харилцааны менежментийн стратеги

**Гол чиглэл:**
Түншлэл | Хэрэглэгчтэй харилцах харилцаа | Оролцогч талын оролцоо | Орон нутгийн иргэд | Бизнес болон аж үйлдвэр | Хөдөлмөрийн харилцаа | Хүний нөөц |
Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

●-○-○ **Эхлэл-Тогтворжсон**

- Дижитал дэд бүтэц дээр суурилсан олон төрлийн үйл ажиллагаагаар дамжуулан харилцааны удирдлагыг хөгжүүлдэг.
- Олон төрлийн төхөөрөмж дээр саадгүй ачаалдаг, хэрэглэгчдийн шаардлагыг хангасан, чат болон онлайн маягтаар холбогдох боломж бүхий вэб сайтаар дамжуулан их сургууль, хөтөлбөр, үйлчилгээнийхээ талаар дэлгэрэнгүй мэдээллээр хангадаг.
- Сошиал медиа платформыг идэвхтэй ашиглан мэдээлэл хуваалцах, түгээх, хэрэглэгчидтэй харилцах боломж нэмэгдүүлдэг. Ирээдүйн оюутнуудад мэдээлэл хүргэхийн тулд зорилтот онлайн сурталчилгаа ашигладаг.
- Сургалтын удирдлагын системийн энгийн түвшний платформ, баримт бичиг хуваалцах платформ, видео хурлын хэрэгсэл зэрэг төрөл бүрийн дижитал хэрэгсэл, сүлжээ ашиглан бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог дэмждэг.

- Ирээдүйн болон одоо суралцаж буй оюутнууд, төгсөгчид, түншүүдтэй харилцах харилцааг удирдах, тэдэнтэй холбоо барих мэдээллийг хянах, харилцааг удирдах үндсэн үзүүлэлтүүдийг гаргах, "үнэн"-ий олон хувилбараас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагад төвлөрсөн хэрэглэгчтэй харилцах нэгдсэн нэг систем шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг.

- Оролцогч талуудтай харилцах харилцааг хөгжүүлж, хүрээг тэлэх зорилгоор виртуал арга хэмжээ, вебинар, семинар зэргийг нөхцөл байдлын шаардлагаар зохион байгуулдаг.

## Тогтворжсон-Сайжирсан

- Аюулгүй, найдвартай дижитал технологи, сүлжээ ашиглан харилцааны удирдлагын цогц стратеги хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.
- Ирээдүйн болон одоо байгаа оюутнууд, төгсөгчид, түншүүдтэй харилцах харилцааг удирдах, оролцооны үзүүлэлтүүдийг нарийн хянах, дүн шинжилгээ хийх, арга хэмжээ үйл явдлыг удирдах, тайлагнах чадварыг сайжруулах хэрэглэгчтэй харилцах томоохон системийг хөгжүүлж байгаа.
- Форумаар харилцах, нөөц хуваалцах, ахиц дэвшлийг хянах, бусад дижитал хэрэгслүүдтэй нэгтгэх зэрэг ахисан түвшний функцүүдээр дамжуулан оюутнууд болон багш нарын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хангах сургалтын удирдлагын системийн найдвартай платформтай.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг стратегийн түвшинд хэрэглэснээр оролцоог сайжруулж, сайтар төлөвлөсөн кампанит ажил, хэрэглэгчдийн бүлгүүдийн сегментчилэл, гүйцэтгэлийн дүн шинжилгээ хийж оновчлох замаар хэрэглэгчдийн хүрээгээ тэлдэг.
- Мобайл апп болон дижитал платформууд ашиглан харилцаа холбоог сайжруулж, сургалтын хуваарь, оюутны хотхоны газрын зураг, туслах үйлчилгээ зэрэг нөөцөд хандах боломжийг олгох замаар хувь хүнд чиглэсэн дэмжлэг үйлчилгээг оюутнуудад үзүүлдэг.
- Виртуал арга хэмжээ, вебинар, семинарыг тогтмол зохион байгуулснаар оролцогч талуудтай харилцах харилцаагаа бэхжүүлж, үнэ цэнэтэй мэдээллээр хангаж, хамтран дадлага туршлага хийх бүлгүүдийг байгуулж, танилын хүрээгээ тэлэх боломжийг бүрдүүлдэг.

## Сайжирсан-Төлөвшсөн

- Харилцааны удирдлагын стратегийн гол цөм нь дижитал технологи, сүлжээ бөгөөд шинээр гарч ирж буй чиг хандлагад дасан зохицох боломж олгодог.
- Ахисан түвшний өгөгдлийн аналитик хийж, хиймэл оюун ухаанд тулгуурласан дүгнэлт гарган авснаар шинээр гарч ирж буй хэв маягт нийцүүлэн бодит хугацаанд өөрчлөлт, сайжруулалт хийх боломжтой болж, чиг хандлагаар тодорхойлон, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангаж, харилцааг бэхжүүлэх санаачилгуудад нөлөөлнө.
- Хиймэл оюун ухаан, машин сургалт болон шинээр гарч ирж буй бусад технологиудыг нэгтгэснээр оюутанд үзүүлэх дэмжлэг үйлчилгээг сайжруулж, сургалтыг илүү хувь хүнд чиглүүлэхэд анхаарч, удирдлагын үйл явцыг оновчтой болгодог. Оюутнууд ямар чиглэлээр сурдаг, ямар тэнхимд харьяалагддагаас үл хамааран хоорондоо харилцаж, хамтран ажиллах боломж зэрэг оюутан хоорондын харилцааны асуудлыг сургалтын хөтөлбөр боловсруулахад нэн чухалд авч үздэг.
- Онлайнаар чиглүүлэх цогц хөтөлбөрүүдийн тусламжтайгаар оюутнуудыг төгсөгчид, салбарын мэргэжилтнүүдтэй холбож, заавар зөвлөгөө өгөх, сурч буй чиглэлээрээ бусадтай холбоо тогтоож, танилын хүрээгээ тэлэх, ажил мэргэжлээ төлөвлөх, ур чадвараа хөгжүүлэх боломж олгодог.
- Төгсөгчид онлайн орчинд өндөр идэвхтэй харилцаж, холбоотой байдаг бөгөөд их сургуулийн санаачилгуудад байнга дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж, янз бүрийн үйл ажиллагаанд оролцдог.
- Онлайн санал асуулга, нийгмийн сүлжээ болон бусад дижитал сувгуудаар дамжуулан оролцогч талуудын санал хүсэлтийг системтэйгээр цуглуулж, дүн шинжилгээ хийж, тасралтгүй сайжруулалт хийж, харилцаа холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.



# Дижитал болон бодит дэд бүтэц

Сүлжээ, систем, техник хангамж, программ хангамж, дижитал технологиор тоноглогдсон бодит орон зайд зохих хөрөнгө оруулалт хийх зэргээр холбогдох мэдлэг, туршлага, алсын хараан дээр суурилсан найдвартай, аюулгүй дэд бүтэц цогцлоож, үр дүнтэй удирдлагаар хангах, стандарт хэрэгжилтийг дагаж мөрдүүлэх.



# Найдвартай дижитал дэд бүтэц

Байгууллагын үр ашигтай үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих зорилгоор технологи, тоног төхөөрөмжийн цогц, аюулгүй, найдвартай системийг төлөвлөж, хөрөнгө оруулалт хийж, хэвийн ажиллагааг хангах.



## 78 Технологи, дэд бүтцийн чиг хандлага, хөгжил

**Гол чиглэл:**
Чиг хандлага тодорхойлох | Салбарын мэдээлэл, тоо баримт | Орон нутгийн / бүс нутгийн / үндэсний статистик мэдээ | Олон улсын үйл ажиллагаа

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Чиг хандлага тодорхойлох өргөн хүрээг хамарсан үйл ажиллагааны нэг хэсэг болох технологийн чиг хандлагыг сайтар хянан, ажигладаг. Зарим нэг хүн сайн дураараа тодорхой зарим технологийг сонгон эзэмшсэн байдаг. Нөхцөл байдлын шаардлагаар технологийг зөвшөөрөлгүй эсвэл стратегийн чиг баримжаагүйгээр түр ашигладаг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Технологийн чиг хандлагыг уялдаа холбоотой, зохион байгуулалттай аргачлалаар мөн дээд боловсролын салбар дахь хэрэглээнд нийцүүлэн тодорхойлдог.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Шинжээчдээс бүрдсэн багууд гарган бизнесийн үндсэн чиглэл тус бүрээр технологийн хөгжлийн чиг хандлагыг судалдаг ба тэдгээр багуудын нэгдсэн мэдээлэл, дүгнэлт дээр үндэслэн дээд шатны удирдлага шийдвэр гаргадаг. Ирээдүйн хэрэгцээ шаардлагад чиг хандлагын дүн шинжилгээ хийхэд орон нутгийн болон бүс нутгийн түншүүдийн санал хүсэлтийг мөн оруулдаг ба олон улсын хэтийн төлөвийг ч бас харгалзан авч үздэг.

# 79 Дижитал дэд бүтцийн мэдээлэлд суурилсан стратеги төлөвлөлт

**Гол чиглэл:**

Дижитал стратеги | МТ стратеги | Байгууллагын стратеги | Засаглал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Технологийн стратеги төлөвлөлтөөр ирээдүйг идэвхтэйгээр тодорхойлохын оронд өөрчлөлт гарсан үед нь дасан зохицоход анхаардаг.
- Одоо байгаа дижитал дэд бүтцийн чадавхыг тогтмол үнэлж, найдвартай байдал, өргөтгөх боломжтой байдал, шилдэг туршлагатай холбоотой аливаа дутагдал, хязгаарлалт байгаа эсэхийг тодорхойлдог.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Технологийн холбогдолтой стратеги төлөвлөлтөд ирээдүйн сорилт, боломжуудыг урьдчилан харж, бэлтгэхэд чиглэгдсэн чиг хандлагын дүн шинжилгээ, урьдчилан харж таамаглах үйл ажиллагаар багтаан оруулсан байдаг.
- Найдвартай, өргөтгөх боломж бүхий дижитал дэд бүтэц нь аюулгүй бөгөөд нэн тэргүүний, чухал ажилд зориулагдсан шилдэг туршлага, үүлэн платформыг хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлж, ашигласан байдаг.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Технологийн стратеги төлөвлөлт нь чиг хандлагад хариу үйлдэл үзүүлэх төдий биш бөгөөд технологийн холбогдолтой бүх хөрөнгө оруулалт нь стратегийн өргөн хүрээний тэргүүлэх чиглэлүүдээр хүлээгдэж буй ашиг, боломж, эрсдэлийг тооцон авч үзсэн байдаг.
- Тус байгууллага нь дээд боловсролын салбарт инновац, хамтын ажиллагаа, манлайлалаар дамжуулан ирээдүйг идэвхтэй тодорхойлоход хувь нэмрээ оруулдаг.

# 80 Уялдаа холбоотой, уян хатан дижитал стратеги

**Гол чиглэл:**

Дижитал стратеги | МТ стратеги | Байгууллагын стратеги | Засаглал | Оролцогч талын оролцоо | Дижитал манлайлал

Төлөвшлийн түвшинг сонгох:

**●-○-○ Эхлэл-Тогтворжсон**

- Мэдээллийн технологийн цогц стратеги нь одоо байгаа функцууд болон дэд бүтцийг дэмжихэд чиглэгддэг. Мэдээллийн технологийн дэд бүтцийн өнөөгийн байдлыг хадгалах, мөн түүнчлэн аюулгүй байдал, өргөтгөх боломжтой байдал зэрэг мэдээллийн технологид хамааралтай тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулдаг. Байгууллагын дижитал санаачилгууд ихэвчлэн тус тусдаа явагддаг бөгөөд байгууллагын өргөн хүрээний зорилтуудтай уялдаа холбоо бага байдаг.

**○-●-○ Тогтворжсон-Сайжирсан**

- Байгууллагыг хамарсан дижитал стратегийн хүрээнд үндсэн мэдээллийн технологийн чиг үүрэг, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээс давж илүү нарийн өгөгдөл, аналитик зэрэг түвшин руу өргөжин тэлэх хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн. Стратегийг удирдан чиглүүлэх зөвлөлийн буюу засаглалын бүтцэд бүх оролцогч талуудын төлөөллийг багтаасан бөгөөд сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлохын тулд дижитал бэлэн байдлын үнэлгээг хийсэн.
- Дунд болон урт хугацааны дижитал хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хүрээнд шинэ технологийн шийдэл, ажилд авах, сургах, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргах, бизнесийн үйл явцыг сайжруулах зэрэг өргөн хүрээний дижитал шилжилтийн том зорилтуудыг дэмждэг. Оролцогч талуудыг хамруулж, татан оролцуулах замаар дижитал шилжилтийн боломжит ашиг тусыг ойлгуулж байгаа.

**○-○-● Сайжирсан-Төлөвшсөн**

- Дижитал шилжилтийн стратегийг байгууллагын бусад бүх стратегитай нэгтгэх (эсвэл одоо байгаа бүх стратегид оруулан тусгах) замаар байгууллагын өргөн хүрээний зорилгуудад нийцүүлсэн. Стратегийн хэрэгжилт болон байнгын үнэлгээнд хяналт тавих зохицуулалт бүхий засаглалын бүтэц бий.
- Дижитал шилжилтийг дэмжих зорилгоор технологи, дэд бүтэц, хүмүүст ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд инновац, хамтын ажиллагааны соёл хүчтэй дэлгэрч байгаа. Ажилтнууд, оюутнуудын туршлага, судалгааны үр дүн, захиргааны ажлын үр бүтээмж, бизнесийн үйл ажиллагаа, оролцоо талын оролцоо мэдэгдэхүйц сайжирч дижитал шилжилтийн ашиг тус байгууллага даяар илт харагдаж байгаа. Байгууллага нь шинээр гарч ирж буй чиг хандлагаас алхам урьтаж, тасралтгүй амжилт гаргахын төлөө дижитал шилжилтийн стратегиа тасралтгүй үнэлж, сайжруулж байгаа.

# 81 Дижитал шилжилт, өгөгдөл, технологийг ахисан түвшинд хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулалт

**Гол чиглэл:** Хөрөнгө оруулалт |
Программын архитектур
Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Техникийн болон дижитал дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд мэдээллийн технологийн стратегийг тусгасан. Хөрөнгө оруулалтын шийдвэрүүд нь ихэвчлэн өнөөгийн асуудал, өмнөө тулгарсан асуудал сорилтод хариу өгөх хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй байдаг. Хуучны буюу хоцрогдсон системүүд, "дотоод нөөц бололцоо"-гоо ашиглан хийсэн шийдлүүдэд өмнө нь хийсэн хөрөнгө оруулалт илүү шинэлэг, урт хугацааны төлөвлөлт хийхэд саад болдог. Хөрөнгө оруулалтын шийдвэр нь идэвхгүй буюу хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдаг бөгөөд дээд шатны удирдлага нь урт хугацааны зорилго, тогтвортой байдлыг дэмжиж хөрөнгө оруулалт хийх талаар тодорхой ойлголтгүй байх магадлалтай.
- Дижитал дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийж, төлөвлөхдөө дижитал технологи бүхий кампус бий болгож, бат бөх суурь тавихад анхаардаг. Хөрөнгө оруулалтын хүрээнд одоо байгаа техник хангамж, программ хангамж, сүлжээний системийг шинэчлэх, кибер аюулгүй байдлын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээг нэн тэргүүнд тавьдаг. Техникийн асуудлыг шийдвэрлэх, ажилтнууд болон оюутнуудыг дэмжих, сургах зорилгоор дэмжлэг үйлчилгээний төвлөрсөн багуудад хөрөнгө оруулалт хийдэг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Техникийн болон дижитал дэд бүтцийн урт хугацааны хөрөнгө оруулалтын стратеги бий. Эрсдэлийг тодорхойлох, бууруулахын тулд идэвхтэй арга барилыг хэрэгжүүлсэн бөгөөд өгөгдөл, аналитик дүгнэлт дээр үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг. Урт хугацааны тогтвортой байдлыг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах бүх үйл явцад тусгасан байдаг.

- Дижитал дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийж, төлөвлөж буй нь сургалт, судалгааг сайжруулах хүсэл эрмэлзлийн илэрхийлэл болно. Судалгааны боловсрол, инновацыг зохих ёсоор дэмжихийн тулд дэвшилтэт технологид тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг (жишээ нь: хиймэл оюун ухаан, машин сургалт, мэдээллийн аналитик). Тогтмол аудит хийж, кибер аюулгүй байдлын ахисан түвшний арга хэмжээ авснаар өгөгдлийг хамгаалах, дүрэм журмыг дагаж мөрдөх явдлыг хангадаг.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд урт хугацааны зорилго, томоохон зорилтуудыг дэмждэг. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайн хийдэг нь байгууллагын хүчирхэг давуу тал болдог бөгөөд инновац, тогтвортой байдлын соёл бүрэн тогтсон. Мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргадаг тул (зөвхөн хөрөнгө оруулалт хийхийн төлөө инновац хийдэг биш) хийсэн хөрөнгө оруулалт зөв, зохистой байдаг. Байгууллага нь олон жилийн хугацаатай эсвэл багц үйлчилгээ, хөнгөлөлт эдлэх боломж зэрэг урт хугацааны тогтвортой байдлыг дэмжих хөрөнгө оруулалтын шинэ боломж, аргуудыг идэвхтэй эрэлхийлж байгаа.
- Дижитал дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийж, төлөвлөснөөр их сургуулийн үйл ажиллагааны бүхий л чиглэлд дижитал шилжилтийг идэвхжүүлж байна. Технологид зохих хөрөнгө оруулалт хийснээр судалгаа, боловсролын чиглэлээр шинэлэг хандлагыг хэрэгжүүлж, инновацын төв байгуулснаар энтрепренерийн соёл, өөр өөр мэргэжлийн чиглэл хоорондын хамтын ажиллагаар дэмжих болсон. Өгөгдлийн аналитик болон хиймэл оюун ухаан нь  шийдвэр гаргахад тусалж, бизнесийн үйл ажиллагаар оновчтой болгож, оюутны амжилтад эерэгээр нөлөөлж байна. Оролцогч талуудын дижитал чадавхид хөрөнгө оруулалт хийснээр ажилтан сонгон шалгаруулах, хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах, дижитал манлайлал үзүүлэх, судалгаа хийх, энтрепренерийн үйл ажиллагаа явуулах,
- сургалтын үр дүнг сайжруулахад эерэг нөлөөлөл үзүүлэх болсон.
Дотоод нөөц бололцоогоороо үзүүлэх үйлчилгээг хаана ашиглавал илүү хэрэгцээтэй болох нь ойлгомжтой, тодорхой бөгөөд мэдээлэлд суурилсан 'үүлэн технологи нэгдүгээрт' гэсэн зарчмыг үндсэн үйлчилгээнд нэвтрүүлснээр хөрөнгө оруулалтыг зохих ёсоор хийх боломжтой болсон. Ингэснээр тодорхой газарзүйн бүс нутгийг хамарсан олон тооны үүлэн тооцооллын төв руу бүрэн эсвэл хагас шилжилт хийсэн. Энэ аргыг хэрэгжүүлсний үр дүнд нэг цэгийн доголдлыг багасгаж, бизнесийн тасралтгүй байдлыг баталгаажуулахын зэрэгцээ гамшгийн дараах сэргээх процесстой холбоотой асуудал бэрхшээлүүдийг хөнгөвчилдөг.

## 82 Байгууллагын архитектурын тогтолцоо ба стратеги

**Гол чиглэл:**

Бизнесийн үйл явц, үйл ажиллагаа | Байгууллагын архитектур

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Байгууллага нь мэдээллийн технологийн систем, үйл явцыг тухайн нөхцөл байдлаас хамааралтайгаар удирдсаны улмаас үр бүтээмжгүй, тогтворгүй байдал үүсдэг. Мэдээллийн технологийн төлөвлөлт, удирдлагатай холбоотой удирдах, шийдвэр гаргах үйл явцууд нь өөр хоорондоо уялдаа холбоогүй, хэлтэс хооронд маш бага хэмжээнд хамтран ажилладаг. Архитектурын хувьд бүрэлдэхүүн хэсгүүдийн ерөнхий баримт бичиг байхгүй.

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллагын архитектурын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, холбогдох тогтолцоог боловсруулах, удирдахад хяналт тавих зорилгоор байгууллагын архитектурын Enterprise Architecture (EA) багийг үүсгэсэн. Холбогдох стандарт, үйл явцын баримт бичгүүдийг боловсруулсан бөгөөд хэлтэс хоорондын хамтын ажиллагаа, харилцаа холбооны үр дүнд засаглалын буюу удирдах бүтэц сайжирсан.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Байгууллагын архитектурыг байгууллагын стратеги төлөвлөлтийн үйл явцад бүрэн нэвтрүүлсэн. Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд EA баг бусад хэлтэстэй идэвхтэй хамтран ажилладаг. Гүйцэтгэлийн хэмжүүр, тогтмол үнэлгээ, сайжруулалтын үйл явцаар дамжуулан тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг удирддаг. Байгууллагын архитектуртай болсны үр дүнд мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт болон стратегийн зорилтууд хоорондоо сайтар уялдаж өгдөг.



## 83 Найдвартай, аюулгүй дижитал дэд бүтцээр хангах

**Гол чиглэл:**

Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал | Байгууллагын архитектур | Кибер аюулгүй байдал | Өгөгдөл үүсгэх, удирдах | Өгөгдлийн архитектур | Өгөгдлийн нууцлал

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Дижитал дэд бүтцийн төлөвлөлт, шийдвэр дээр суурилан үр дүнд аюулгүй, найдвартай байдлыг энгийн түвшинд хангадаг.
- Бизнесийн тасралтгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийг тодорхойлж, ойлгох зорилгоор дижитал дэд бүтцийн төвөлийг үнэлүүлсэн. Гамшиг тохиолдоход илүү найдвартай ажиллуулах үүднээс дижитал дэд бүтцийн гол ачаалалтай хэсгүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч, шаардлагатай заримд үүлэн платформыг ашиглах нь чухал гэж үзсэн байгаа.
- Сүлжээний дэд бүтэц найдвартай тул өндөр хурдны холболтоор хангах, тодорхой хэмжээний тасралтгүй ажиллагааг хангах нөөц арга хэмжээ авах, өргөтгөл хийх зэрэг боломжтой. Аюулгүй, орчин нөхцөлийн хяналт бүхий дата төвүүдийг ажиллуулж байгаа.
- Кибер аюулгүй байдлын цогц арга хэмжээг төлөвлөсөн, хэрэгжүүлэхэд бэлэн байгаа бөгөөд ажилтнууд, оюутнууд кибер аюул заналхийллийн талаар мэдлэгтэй. Ажил үүргээс хамааралтай хандах буюу нэвтрэх эрхийн хяналтын системийг тогтмол хянаж, шинэчилдэг.
- Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөгөөнд өгөгдлийг найдвартай нөөцлөх процессууд тусгагдсан.
- Бодит хугацаанд хянах, ослын хариу арга хэмжээ авах тодорхой төлөвлөгөө, журмуудтай.

### Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал дэд бүтцийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шийдвэрийн үр дүнд аюулгүй, найдвартай байдлыг оновчтой түвшинд хангадаг.
- Гол ажлын ачааллыг авдаг систем, процессууд үүлэн платформ, функцүүдийн тусламжтайгаар гамшгийг тэсвэрлэх чадвартай. Үүлэн платформ руу өргөтгөснөөр байгууллагын бодит байршил дээрх дэд бүтцээс систем, процессуудыг салган, найдвартай байдлыг сайжруулсан.
- Сүлжээний дэд бүтэц найдвартай тул өндөр хурдны холболтоор хангах, тасралтгүй ажиллагааг хангах зорилготой олон давхар нөөц арга хэмжээ авах, өргөтгөлийг өндөр түвшинд хийх (жишээлбэл, үүлэн үйлчилгээ, 5G сүлжээ) зэрэг боломжтой. Дата төвүүд болон серверийн өрөөнүүдийн аюулгүй байдал болон нөөц арга хэмжээ авах боломж нь ахисан түвшинд хангагдсан.
- Кибер аюулгүй байдлын дээд зэргийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, ажилтнууд болон оюутнуудад кибер аюул заналхийллийн талаар тасралтгүй сургалт явуулдаг. Хандалтыг хянах дэвшилтэт системүүдийг байнга хянаж, шинэчилж байдаг.
- Бизнесийн болон тасралтгүй байдлын төлөвлөгөөнд өгөгдлийг нөөцлөх цогц процессууд, программ хангамжийн засвар үйлчилгээ, техник хангамжийн шинэчлэлтүүдийг тогтмол хийх зэргийг тусган оруулсан.
- Ахисан түвшинд бодит хугацааны хяналт хийх, ослын хариу арга хэмжээ авах тодорхой төлөвлөгөө, шуурхай хариу арга хэмжээний журмуудтай.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Аюулгүй, найдвартай байдлын дээд зэргийн стандартыг тогтоож, байгууллагын хэмжээнд инновацыг идэвхжүүлэх гол хөдөлгөгч хүч нь дижитал дэд бүтэц болно.
- Шаардлагатай чиглэлээр үүлэн платформ ашиглах боломжтой бүрэн цогц дижитал дэд бүтэцтэй. Дэд бүтэц нь ачаалал даах чадвартай, найдвартай, өргөтгөх боломжтой, аюулгүй. Мөн түүнчлэн хангалттай түвшинд автоматжуулсан, шилдэг туршлагыг нэвтрүүлсэн.
- Хэт өндөр хурдны холболт, нөөц сүлжээний дэвшилтэт шийдэл, өргөтгөх боломж бүхий бэлэн байдлын өндөр түвшнийг хангасан сүлжээний дэд бүтцийн (жишээ нь захын тооцоолол, ачааллыг уянаар тэнцвэржүүлэх) хангамжтай. Өгөгдлийн төвүүд нь аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах, эрчим хүчийг хэмнэх, нөөц арга хэмжээ авах боломжтой.
- Байгууллагын дотоодын мэргэжлийн үйлчилгээний багийн зүгээс байнга өөрчлөгдөж байдаг кибер аюул заналхийллийн сорилтуудыг даван туулахын тулд Жанет Сүлжээний мэдээлэлд тулгуурлан тухайн салбарт хамаарах үйлчилгээ үзүүлдэг.
- Кибер аюулгүй байдлын орчин үеийн технологиудыг хэрэглэдэг ба ажилтнууд болон оюутнуудын боловсролд ихээхэн анхаарч, кибер аюулаас урьдчилан сэргийлэх, бууруулахад шинэлэг санаачилга гаргадаг.
- Байгууллага нь байнгын сайжруулалт, аюулгүй байдлыг хангах үүднээс хиймэл оюун ухаан, машин сургалт зэрэг дэвшилтэт технологид суурилсан хандалтыг хянах нарийн систем ашигладаг. Олон шатлалт нөөцлөлийн болон гамшгийн нөхөн сэргээлтийн цогц стратеги хэрэгжүүлснээр аливаа саатал, гэмтлээс систем, өгөгдлийг шуурхай, саадгүй сэргээх боломжтой болсон.
- Болзошгүй асуудлуудыг идэвхтэй тодорхойлж, шийдвэрлэхдээ дэвшилтэт аналитик болон машин сургалтыг ашиглаж, бодит хугацаанд хянаж, ослын хариу арга хэмжээ авахдаа орчин үеийн систем, технологид тулгуурладаг.



# 84 Шударга, хүртээмжтэй дижитал дэд бүтэц

**Гол чиглэл:**
Оролцогч талын хэрэгцээ | Шаардлага тодорхойлох | Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал ядуурал | Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Оролцох, суралцах, ажиллах үйл явцад дижитал процесс, систем, үйлчилгээ саад тотгор учруулахгүй байхад байгууллагын зүгээс анхаарч ажиллаж байгаа.
- Дижитал технологитой холбоотой асуудлаар хандсан тохиолдолд асуудал хариуцсан ажилтан үйлчилгээ үзүүлдэг.
- Байгууллага нь ажилтнууд болон оюутнуудын дижитал хандалт, ашиглалтын талаарх мэдээллийг цуглуулдаг боловч илрүүлсэн дутагдлыг арилгах стратегийн аргачлал байхгүй.
- Дижитал процесс, систем, үйлчилгээг ЕХ-ны вэбсайтыг хүртээмжтэй байлгах зохицуулалтуудтай нийцүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байгаа. Тус байгууллага нь туслах технологийн дэмжлэг авах хүсэлтэд 2010 оны Тэгш байдлын тухай хуулийн дагуу хариу өгдөг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал ялгаатай байдлыг (хувь хүний хэрэгцээ шаардлага эсвэл чадавх, нөөц, сүлжээ, тоног төхөөрөмжийн хүртээмж гэх мэт) шийдвэрлэх стратегийг үнэлэх, сайжруулах зорилгоор оролцогч талуудтай тасралтгүй яриа хэлэлцээ хийж байгаа.
- Тус байгууллага нь дижитал буюу өгөгдлийн ядуурлад өртсөн суралцагчдыг төхөөрөмж, холболтоор хангах, дижитал ур чадварын сургалт явуулах, цөөнх төлөөлөлтэй нийгмийн бүлэгт харьяалагддаг суралцагчдад зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх зэрэг олон төрлийн зорилтот дэмжлэг үйлчилгээг оюутнуудад үзүүлдэг.
- Шинэ ажилтан, оюутанд зориулсан сургалтаар суралцагчид болон/эсвэл ажилчдыг суралцах/ ажиллахад тохиолдох саад тотгорыг бууруулах механизм болох дижитал төхөөрөмж, процесс, систем, үйлчилгээг тодорхойлж, өөрийгөө үнэлэхийг санал болгодог.

### ○-○-● Сайжирсан-Төлөвшсөн

- Тус байгууллага нь бүтцийн саад тотгорыг арилгах, бүх оюутан, ажилтнуудад аюулгүй, ил тод дижитал орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа.
- Эрх тэгш байдал, оролцоог хангах бодлогын хүрээнд бүх оролцогч талуудыг дижитал орчны дизайнд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлдэг. Байгууллагын зүгээс ажилтнуудыг ажил үүргээ биелүүлэхдээ хамгийн сүүлийн үеийн төхөөрөмж, программ хангамж ашиглаж, дасан зохицох боломжийг олгодог.
- Оюутнуудыг сургалтын туршлагаа сайжруулах, хуучирсан, найдвартай бус техник хангамж, системийг ашиглахгүй байхад нь анхаарч, дижитал технологийн зорилтот дэмжлэг үзүүлдэг.
- Хичээлийн хөтөлбөрийн багууд өөрсдийн мэдлэгт тулгуурлан сургалтын хөтөлбөрт хүртээмжтэй дижитал технологийг тусган, суулгаж өгдөг.



## 85 Дижитал дэд бүтцийн тогтвортой байдал ба байгаль орчинд үзүүлэх нөлөө

**Гол чиглэл:** Байгаль орчны тогтвортой байдал

Төлөвшлийн түвшинг сонгох:

### ●-○-○ Эхлэл-Тогтворжсон

- Дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгууллага хүлээн зөвшөөрч, эдгээр асуудлыг шийдвэрлэх зарим нэг санаачилгыг гаргаж байгаа.
- Эрчим хүчний хэрэглээ болон нүүрсхүчлийн хийн ул мөрийг багасгахын тулд өгөгдлийг хариуцлагатайгаар удирдаж, хадгалахад зориулсан удирдамж боловсруулсан.
- Тус байгууллага нь аялал жуулчлалтай холбоотойгоор мөн нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилгоор виртуал уулзалт, теле хурал ашиглахыг дэмждэг.
- Эрчим хүч хэмнэх арга хэмжээг (автомат унтах горим эсвэл төхөөрөмж болон компьютер дээрх тэжээлийн удирдлагын программ хангамж гэх мэт) байгууллага даяар хэрэгжүүлсэн.
- Технологийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар сургалт, семинараар дамжуулан ажилтнууд болон оюутнуудыг сургаж, төхөөрөмж ашиглахдаа эрчим хүчний хэмнэлтийг анхаарч үзэхийг зөвлөдөг. Электрон хог хаягдлыг цуглуулах цэг, дахин боловсруулах арга хэмжээг зохион байгуулдаг.

### ○-●-○ Тогтворжсон-Сайжирсан

- Дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг арилгах цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа.
- Кампусын хэмжээнд дижитал төхөөрөмжүүдэд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй туршлагыг нэвтрүүлсэн. Үүнд, эрчим хүчний хэмнэлттэй техник хангамж ашиглах, өгөгдлийн төвийг оновчтой болгох, эрчим хүчний удирдлагын дэвшилтэт тохиргоог нэвтрүүлэх зэрэг орно.
- Электрон хог хаягдлын удирдлагын системд электрон төхөөрөмжийг тогтмол цуглуулах, хариуцлагатайгаар дахин боловсруулах, мөн түүнчлэн засварлах, дахин ашиглахыг сурталчлах зэрэг орно.
- Дижитал технологийн тогтвортой худалдан авалтын бодлогын хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж болон тогтвортой хөгжлийг дэмждэг ханган нийлүүлэгчдийг нэн тэргүүнд тавьдаг.
- Дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг холбогдох хичээл, сургалтын хөтөлбөрт тусгаж, ажилтнууд болон оюутнуудыг хариуцлагатай дижитал дадал хэвшилд суралцахыг уриалдаг.
- Тус байгууллага нь гадны байгууллага, салбарын мэргэжилтнүүдтэй хамтран дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар олон чиглэлийг хамруулсан судалгаа хийж байгаа.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Тус байгууллага нь дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх, шилдэг туршлагыг үлгэрлэн харуулах, чухал нөлөө үзүүлэх чиглэлээр тэргүүлэгч юм.
- Дижитал технологийн эрчим хүчний хэрэглээг цэвэр тэглэлт руу чиглүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, шинэлэг шийдлээр дамжуулан үр ашигтай дэвшилтэт арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа.
- Засварлах, дахин ашиглах, хариуцлагатай дахин боловсруулах зэрэг эдийн засгийн тойрог зарчмуудыг хэрэгжүүлэхэд анхаарч, хог хаягдалгүй байлгах электрон хог хаягдлын удирдлагын системийг ажиллуулдаг.
- Худалдан авалтын бодлогын хүрээнд байгууллагын зүгээс ханган нийлүүлэгчдийг байгаль орчны холбогдолтой гүйцэтгэлээ сайжруулах, тогтвортой дижитал технологи хөгжүүлэхэд шинэлэг хандлага нэвтрүүлэхийг уриалдаг.
- Тус байгууллагыг дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн боловсрол, сургалтын чиглэлээр тэргүүлэгч гэж үздэг. Тус байгууллага шилдэг туршлага, мэдлэгээ хуваалцах зорилгоор гадны оролцогч талуудтай идэвхтэй хамтран ажиллаж байгаа.
- Тус байгууллага нь дижитал технологийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн судалгаа тэргүүлж, дэлхийн болон орон нутгийн тогтвортой байдлын зорилгод хувь нэмэр оруулах инновацыг идэвхжүүлж, байгаль орчны холбогдолтой бодлого, салбарын практикт нөлөөлөл үзүүлдэг.



# 86 Нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийн удирдлага

**Гол чиглэл:**

Аюулгүй байдал, бизнесийн тасралтгүй байдал |

Кибер аюулгүй байдал

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийн удирдлага ерөнхийдөө идэвхгүй буюу асуудал гарсан үед хариу үйлдэл үзүүлдэг, зохих ажилтнууд/хэлтсүүдээс хандах боломжтой ханган нийлүүлэгчийн болон гэрээний иж бүрэн жагсаалтыг боловсруулан гаргахад тодорхой зарим хүчин чармайлт гаргаж байгаа. Нийлүүлэлтийн сүлжээний системүүдийг зохих ёсоор бүгдийг нэгтгээгүй учир өгөгдлийг үр ашиггүй ашиглахад хүрдэг ба нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг хянах, нийлүүлэлтийн сүлжээний асуудлын улмаас эрсдэлд орсон өгөгдөл, үйлчилгээ, дэд бүтэц, аюулгүй байдлын цоорхой зэргийн нөлөөллийг үнэлэхэд хүндрэл учирдаг.
- Нийлүүлэгчидтэй хийсэн гэрээнд хэрвээ ямар нэг цоорхой илрэх, осол гарах, асуудал үүссэн тохиолдолд нэн даруй мэдэгдэх шаардлагыг тусгасан.
- Гуравдагч талын нийлүүлэгчидтэй ажил гүйцэтгэлийн гэрээ байгуулдаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Тус байгууллага нь нийлүүлэлтийн сүлжээний эрсдлийг урт хугацаанд үр дүнтэй удирдах зорилгоор дижитал системүүдийг нэгтгэж, өгөгдлийг зохицуулан удирдахад хүчин чармайлт гаргаж байгаа. Нийлүүлэлтийн сүлжээн дэхь гуравдагч талуудаас хамааралтай байдлыг идэвхтэй удирдах стратегийн аргачлал боловсруулж байгаа – өгөгдөл хамгаалал болон аюулгүй байдлын түвшинг эрэмбэлэх, худалдан авалттай холбоотой эрсдлийг хянах (жишээ нь: худалдан авалтын процесс, протокол, ханган нийлүүлэгчдийн үнэлгээг сайжруулах). Худалдан авах ажиллагааны гэрээнд ханган нийлүүлэгчдээс аливаа эрсдэл, гэрээнд тусгагдаагүй байсан асуудал, осол аваар, бусад асуудлыг цаг алдалгүй илрүүлж мэдээлэх шаардлагыг тусгасан.
- Нийлүүлэлтийн хэлхээний удирдлагын асуудлуудыг (жишээ нь, аюулгүй байдал, санхүү, гэрээний удирдлага) үр дүнтэй дамжуулан мэдээлэх, удирдахын тулд эдгээртэй холбоотой засаглал, тайлагналын механизмыг боловсронгуй болгож байгаа.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Нийлүүлэлтийн сүлжээний эрсдлийг үр дүнтэй системүүдээр дамжуулан байгууллага даяар нэгтгэн удирддаг. Нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, эвдрэл, осол аваар, мэдээллийн хулгай зэрэгт үзүүлэх нөлөөллийг шуурхай үнэлж, байгууллагын систем, үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох боломжтой.
- Нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг байгууллагын хэмжээнд зохих стратеги, үйл ажиллагаанд нэгтгэн удирддаг бөгөөд нийлүүлэлтийн сүлжээний эрсдлийн удирдлагыг өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үндсэн чиглэл болгон ашигладаг. Үнэлгээ, сонгон шалгаруулалтын явцад ханган нийлүүлэгчидтэй идэвхтэй хамтран ажилласнаар болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бууруулж, гэрээнд тусган оруулах боломжтой болдог.
- Үйл ажиллагааны бүх чиглэлээр бизнесийн тасралтгүй байдлыг хангахын тулд нийлүүлэлтийн сүлжээг байгууллагын холбогдох бүх ажилтан, хороодоор дамжуулан удирдан зохицуулдаг.

# Дижитал холболт

Байгууллага доторх оролцогч талууд, бизнесийн үйл явц, өгөгдөл, сүлжээнүүдийн хооронд аюулгүй, найдвартай холболтоор хангах, түүнчлэн зохих гадаад сүлжээнүүдтэй холбогдох боломжийг бүрдүүлэх.



## 87 Найдвартай сүлжээ, холболтоор хангах

**Гол чиглэл:**

Дижитал сүлжээ | Бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Сүлжээний найдвартай байдлыг нэн тэргүүнд тавьж, сүлжээ унахыг багасгах зорилгоор нөөц сүлжээ буюу системийг төлөвлөж, өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах үүднээс зарим үүлэн үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Халдлагыг илрүүлж, урьдчилан сэргийлэх систем нэвтрүүлж, аюулгүй байдлын тогтмол аудит хийх, кибер аюулгүй байдлын талаар ажилтнуудад тогтмол сургалт явуулах зэрэг сүлжээний аюулгүй байдлын дэвшилтэт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа.
- Байгууллага нь гадаад сүлжээтэй аюулгүй холбогдох арга хэмжээ авдаг. Аюулгүй байдал, найдвартай байдлын асуудлаар идэвх, санаачлагатай ажиллах арга барил хэрэгжүүлсний үр дүнд дижитал орчныг сайжруулах хяналтын хэрэгсэл, ослын хариу арга хэмжээний төлөвлөлт, үүлэнд суурилсан шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийсэн.

### Тогтворжсон-Сайжирсан

- Байгууллага нь төрөл бүрийн хэрэглээний программ болон дэд бүтцийг хэвийн ажиллуулах, өгөгдөл хадгалах зэрэг хэрэгцээ шаардлагуудыг хангах үүднээс найдвартай дижитал холболт, сүлжээ үүсгэн, үүлэн үйлчилгээг өргөнөөр ашиглах цогц, төлөвшсөн арга барилыг хэрэгжүүлсэн.
- Үүлэн үйлчилгээний аюулгүй байдлын арга хэмжээ болгон аюулыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах хиймэл оюун ухаан, машин сургалт зэрэг дэвшилтэт технологиудыг ашигладаг. Сүлжээ, үүлэн үйлчилгээнүүдийн доголдлыг олж илрүүлэн, арилгахын тулд тасралтгүй хянаж, үнэлдэг.
- Сүлжээний болон үүлэн үйлчилгээний найдвартай байдлыг оновчтой болгож, бэлэн байдлын болон гүйцэтгэлийн өндөр түвшинг хангах тэсвэрлэн сэргэх чадвар маш өндөр дэд бүтцийг байгуулсан. Бүх түвшинд кибер аюулгүй байдлын ач холбогдлыг онцолж, аюулгүй байдлын соёл бүрэн тогтсон.

### Сайжирсан-Төлөвшсөн

- Тус байгууллага нь зохих технологи, шилдэг туршлага, дэвшилтэт үүлэн үйлчилгээг хослуулан ашиглаж, бэлэн байдлын болон гүйцэтгэлийн түвшин өндөртэй, найдвартай дижитал орчныг бүрдүүлсэн.
- Салбарын түншүүд, судлаачид болон бусад оролцогч талуудтай хамтран ажилласнаар кибер аюулгүй байдал, сүлжээний удирдлага, үүлэн үйлчилгээний шинэ шийдлүүдийг эрэлхийлж, хэрэгжүүлэхэд тус дэм болдог.
- Үүлэн үйлчилгээг үр дүнтэй ашигласны үр дүнд одоогийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тасралтгүй сайжруулалт, инновац, шинэ технологиудыг нэгтгэхэд анхаарч, дижитал орчныг илүү үр дүнтэй өргөжүүлж, уян хатан болгох боломжтой болсон.

# 88 Төрөл бүрийн оролцогч талуудын холболтын хэрэгцээ, шаардлагыг хангах

**Гол чиглэл:**

Тэгш хүртээмж, тэгш оролцоо | Дижитал ядуурал | Дижитал бүлэг үүсгэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

### Эхлэл-Тогтворжсон

- Санал асуулга, фокус групп, сургалтын аналитик хэрэглүүрээс авсан өгөгдөлд дүн шинжилгээ хийх зэргээр суралцагчдын янз бүрийн бүлгүүдийн холболтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, үнэлэх хүчин чармайлт гаргасан. Оюутны илэрхийлсэн хэрэгцээ, шаардлагад зарим контент, технологи, үйлчилгээг нийцүүлсэн.
- Сургуулийн хотхоны гадуур байгаа оюутнуудад зарим нэг онлайн болон холимог сургалтын санал болгож байгаа бөгөөд дүрэм, журмын шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулж агуулга болон нөөцийг хүртээмжтэй болгох талаар ажиллаж байгаа. Хариу арга хэмжээ нь ихэвчлэн идэвхгүй буюу асуудал үүссэн үед л арга хэмжээ авдаг ба
- дижитал ядуурал, өгөгдлийн ядуурал, хөгжлийн бэрхшээл, сэтгэл мэдрэлийн ялгаатай байдал, сэтгэцийн эрүүл мэнд, хэл яриа болон бусад нийгмийн харилцаанд ороход тулгардаг асуудал сорилтуудтай холбоотой олон төрлийн хэрэгцээ, шаардлагын талаарх ойлголт хязгаарлагдмал байдаг.

### Тогтворжсон-Сайжирсан

- Тус байгууллага нь оюутны хотхон доторх болон гаднах олон янзын суралцагчдын холболтын хэрэгцээг хангах цогц арга барил боловсруулсан. Суралцагчдын янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээг тодорхойлж, үнэлэх тодорхой процессууд байдаг бөгөөд үүнд өгөгдөлд тулгуурласан дүгнэлт, тогтмол харилцан яриа, оюутнууд болон оролцогч талуудын санал хүсэлт зэрэг орно.
- Алсын зайнаас суралцагчдад зориулсан тусгай дэмжлэг үйлчилгээ байдаг бөгөөд, мөн олон төрлийн онлайн болон холимог сургалтыг санал болгодог.
- Сургалтын хэрэглэгдэхүүн болон дижитал платформыг бүтээхдээ янз бүрийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан үздэг ба тэгш оролцоо, тэгш хүртээмжийг байгууллагын үнэт зүйл, стратегид тусгасан.
- Салбарын түншүүд болон бусад байгууллагууд зэрэг олон оролцогч талуудтай хамтрах хамтын ажиллагаа нь суралцагчдын тодорхойлсон хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээг тасралтгүй сайжруулах, өргөжүүлэхэд чиглэдэг.



### Сайжирсан-Төлөвшсөн

- Суралцагчдын холбоо харилцааны хэрэгцээг тодорхойлох, үнэлэх дэвшилтэт арга зүй нэвтрүүлснээр хиймэл оюун ухаан, машин сургалт, урьдчилан таамаглах аналитик зэргийг ашиглан тогтмол харилцан ярилцах, санал хүсэлт авах боломж нэмэгдсэн.
- Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон үнэлсний үндсэн дээр дасан зохицох сургалтын систем, виртуал болон өргөтгөсөн бодит байдал, хиймэл оюун ухаанд суурилсан сургалтын аналитик зэрэг сургалтын шинэлэг арга, технологиуд ашиглан хувь хүнд чиглэсэн, хүртээмжтэй сургалт явуулах боломж бүрдсэн.
- Оюутнууд болон бусад сонирхогч талууд систем, үйлчилгээ, контент бүтээх, тасралтгүй сайжруулалт, инновацын соёлыг төлөвшүүлэхэд идэвхтэй хамтран оролцдог. Олон төрлийн суралцагчдын хэрэгцээг системтэйгээр тодорхойлж, үнэлэн, уг хэрэгцээ шаардлагыг хангахын төлөө тууштай ажиллах нь байгууллагын эрхэм зорилго, үнэ цэнд тусгасан гол үзэл санаанд бүрэн нийцнэ.
- Бүх оролцогч талууд систем, үйлчилгээнд нэвтрэн, ашиглахад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал хангагдсан байдаг.

# 89 Кибер аюулгүй байдлын хамгаалал, итгэмжлэл, дэмжлэг, протокол

**Гол чиглэл:**
Кибер аюулгүй байдал
Төлөвшлийн түвшинг сонгох:

## Эхлэл-Тогтворжсон

- Кибер аюулгүй байдлыг чухал хэмээн хүлээн зөвшөөрдөг бөгөөд дижитал хөрөнгө, сүлжээ, хэрэглэгчдийг хамгаалах аюулгүй байдлын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Cyber Essentials (Кибер суурь мэдлэг) гэрчилгээжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд аюулгүй байдлын үндсэн хяналтуудыг (firewall/галт хана, вирусны эсрэг программ хангамж, хандалтын хяналт зэрэг) хэрэгжүүлсэн.
- Кибер аюулгүй байдлыг хариуцсан баг, ажилтан байдаг болович багш, ажилтан, оюутнуудын дунд кибер аюулгүй байдлын мэдлэг, соёл хязгаарлагдмал байдаг. Кибер аюулгүй байдлын асуудал үүссэн тохиолдоход нь хариу арга хэмжээ авахад анхаардаг.

## Тогтворжсон-Сайжирсан

- Идэвхтэй арга хэмжээ авч, эрсдэлийн удирдлагад онцгой анхаарч, кибер аюулгүй байдлын цогц аргачлал хэрэгжүүлэн ажилладаг. Тус байгууллага нь ISO/IEC 27001, Cyber Essentials зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн кибер аюулгүй байдлын стандартуудыг дагаж мөрддөг бөгөөд халдлагыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх систем, шифрлэлт, олон давхар баталгаажуулалт зэрэг аюулгүй байдлын найдвартай хяналтыг хэрэгжүүлсэн.
- Байгууллагын зүгээс үүрэг, хариуцлагыг нь тодорхой зааж өгсөн, кибер аюулгүй байдлын тусгай баг ажиллуулдаг. Ажилтнууд болон оюутнуудад энэ чиглэлээр ойлголт өгөх сургалт, хөтөлбөрүүдийг тогтмол санал болгодог.
- Сүлжээг идэвхтэй хянаж, аюулгүй байдлын аудит, үнэлгээг тогтмол хийдэг. Байгууллага нь ослын эсрэг хариу арга хэмжээ авах тодорхой төлөвлөгөөтэй.



## Сайжирсан-Төлөвшсөн

- Кибер аюулгүй байдлын бат бөх соёл төлөвшсөн бөгөөд бүх түвшинд кибер аюулгүй байдлын ач холбогдлыг онцлон анхаардаг. ISO/IEC 27001 зэрэг кибер аюулгүй байдлын стандартуудыг дагаж мөрдөхөөс гадна Британий кибер эрсдэл, тэсвэрлэн сэргэх чадварын стандарт BS31111-ыг мөн дагаж мөрддөг. Cyber Essentials сертификатыг хадгалан үлдэх нь кибер аюулгүй байдлын цогц стратегийн үндэс суурь болдог.
- Тохиромжтой технологи, дэвшилтэт техник ашиглан дижитал хөрөнгө, сүлжээ, хэрэглэгчдийг хамгаалдаг.
- Тус байгууллага нь дээд боловсролын салбар дахь шинэ стандарт, туршлага, технологийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, кибер аюулгүй байдлын асуудлаар манлайлал үзүүлдэг. Тус байгууллагыг Кибер аюулгүй байдлын боловсролын эрдмийн төв хэмээн тодорхойлсон. Байнга хувьсан өөрчлөгдөж байдаг кибер аюул заналхийллийн сорилтыг даван туулахын тулд байгууллагын дотоодын мэргэжлийн үйлчилгээний багийн зүгээс Жанет сүлжээний мэдээлэлд тулгуурлан тухайн салбарт хамаарах үйлчилгээг үзүүлдэг. Тус баг нь ажил хэргийн харилцааны хүрээг тэлэх, хурал цуглаан зохион байгуулах, оролцох үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж, удирдан чиглүүлдэг.
- Тус байгууллага нь технологийн хөгжилтэй зэрэгцэн хувьсаж байдаг аюул заналд нийцүүлэн кибер аюулгүй байдлын арга хэмжээг байнга өөрчлөн, сайжруулдаг.
- Мөн салбарын түншүүд, судлаачид болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллаж (жишээ нь, Үндэсний Кибер аюулгүй байдлын төв), хиймэл оюун ухаанд суурилсан аюулыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах систем гэх мэт кибер аюулгүй байдлын шинэлэг шийдлүүдийг судалж, хэрэгжүүлдэг.

# Дижитал дэмжлэг

Оролцогч талуудад дижитал технологийг ажил, хичээл, судалгаа шинжилгээндээ үр дүнтэй ашиглахад нь туслах зорилгоор олгох нөөц, үйлчилгээ, тусламж.



## 90 Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг ажилд авах, тогвортой ажиллуулах

**Гол чиглэл:**
МТ дэмжлэг | Дижитал манлайлагчид | Дижитал сургалтын манлайлагчид | Сургалтын технологич | Дижитал чадавх | Ажилтнуудыг хөгжүүлэх

Төлөвшлийн түвшинг сонгох:

**Эхлэл-Тогтворжсон**

- Байгууллага нь дижитал мэдлэгтэй (жишээлбэл, МТ ба сүлжээ, кибер аюулгүй байдал, сургалтын технологи, мэдээллийн удирдлага, дижитаал хэлбэрт оруулах, архивлах, судалгааны технологи, өгөгдөл, аналитик гэх мэт) мэргэшсэн мэргэжилтнүүдтэй байхын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Ажилд авах, үлдээх зарим нэг үр дүнтэй журам хэрэгжиж байгаа. Стратеги болон/эсвэл шийдвэр гаргалтад нөлөөлөх нөөцийн хомсдол, ур чадварын хомсдол, боломж зэргээс шалтгаалан өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг татах, үлдээн ажиллуулахад саад учирч болзошгүй.

**Тогтворжсон-Сайжирсан**

- Тус байгууллага нь дижитал туршлагатай, өндөр ур чадвартай, мэргэшсэн боловсон хүчнийг ажилд авах, үлдээн ажиллуулахын чухлыг хүлээн зөвшөөрдөг. Уян хатан ажиллах боломж, өрсөлдөхүйц цалин хөлс гэх мэт ажилчдыг татах, тогтвортой ажиллуулах нөхцөлүүдийг санал болгодог. Өндөр мэргэшсэн ур чадвар, мэдлэгийг байгууллага даяар үнэлдэг. Мэргэшсэн гадны зөвлөхүүдийг тодорхой төслүүдэд ажилуулах боломжтой.

**Сайжирсан-Төлөвшсөн**

- Байгууллага нь өндөр ур чадвартай, дижитал туршлага бүхий мэргэшсэн ажилтнуудын дижитал шилжилтэд оруулж чадах үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, шилдэг боловсон хүчнийг татах, тогтвортой ажиллуулахын тулд ажилд авах, үлдээх, хөгжүүлэх стратегийн, шинэлэг хандлагыг баримталдаг.
- Төрөл бүрийн дижитал тусламжийн багуудын ахлах ажилтнууд байгууллагын стратеги, бодлого тодорхойлох, мэдээллийн удирдлага, сургалт, судалгааны ажилд шинийг санаачлан нөлөөлөхөд идэвхтэй оролцдог.

## 91 Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх, сургах

**Гол чиглэл:**

МТ дэмжлэг | Ажилтныг хөгжил

Төлөвшлийн түвшинг сонгох:

